

ТӨРИЙН БАЙГУУЛАЛ СУДЛАЛ

№06

Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сан
Монгол Улсын Их Сургуулийн Улс төр судлал,
Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын сургууль

SGAP
Governance, Administration, Politics
Засаглал, Удирдлага, Улс төр

Улаанбаатар
2024

ТӨРИЙН БАЙГУУЛАЛ СУДЛАЛ СЭТГҮҮЛ №06

§GAP

Governance, Administration, Politics
Засаглал, Удирдлага, Улс төр

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ:

Профессор С.Мөнхбат	МУИС-ийн УТСОУХНУС-ийн захирал
Профессор Ж.Төртогтох	МУИС-ийн УТСОУХНУС-ийн Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч
Дэд Профессор Г.Баасанжав	МУИС-ийн УТСОУХНУС-ийн Нийтийн удирдлагын тэнхимийн эрхлэгч
Виктор Франк	Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сангийн Суурин төлөөлөгч
С.Ганзаяа	Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сангийн хөтөлбөрийн менежер
Ерөнхий редактор:	Доктор П.Амаржаргал

Зохиогчийн эрх ©Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сан
Энэхүү бүтээлийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан тул эшлэл авалгүйгээр хуулбарлах, олшруулах, хэсэгчлэн авах, ашиглах хэвлэн нийтлэхийг зохиогчийн эрх зөрчсөнд тооцно. Бүтээлд нийтэлсэн материалын агуулга, мэдээллийн үнэн зөвийг зохиогчид хариуцна.

"Адмон-принт" ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

АГУУЛГА:

МЭНДЧИЛГЭЭ.....	4
ӨМНӨХ ҮГ.....	5
Д.МЯГМАРСҮРЭН.....	6
СУПЕР СОНГУУЛИЙН ЖИЛ: ДЭЛХИЙ ДАХИН БА МОНГОЛД	
Ж.ТӨРТӨГТОХ, Г.ТУЯАГЭРЭЛ.....	19
УЛС ТӨРИЙН СОНГОЛТОД НӨЛӨӨЛӨХ НЭР ДЭВШИГЧТЭЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ	
Г.БААСАНЖАВ.....	35
СОНГУУЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, УДИРДЛАГА	
О.ХАТАНБОЛД, Д.УРТНАСАН.....	42
СОНГОГЧДЫН УЛС ТӨРИЙН СОЁЛЫН ХАНДЛАГА	
У.БАТЦЭРЭН.....	54
МОНГОЛ ДАХЬ СОНГУУЛИЙН КАМПАНИЙН ТЕХНОЛОГИ БА ИМИЖ БҮРДҮҮЛЭЛТ	
Т.ТУЯАЧИМЭГ.....	59
ЗАЛУУ, ШИНЭ НЭР ДЭВШИГЧДЭД ТУЛГАМДАХ АСУУДЛУУД	
О.АРИУНБИЛЭГ.....	68
УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ	
УЛС ТӨРИЙН НАМУУДЫН БАЙР СУУРЬ: ЯРИЛЦЛАГА	
АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА Л.ГАНТӨМӨР.....	78
"АЛС ХЭТДЭЭ АРДЫН НАМ, АРДЧИЛСАН НАМ ГЭСЭН ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ХОЁР ТОМ НАМЫН ХООРОНД ҮЗЭЛ САНААНЫ ӨРСӨЛДӨӨН ЯВАГДАХ БОЛОМЖТОЙ ГЭЖ ХАРЖ БАЙНА"	
ХҮН НАМЫН ДАРГА Т.ДОРЖХАНД.....	85
"ЭНЭ УДААГИЙН СОНГУУЛЬ ХУВЬ ХҮМҮҮСИЙН ГЭХЭЭСЭЭ ИЛҮҮТЭЙ БОДЛОГЫН ИНСТИТУЦ ХООРОНДЫН ӨРСӨЛДӨӨН БАЙХ БОЛНО"	

МЭНДЧИЛГЭЭ

Хүндэт уншигчид аа.

“Төрийн байгуулал судлал” сэтгүүлийн шинэчилсэн хувилбарыг та бүхэнд толилуулж байгаадаа баяртай байна.

Сэтгүүл инновацлаг хэлбэрээр баяжигдан хэвлэгдэж байгаа нь Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сан (КАС) болон Монгол Улсын Их Сургуулийн (МУИС) амжилттай, сайн хамтын ажиллагааны үр дүн юм. Сэтгүүлийн шинэлэг хэлбэр нь шинжлэх ухаан, улс төр, нийгмийг холбосон гүүрийг бий болгож, судлаачдын шинжлэх ухааны үндэслэлтэй санал зөвлөмж болон улс төрийн практикийг хослуулсан платтформыг үүсгэж байгаа нь онцлог юм.

“Төрийн байгуулал судлал” сэтгүүл нь мэргэжлийн салбартаа эрэлт хэрэгцээ өндөртэй эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл байсан нь бид үндсэн агуулгыг технологийн эрин үед илүү хүртээмжтэй байлгаж, олон нийт нийтлэгдсэн мэдээ, мэдээллийн талаар хамтран хэлэлцэж ярилцахад улам бүр түлхэц болох юм. Сэтгүүлийн шинэчлэл нь шинжлэх ухаан, улс төр, нийгэм, эдийн засгийн хэтийн төлөвийг тоймлон, цаг үеийн сэдвүүдийг мэргэжлийн хэллэг ашиглахгүйгээр танилцуулж байхыг зорьж байна. МУИС-ийн УТСОУХНУС болон КАС-ийн төлөөллөөс бүрдсэн манай редакцын баг нийтлэл, агуулгыг мэргэжлийн түвшинд, уншигчдад хүртээмжтэй байлгаж, улс төр, нийгмийн оролцогч талуудын санал, хүсэлтийг үргэлж нээлттэй хүлээн авах юм.

GAP сэтгүүлийн энэ дугаарт бид “Сонгууль” хэмээх цаг үеийн сэдвийг онцолж байна. Энэ удаагийн дугаарт хууль, эрх зүйн зохицуулалт, сонгуулийн кампанит ажлын технологос эхлээд парламентын гишүүдийн тоог нэмэгдүүлэх нь төлөөллийн ардчилалд үзүүлэх нөлөөлөл хүртэлх сонгуулийн үйл явцын олон асуудлыг авч үзлээ. “Сонгууль”-ийн талаарх сэдвийг цогцоор нь харуулахын тулд манай судлаач, мэргэжилтнүүд олон улсын сонгуулийн төлөв байдал, цаашдын хандлага, сүүлийн үеийн судалгаа, мэдээ мэдээллийг тоймлон харуулжээ. Сэтгүүлийн нийтлэлүүдийн агуулга нь ардчилсан нийгэм, түүний сонгуулийн талаарх уншигчдын мэдлэгийг гүнзгийрүүлэхэд хувь нэмэр болно хэмээн найдаж байна.

КАС-ийн Суурин төлөөлөгч Виктор Франк

ӨМНӨХ ҮГ

“Төрийн байгуулал судлал” эрдэм шинжилгээний сэтгүүлийн ээлжит 6 дахь дугаарыг Уншигч Танд тус сэтгүүлийн редакцын зөвлөлөөс өргөн барьж байна.

МУИС-ийн Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн Улс төр судлалын тэнхим ба Монгол Улс дахь ХБНГУ-ын Конрад Аденауэрын Сангийн суурин төлөөлөгчийн газрын харилцаа, хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд тус эрдэм шинжилгээний сэтгүүлийг нийгэм, улс төр судлал, төрийн захиргаа, төрийн бодлого, удирдлагын салбарын өргөн хүрээг хамарсан эрдэм шинжилгээ, судалгааны үр дүн бүхий өгүүлэл, нийтлэлийг хэвлэн нийтлэх зорилготойгоор хамтран эрхлэн гаргадаг билээ.

“Төрийн байгуулал судлал” сэтгүүлийн энэхүү ээлжит дугаарт орсон өгүүлүүд нь сонгуулийн сэдвээр дагнан бичсэн судлаачдын өгүүлэл, улс төрийн зарим намын удирдлагын байр суурь, үзэл бодол зэргийг тусгасан ярилцлага зэргээс бүрдсэн гэдгийг онцолж байна.

Энэ удаагийн дугаарт орсон дэлхий дахинд ба Монгол Улсад 2024 онд болж буй болон болох сонгуулиудын ерөнхий төлөв байдал, улс төрийн сонголтонд нөлөөлөх нэр дэвшигчдийн хүчин зүйлс, сонгуулийн зохион байгуулалт, удирдлага, сонгогчдын улс төрийн хандлага, сонгуулийн кампанийн технологи ба имиж, залуу болон шинэ нэр дэвшигчдэд тулгамдаж буй асуудлууд, УИХ-ын сонгуулийн тухай хуульд холбогдох зарим асуудал зэргийг хөндсөн бөгөөд тухайн зохиогчдынхоо үзэл бодол, итгэл үнэмшил, судалгааны сонирхол, үр дүнг илэрхийлсэн гэдгийг тунгаан үзвэл зохилтой.

Бид цаашид төрийн байгууллын институтуудын талаарх болон нийгэм, улс төр судлал, төрийн захиргаа, удирдлагын чиглэлээрх судалгаа, шинжилгээний үр дүн бүхий эрдэм шинжилгээний өгүүлүүдийг хүлээн авч, хэвлэн нийтлэх болно.

Уншигч Таны эрдмийн ажил үйлст өндөр амжилт хүсэн ерөөе.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

СУПЕР СОНГУУЛИЙН ЖИЛ: ДЭЛХИЙ ДАХИН БА МОНГОЛД


Доктор Д.Мягмарсүрэн

ШУТИС-ийн Хүний нөөцийн албаны дарга

Дэлхий дахины сонгуулийн эргэн тойронд

Дэлхий дахины улс төрийн хуанлид 2024 он бол үйл явдал, өрнөл ихтэй жил гэдгээрээ онцлог. Олон улс оронд улс төрийн сонгууль явагдаж, засгийн эрх солигдох, улмаар үр дагавар нь дэлхийн улс төр, эдийн засагт чухал нөлөө үзүүлэх талаар олон улсын ажиглагч, судлаачид байр сууриа илэрхийлж байна.


Товчхондоо энэ онд дэлхийн 64 улсын 4 тэрбум хүн ам (дэлхийн хүн амын 49%)-ыг хамарсан үндэсний хэмжээний сонгууль явагдана. Дэлхийн түүхэнд ийнхүү олон сонгууль давхцах тохиолдолд нэн ховор учраас энэ жилийг “Супер сонгуулийн жил” хэмээн нэрлэж буй бөгөөд 2048 оноос өмнө дахин тохиохгүй хэмээн АНУ-ын Integrity institute судалгааны хүрээлэн мэдээлжээ [1]. Нийтдээ дэлхий дахинд 2 тэрбум хүн саналаа өгөх бөгөөд үүнээс хамгийн том хэмжээний сонгууль нь Энэтхэгт 900 сая гаруй сонгогч дараагийн төрийн тэргүүнээ сонгох эрхээ эдлэх бол хамгийн цөөн сонгогчтой улсын нэг болох Тувалу Улсын парламентын сонгуульд өнгөрсөн 1-р сард 10 мянган сонгогч саналаа өгсөн ажээ. Юуны өмнө өнгөрсөн хугацаанд явагдсан онцлох сонгуулийг тоймлоё. 2024 оны 1-р сард Тайвань, Бангладешид үндэсний хэмжээний сонгууль явагдаж,



Зураг 1. Супер сонгуулийн жилийн газрын зураг. 75 хувь нь чөлөөт болон хагас чөлөөт хэлбэрээр явагдана. Эх сурвалж: Statista research.

Тайванд зүүн төвийн үзэлтэй Ардчилсан дэвшилт намаас тусгаар тогтнолын талыг баримтлагч Лай Чин Тэ ерөнхийлөгчөөр сонгогдсон бол Бангладеш Улсад хэл ам, бужигнаантай өрнөсөн сонгуулиар Ерөнхий сайд Шейх Хасинагийн

нам үргэлжлүүлэн 5 жил засгийн эрх барихаар болсон юм. Мөн Пакистанд 2 жил үргэлжилсэн улс төрийн үймээн самууны эцэст өнгөрсөн 2-р сард явагдсан парламентын сонгуулиар интернэт сүлжээг бүхэлд нь тасалж, сонгуулийн дүн зарлахгүй олон хоног сунжран, сөрөг хүчин гудамжинд жагссаны эцэст эвслийн засгийн газар байгуулахаар улс төрийн хүчнүүд тохиролцоонд хүрсэн тухай олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээлж байв. Индонезид 2-р сард явагдсан Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч, Парламент, орон нутгийн сонгуулийн дүн гарч, Батлан хамгаалахын сайд асан Прабово Субианто ялсныг олон улсын хүний эрхийн байгууллагууд болон тус улсын сөрөг хүчин болон залуучууд шүүмжлэн, авторитар дэглэм дахин тогтох нь хэмээн эсэргүүцлээ илэрхийлж байлаа.



Зураг 2. Индонезийн 2-р сарын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэлийг хангах зорилгоор сонгуулийн хэсгийн ажилтнууд агуулахад саналын хайрцгуудыг өрж байгаа нь. Тус улсад 200 сая гаруй иргэн сонгуулийн жагсаалтад бүртгэгдсэн байдаг. Эх сурвалж: AFP

Манай хойд хөрш ОХУ-д 3-р сард явагдсан Ерөнхийлөгчийн сонгуульд 4 нэр дэвшигч оролцсон байна. 2021 онд ОХУ-ын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтөөр сонгогдох эрхээ дахин сунгасан Ерөнхийлөгч В.Путинаас гадна “тавиул” нэр дэвшигч ЛДПР намын дарга Леонид Слуцкий, Төрийн Думын дэд дарга, “Шинэ ард түмэн” намын гишүүн Владислав Даванков, Төрийн Думын депутат (Коммунист намын фракц) Николай Харитонов нар өрсөлдсөнөөс В.Путин сонгогчдын 87.2%-ийн саналаар 5 дахь удаагаа Ерөнхийлөгчөөр сонгогдов. Энэ удаагийн сонгуульд саналыг цахимаар өгөх боломжийг олгосноос гадна В.Путин бие дааж нэр дэвшсэн, сөрөг хүчний төлөөлөгч, “Иргэний санаачилга” намаас нэр дэвшихээр горилогч Б.Надеждин шаардлагатай дэмжигчдийн гарын үсгийн шаардлага хангаагүй гэх шалтгаанаар хасагдсан зэрэг үйл явдал өрнөв. Санал хураалтын өдөр сонгуулийг эсэргүүцсэн жагсаал ОХУ болон бусад орнуудад

өрнөж, санал хураах байранд гал тавих, саналын хайрцгийг шатаах, будаг асгах, саналын хуудсан дээр “Путин бол алуурчин” гэж бичих зэргээр эсэргүүцлийн шинжтэй үйлдлүүд гарсан юм. АНУ, Их Британи, Польшийн Засгийн газраас ОХУ-ын сонгуулийг ардчилсан бус гэж үзсэн төдийгүй Германы тал хууль бус сонгууль болсон тул цаашид Ерөнхийлөгч гэсэн тодотгол хэрэглэхгүй Путин гэж нэрлэх тухайгаа мэдэгдэв. Дашрамд хэлэхэд сонгуулиас нэг сарын өмнө оросын сөрөг хүчний зүтгэлтэн, хүний эрхийн төлөө тэмцэгч А.Навальный шоронд амь насаа алдсан явдлыг Путины сонгуулийн ажиллагаанд нөлөөлнө гэж үзсний улмаас зориудаар хөнөөсөн хэмээн олон улсын ажиглагчид таамаглаж байлаа.

3-р сарын сүүлийн 7 хоногт Туркэд явагдсан орон нутгийн сонгуулийн дүн гарч сөрөг хүчний Бүгд найрамдахчуудын ардын нам засаг захиргааны 81 нэгжийн 36-д нь ялалт байгуулсан байна. Ялангуяа Истанбул, Анкара, Измирийн орон нутгийн удирдах эрхээ сунгасан явдлыг эрх баригч Эрдоганы хувьд төрийн эрхэнд 2002 онд гарснаас хойшхи хамгийн том ялагдал нь боллоо хэмээн ажиглагчид үзэж байна [2]. Сонгуулийн дараахан болсон харамсалтай үйл явдал бол ялалт байгуулсан намын дэд дарга ялалтын баяраа тэмдэглэж байх үед тагт нурсны улмаас унаж амь эндсэн байна.

2024 оны эхний улиралд дээр дурдсан улс орнуудаас гадна Беларусь, Сенегал, Коста Рика, Эл Салвадор, Доминикан, Ямайка, Камбож, Иран, Израил, Хойд Солонгос, Португали, Словак, Турк зэрэг улсад сонгууль явагдсан.

Үлдсэн хугацаанд Европын парламент, АНУ, Энэтхэг, Их Британи, Мексик зэрэг томоохон улс орнуудад сонгууль явагдана. Ялангуяа АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн хэрхэн гарснаас тухай улсын төдийгүй дэлхий дахины ардчиллын хувь заяа, дэлхийн улс төр, геополитикийн нөхцөл хаашаа эргэх нь шийдэгдэнэ хэмээн судлаачид таамаглаж байна.

Монголын улс төр, эрх зүйн тогтолцооны өөрчлөлт ба шинэ сонгууль

Монгол Улсын хувьд 2024 оны 6-р сард УИХ-ын ээлжит сонгууль нь Үндсэн хууль болон бусад холбогдох хуулийн шинэчлэл, эрх зүйн тогтолцооны өөрчлөлтийн дараагаар явагдаж буйгаараа онцлог юм. Тэдгээр шинэчлэл, өөрчлөлтийг дараах түвшингээр 3 ангилан үзэж болно. Үүнд:

1. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд хийгдсэн шинэчлэл;
2. Улс төрийн институт, коммуникацийг зохицуулдаг хуулийн шинэчлэл өөрчлөлт;
3. Сонгуулийн эрх зүйн акт, баримт бичгийн өөрчлөлт.

Дээрх ангиллын дагуу энэ удаагийн сонгуульд ямар өөрчлөлт тусгагдсаныг дэлгэрэнгүй авч үзье.

1992 оны Монгол Улсын ардчилсан Үндсэн хуульд тухайн үеийн сонгуулийн насны иргэдийн тоонд үндэслэн нэг гишүүн 15-20 мянган сонгогчийг төлөөлөх нь оновчтой гэж үзэж 76 гишүүнтэй байхаар тогтсон байдаг. Хүн амын тоон өсөлттэй уялдуулах, төлөөллийн зарчмыг илүү сайн хангуулах, хууль боловсруулах, тогтоох чадамжийг өсгөх, парламентад ёсыг бэхжүүлэх зорилгоор гишүүдийн тоог нэмэх шаардлага үүссэн хэмээн үзсэн тул 2023 онд байгуулагдсан Үндсэн Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн ажлын хэсгээс гишүүдийн тоог хоёр дахин нэмэх буюу 152 болгох саналыг дэвшүүлсэн байна. Мөн хууль тогтоох байгууллагад нийт иргэдийн төлөөлөл болон газар нутгийн төлөөллийг хангаж чадахуйц сонгуулийн холимог тогтолцоог Үндсэн хуульд тусгах шаардлагатай гэж тооцсоны үндсэн дээр 76 нь мажоритар, 76 нь намын жагсаалтаар сонгох хувилбарыг бэлтгэсэн аж. Гэвч парламентын гишүүдийн тоог нэмэхтэй холбоотой асуудалд олон нийтийн дургүйцлээс шалтгаалан 50-иар нэмж, 126 гишүүнтэй байхаар эцэслэв. Тэрчлэн болон бусад нам хүчинтэй хийсэн зөвшилцлийн үр дүнд 78 гишүүнийг мажоритар буюу олонхийн саналаар, 48 гишүүнийг пропорционал хэлбэрээр буюу нам, эвслийн жагсаалтаар сонгох хувилбар дээр тогтоож 2023 оны 5-р сарын 31-ны УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан билээ.

2020 онд бүрэлдсэн УИХ-ын хийсэн нэг том алхам бол олон жил сунжран хэлэлцэгдсэн Улс төрийн намын тухай хуулийг шинэчилсэн явдал юм. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан боловсруулж, УИХ-аас 2023 оны 7-р сарын 7-нд баталсан Улс төрийн намын тухай (шинэчилсэн найруулга) хуульд хэд хэдэн онцлог заалт тусгагдсан. Урьд нь зөвхөн УИХ-д суудалтай нам хүчнүүдэд төрөөс санхүүжилт олгодог байсан бол шинэ хуулиар сонгуулиар нэгээс дээш хувийн санал авсан нам, эвсэлд төрийн санхүүжилт олгохоор болсон. Тэрчлэн намын байгууллагын хурал, уулзалт зохион байгуулах, намын хөтөлбөр, үйл ажиллагааг олон нийтэд хүргэхэд зориулан танхим заалыг үнэ төлбөргүй ашиглуулах, олон нийтийн радио, телевизийн цаг гаргах зэрэг шууд бус дэмжлэгийг ч хуулиар зохицуулж өгсөн байна. Хуулийн шинэчлэлд нас, хүйс, нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангах боломжийг нэмэгдүүлэх болон намын үйл ажиллагааг цахимаар явуулах, ил тод байдлыг хангах, санхүүжилтийн тайлангийн хяналтын асуудлыг нарийвчлан тусгах зэрэг цаг үеийн шинжтэй өөрчлөлтийг шинээр оруулжээ [3].

Дээрх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон Улс төрийн намын тухай хуулийн өөрчлөлттэй нийцүүлэн Сонгуулийн тухай хуульд холбогдох өөрчлөлтийг хийсэн байна. Сонгуулийн тухай хуульд нам эсвэл нийт саналын 4-өөс дээш хувийн санал, 2 нам бүхий эвсэл 5 хувийн санал, гурав буюу түүнээс дээш нам бүхий эвслийн хувьд 7 буюу түүнээс дээш хувийн санал авах босгыг тус тус

тусгасан байна. Өөрөөр хэлбэл, сонгуульд 1.6 сая иргэн саналаа өгөх гэж тооцвол 4 хувь буюу 64 мянган санал, 2 намын эвсэл 80 мянган санал, 3 намын эвсэл 112 мянган санал авснаар сая УИХ-д суудалтай болох юм [4]. Жижиг намууд эвсэж 5 болон 7 хувийн босго давах нь амаргүй, тэрчлэн төрөөс олгох санхүүжилтийг бусадтай хуваалцахгүйгээр хүртэх сонирхлоос үүдэн 2024 оны сонгуульд дийлэнх намууд дангаараа, 2 эвсэл л өрсөлдөхөөр мөрийн хөтөлбөрөө бүртгүүлсэн байна.

Мөн УИХ-ын сонгуулийн тухай хуулиар сурталчилгааны хувьд нэр дэвшигчид тус тусдаа биш нэгдсэн том самбарт зургаа үнэ төлбөргүй байршуулах, хоёр хуудастай сонин, сэтгүүл, нэг хуудастай ухуулах хуудас тараах, цахим сувгаар сурталчлах бол Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх, нам эвсэл, нэр дэвшигчид ажиллах ухуулагч нь хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээний 50 хувиас хэтрэхгүй буюу 330 мянган төгрөгийн хөлсөөр ажиллах гэх мэт зохицуулалтаар дамжуулан сонгуулийн зардал, мөнгө санхүүгийн өрсөлдөөнийг УИХ-ын сонгуулийн тухай хуулиар хязгаарлахыг зорьжээ.

Харин сонгуулийн тойргийн зохион байгуулалт, мандатын тоог УИХ-аар 2023 оны эцсээр хэлэлцэж, сонгуулийн тойргийг орон нутагт аймгуудыг нэгтгэн



Зураг 3. 2020 оны сонгууль хүртэл сурталчилгааны ийм самбарыг хөдөө хотгүй олноор нь байрлуулдаг байв. Хуулийн шинэ зохицуулалтаар хойшид ийм самбар байрлуулахыг хязгаарлав.

бүсчилж 7, нийслэл Улаанбаатарт 6, нийт 3-10 мандат бүхий томсгосон 13 тойрогтой байхаар УИХ-ын тогтоол гарав [5]. Үндэсний аудитын газраас нам, эвслийн сонгуульд зарцуулах дээд хэмжээ 6.4 тэрбум, тойрогт нэр дэвшигчийн зардлыг 895.0 саяас 1.5 тэрбум төгрөг байхаар тогтоож өгсөн.

Хууль санаачлагчдын зүгээс энэхүү бүсчилсэн хуваарилалтыг Монгол Улсын улс төрийн шинэчлэл төдийгүй бүсчилсэн хөгжлийг хангах, жалга довны үзлийг арилгах, клиенталист өрсөлдөөн хязгаарлагдахад чухал ач холбогдолтой зохицуулалт болсон гэж үзэж байгаа.

Гэсэн хэдий ч улс төр судлаачид, зарим сөрөг хүчний зүгээс бүсчилсэн тойрог хэмээх ойлголт байдаггүй бөгөөд холимог хэлбэрээр, олон мандаттай



Зураг 4. 2024 оны УИХ-ын сонгуулийн тойргийн хуваарилалт болон мандатын тоо.
Эх сурвалж: СЕХ [6]

тойргийн сонгуулийн хуудас нүсэр, ойлгомжгүй болох, сонгуулийн 17 хоногийн сурталчилгаа нь богино учраас жижиг намын болон шинэ нэр дэвшигчдийн хувьд өөрийгөө таниулах боломжийг хязгаарласан зэрэг шалтгаанаар эрх баригч намд ашигтай сонгуулийн тогтолцоо болсон хэмээн шүүмжилж байна.

Энэ удаагийн сонгуульд УДШ-д бүртгэлтэй 35 намаас 4 нь сонгуульд оролцохооргүй болж, 27 нам, хоёр эвсэл, нийт 29 субъект оролцохоо илэрхийлж, мөрийн хөтөлбөрөө Үндэсний аудитын газарт хүргүүлсэн байна. УИХ-ын гишүүдийн тоо өссөн, сонгуульд өрсөлдөх намууд 78 суудлын 50 хувиас дээш хувьд нэр дэвшүүлэх зэрэг шаардлагаас шалтгаалан намын жагсаалтаар болон тойрог дээр нийтдээ 2500-3000 нэр дэвшигчтэй нүсэр сонгууль болно хэмээн таамаглаж байна.

Сонгууль ба улс төрийн дэглэм

Дэлхий даяар өрнөж буй сонгууль нь тэр чигтээ ардчиллын нотолгоо болж чадахгүй юм. Ардчилсан засаглалтай, сонгуулийг чөлөөт бөгөөд шударгаар явуулж буй улс орнуудын зэрэгцээ засгийн эрх мэдлээ хадгалах, хангах зорилгоор тоглоомын сонгууль дэглэж буй улс орнууд цөөнгүй байна. Ардчилал билэгдлийн төдий оршдог, ор нэр төдий сонгуулийн тогтолцоотой, чөлөөт хэвлэл хомс, төрөөс хүний эрхийг зөрчихдөө гаршсан, улс төрийн бодит өрсөлдөөнгүй, өрсөлдөгч гараад ирвэл цагдаа хүчний байгууллагаар ил болон далд явууллагаар замаасаа зайлуулчихдаг эрлийз дэглэмийг “өрсөлдөөнт авторитар” (competitive authoritarianism) тогтолцоо хэмээн нэрлэдэг. “Freedom house” ОУ-ын байгууллагын 2023 оны “Дэлхийн эрх чөлөө”-ний тайланд үзүүлэлт нь буурсан

52 орны тал нь сонгуулийн манипуляцид автсан буюу хуурмаг сонгуультай гэж тооцогдсон байдаг [7]. Эрх чөлөөгүй хэмээх ангилалд багтсан тэдгээр улс орнууд дотор өнгөрсөн жил сонгууль нь явагдсан Турк, Камбож, Зимбабве зэрэг улс багтсан бөгөөд энэ жилийн хувьд хэл ам дагуулсан сонгуультай Бангладеш, Индонез, Пакистан гэх мэт улс энэхүү жагсаалтад нэмэгдэн орох нь дамжиггүй биз ээ.



Зураг 5. Бангладеш Улсад 1-р сард явагдсан парламентын сонгуулийн санал хураалтын өмнө нь сөрөг хүчний идэвхтэн, дэмжигчид чөлөөт, шударга сонгууль явуулахыг шаардаж сонгуулиар бойкот хийхийг уриалж Дака хотын гудамжинд жагсаал хийж байгаа нь. Эх сурвалж: Altaf Qadri/AP Photo

Мэдээж ардчиллын урт хугацааны уламжлал, туршлагатай улс орнуудад чөлөөт, шударга сонгууль явагдаж буй бөгөөд гол эрсдэл нь гадаадын хүчнүүдээс улс төрийн үйл явцад мэдээллийн хэрэгсэл, технологиор дамжуулан нөлөөлөхөөр оролдох нөхцөлийг хэрхэн шийдвэрлэх бодлого, арга механизмыг боловсруулан хэрэгжүүлж байна. Энэ тухай доор дэлгэрэнгүй өгүүлнэ.

Технологийн шилжилт ба ардчилсан үйл явцад учирч буй сорилтууд

Улс төрийн нам хүчин, улс төрчдөөс иргэд сонгогчидтой харизм, бодлого, мөрийн хөтөлбөр (*programmatic*), клиенталист гэсэн гурван холбоосоор холбогддог тухай 2000 оны эхээр АНУ-ын улс төр судлаач Х.Китчелт холбоо харилцааны сонголтын онолоороо анх дэвшүүлсэн байдаг. Сүүлийн жилүүдэд мэдээллийн технологийн хөгжил дэвшилтэй холбоотойгоор тоон болон цахим

хэрэгсэл нь улс төрийн манлайлагч болон сонгогчдыг холбох чухал талбар болсон тухай судлаачид санал дэвшүүлэх болсон. Өөрөөр хэлбэл, дөрөв дэх холбоосыг хэн үр дүнтэй ашиглан тэр сонгуульд ялах магадлалаа өсгөх боломж нээгдэнэ гэсэн үг [8].

Орчин үеийн технологийн дэвшил нь иргэдийн улс төрийн болон сонгуулийн оролцоог нэмэгдүүлэх, хөнгөвчлөх, өрсөлдөөний ил тод байдал, мэдээллийн эх сурвалжийн олон талт байдлыг тэлэх зэрэг ардчилсан үйл явцыг өргөжүүлэх боломжийг нээж өгсөн. Нөгөө талаар ардчилсан үйл явцыг хязгаарлах, улс төрийн шударга өрсөлдөөн, ил тод байдлыг зогсоохын тулд эрх баригч хүчнүүд интернэт хандалтыг хязгаарлахаас аваад бүрмөсөн хаах, таслах, төрийн үзэл суртлын үр дүнтэй хэрэглүүр болгох явдал улам бүр өргөжиж байна. “Access Now” төрийн бус байгууллагын мэдээлснээр 2021 онд 29 улсад интернэтийг хаасан байдаг бөгөөд ийм үйлдэл нэг удаа хийсэн Засгийн газар дахин хийх магадлал өсдөг аж. Интернэтийг хязгаарладаггүй юмаа гэхэд хуурамч, өрөөсгөл мэдээллээр иргэдийг санаатайгаар төөрөгдүүлэх, улс төрийн шуугиан тарих, мэдээллийн дайн өрнүүлэх нь нийгмийн сүлжээний мэдээлэлд үл итгэх, залхах хандлагыг бий болгож, улмаар ардчилалд аюул заналхийлэл учруулж байна [9].

Дээр дурдсанчилан улс төр, геополитикийн өрсөлдөөний үүднээс дотоод улс төрийн үйл явцад нь нөлөөлөх, мэдээллийн дайн өдөөх замаар өөрт ашигтай нөхцөлийг хангахын тулд мэдээллийн технологи, виртуал сувгуудаар дамжуулан иргэдийн санаа бодлыг үймүүлэх, өдөөн хатгах, улс үндэстнийг хуваан талцуулах, өөрийн талын улс төрийн хүчин, улс төрчдийг засгийн эрхэнд гаргах зэрэг улс орны аюулгүй байдал, ардчилсан хөгжилд заналхийлэх боломжийг дарангуйлалт улс орнууд овжиноор ашиглаж байгаа нь ардчилсан орнуудад томоохон сорилт болж байна. Тухайлбал, суртал ухуулгын кампанит ажилд хиймэл оюун ухааныг ашиглахад Хятад улс тэргүүлж байгаа тухай Энэтхэгийн “Observer Research Foundation” байгууллагын шинжээчид дүгнэжээ. Улмаар 2030 он гэхэд энэхүү салбарт тэргүүлж, цэрэг дайны зорилгоор хүч хэрэглэхгүйгээр дайсныхаа танин мэдэхүйн чадварыг онилон, номхотгоход чиглэсэн “мэдээлэлжсэн дайн” үзэл баримтлалыг хөгжүүлж байгаа гэнэ. Тайванийн Үндэсний аюулгүй байдлын товчооны ерөнхий захирал Цай Минг-Йен Хятадын Коммунист Намаас “deepfake”-д тулгуурлан Тайванийг “танин мэдэхүйн дайны талбар” болгон эмх замбараагүй байдал үүсгэж болзошгүйд санаа зовниж буйгаа илэрхийлсэн байдаг [10]. Улс төрийн тоглогчид дотооддоо зорилго, хөтөлбөрөө иргэддээ түгээхээс аваад дайсагнагч улсууд “хосолмол дайн” буюу “саарал бүсийн арга тактик” ашиглах энэхүү үзэгдлийг Европын холбооноос “гадаад мэдээллээр төөрөгдүүлэх хөндлөнгийн оролцоо” (foreign information manipulation interference (FINI)) гэж нэрийджээ [11].

Дан ганц ардчилсан бус улс орнуудад нийгмийн сүлжээний талбарыг сөрөг байдлаар ашиглах тухай ярих нь өрөөсгөл юм. 2018 онд Лондонд төвтэй “Кембриж Аналитика” компани 80 гаруй сая хэрэглэгчийн хувийн мэдээллийг хууль бусаар авч, АНУ болон бусад 200 гаруй орны сонгуульд тусгай алгоритмаар дамжуулан фэйсбүүк хэрэглэгчдийн улс төрийн үзэл санаа, итгэл үнэмшлийг өмнөөс нь тодорхойлж, улс төрийн төөрөгдөл үүсгэж байсан нь тогтоогдсон билээ [12].

“Deepfake” технологи буюу хиймэл оюун ухаан ашиглан нийгмийг төөрөгдүүлэх зорилготой хуурамч мэдээлэл, зохиомол контент, видео болон аудио бичлэг, дуу хоолой, зураг дүрс нь улс төрийн шударга өрсөлдөөний томоохон сорилт болоод байна. Тухайлбал, 2019 онд Габоны ерөнхийлөгч Али Бонгогийн эрүүл мэнд ноцтой байдалд орсон тухай хуурамч бичлэгээр дамжуулан цэрэг армийг төрийн эргэлт хийхийг ятгах оролдлого гарсан [13], мөн онд Италийн Ерөнхий сайд асан Маттео Рензи хошин шогийн нэвтрүүлэгт оролцож, улс төрийн хамтрагчдаа доромжилсон агуулгатай видео тархаж, олон нийтийг шуугиулсан ч удалгүй хуурамч бичлэг болох нь илэрсэн, 2022 оны 3-р сард Украины Ерөнхийлөгч В.Зеленский цэргүүдээ бууж өгөхийг ятгаж буй бичлэг цахим орчинд тархсан зэрэг хиймэл оюун ашиглан хэт хуурамч мэдээлэл тарааж буй тохиолдлын жагсаалт дуусахгүй үргэлжилнэ. Монгол Улс ч энэхүү асуудлыг тойрсонгүй. Өнгөрсөн оны 11-р сард Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх хятад хэлээр ярьсан хуурамч бичлэг нийгмийн сүлжээнд цацагдсаны дараагаар цагдаагийн байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулж, Монголын хоёр иргэнийг баривчлахад хүрсэн билээ.



Зураг 6. 2022 онд Украины Ерөнхийлөгч В.Зеленскийн бичлэгийг ашиглан хуурамч видео хийснийг харьцуулсан зураг. Энэхүү технологи өдгөө улам хөгжиж, хуурамчийг ялган танихад улам төвөгтэй болсон. [14]

Парламент хоорондын эвсэл (IPU) олон улсын байгууллагын нийтлэлд дурдсанаар 2024 оны улс төрийн сонгуульд хэт хуурамч мэдээлэл өмнөх жилүүдээс илт өсөх хандлагатай бөгөөд хэт хуурамч болон худал мэдээлэл эрс нэмэгдэх хандлагатай байгаа аж. Тэдний үзэж буйгаар худал мэдээлэл нь хувийн

болон улс төрийн ашиг хонжоо олох хялбар арга бөгөөд улс төрчдийн хувьд өрсөлдөгчдийн нэр хүндийг гутаах кампанит ажлын хэсэг болох төдийгүй хэт туйлширсан нийгэмд гаднын оролцоо, хорлон сүйтгэх арга хэрэгсэл болдог байна. Карлсруэгийн Технологийн Хүрээлэнгийн ажилтан Жутта Жакхел: “хуурамч бичлэг нь улстөрчийг хувь хүний хувьд хохироодог төдийгүй харьяалах нам хүчнийх нь сонгуульд оролцох боломжид нөлөөлж, улмаар ардчилсан институцид итгэх итгэлийг сулруулдаг” байна. Саяхны жишээ гэхэд 1-р сард явагдсан Бангладешийн сонгуулийн үеэр Х (хуучнаар твиттер)-ийн талбарт тавигдсан видео бичлэгт тус улсын сонгуульд АНУ-ын дипломатчид хөндлөнгөөс оролцож, улс төрийн хүчирхийлэл үйлдсэн хэмээн мэдэгдэж, холбогдох үймээн самууны үйл явдлын зураглалыг цацжээ. Удалгүй хиймэл оюун ухааны аватар ашиглан бүтээгдсэн нь нотлогдсон юм [15]. Европол байгууллагын тооцоолсноор 2026 онд цахим контентын 90 хувийг хиймэл оюун ухаанаар бүтээсэн болон төөрөгдүүлсэн мэдээлэл бүрдүүлэх ажээ.

Ажиглагчид 2024 оны сонгууль урьд өмнөх сонгуулиудаас нийгмийн сүлжээ, хиймэл оюун ухааныг илүү өргөн хүрээнд ашиглах магадлалтайг онцолж байна. Дээр дурдсан хиймэл оюун ухаан, “deepfake” технологи нь пандорагийн хайрцаг лугаа урьдчилан тааварлахын аргагүй үр нөлөө учруулж болзошгүй тухай үзэл санаа цөөнгүй байна. Энэхүү эрсдэлээс хамгаалах зорилгоор улс орнууд янз бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлж буй бөгөөд тухайлбал АНУ-ын IBM корпораци 2024 оны сонгуульд хиймэл оюун ухааныг хууран мэхлэхтэй тэмцэхэд ашиглах техникийн гэрээнд (Мюнхений технологийн хэлэлцээр) гарын үсэг зурж, хиймэл оюун ухааныг олон нийтийг хууран мэхлэх, сонгуулийг будилаантуулахад ашиглах эрсдэлийг бууруулахад хамтран ажиллахаа амласан байна. Тус корпорацийн зүгээс сонгуулийг хамгаалах, уран бүтээлчид болон иргэдийн хувийн нууцлалыг хамгаалах гэсэн 3 зорилтыг үндсэн чиглэл хэмээн тооцсон байна [16]. Мөн АНУ-ын сенатор Клобучар, Хоули, Кунс, Коллинз нарын өргөн мэдүүлсэн “Сонгуулийн ажиллагааг хиймэл оюун ухааны хууран мэхлэлтээс хамгаалах тухай акт” нь сонгуульд нөлөөлөх зорилгоор улс төрийн сурталчилгаанд нэр дэвшигчдийг талаар хийсэн хуурамч контент бүтээх зорилгоор хиймэл оюун ухааныг ашиглахыг хязгаарлахад чиглэжээ [17]. Европын холбооноос мөн ирэх 6-р сард болох сонгуулийн аюулгүй байдлыг хангахын тулд худал мэдээлэл, цахим халдлагын аюулаас сэргийлэх зорилгоор технологийн том компаниудад хандаж байгаа аж. Дижитал үйлчилгээний тухай хуулийг хэрэгжилтийг хангах зорилгоор Европын комиссоос 20 гаруй цахим талбар, хайлтын системд хуурамч мэдээлэл түгээх, оросын бот кампанит ажиллагаа буюу хуурамч мэдээллийн хэрэгслийн эрсдэлээс сонгуулийг хамгаалахад чиглэсэн шинэ удирдамжийг гаргаад байна [18]. Монгол Улсын хувьд ч 6-р сард явагдах УИХ-ын сонгуульд технологи, хиймэл оюун ухаан

ашиглаж хуурамч мэдээлэл тараах, гаднаас бот кампанит ажиллагаа явуулахгүй гэх баталгаа байхгүй.

Нөгөө талаар “Frontier tech hub” байгууллагын зүгээс дэлхий даяар дижитал боловсролын түвшин дээшилж, иргэд илүү мэдээлэлжсэн, эрх чөлөөтэй болохын зэрэгцээ тоон технологид суурилсан сонгууль нь сонгогчдын ирцийг нэмэгдүүлж, блокчэйн технологийн үр нөлөөгөөр сонгуулийн кампанит ажилд хөндлөнгөөс оролцох боломжийг хязгаарлан, ёс зүйгүй үйлдлийг илрүүлэх боломж нэмэгдэнэ гэсэн өөдрөг байр суурь илэрхийлснийг хэлэх хэрэгтэй [19].

Дүгнэлтийн оронд

Дэлхийн их гүрнүүдийн сөргөлдөөн, Орос-Украины дайн, Израил-Хамасын дайн, дэлхийн гео-эдийн засгийн хуваагдал зэрэг олон улсын харилцаа нарийн төвөгтэй цаг үед дэлхийн олон оронд улс төрийн сонгууль явагдаж байна. Сонгуулийн үр дүнд бүрэлдсэн парламент, засгийн газар, төрийн тэргүүний бодлого стратегиас шалтгаалж, дэлхийн хүчний харьцаа, геополитикийн орчин нөхцөл хаашаа эргэх нь шийдэгдэнэ хэмээн судлаачид үзэж байна.

Тухайн улс орон ямар дэглэмтэйгээс үл хамааран нам хүчин, улс төрчид сонгуульд нийгмийн сүлжээ, мэдээллийн технологийн дэвшил, хиймэл оюуны ухааныг ашиглах явдал түгээмэл үзэгдэл нэгэнт болжээ. Энэхүү үйл явцыг үндсэн хоёр чиглэлд хувааж болох бөгөөд эхнийх нь, өөрийн орны улс төрийн өрнөл, сонгуулийн кампанит ажил, иргэд сонгогчдын санаа бодлыг бүрдүүлэхэд дижитал технологийг өргөнөөр ашиглах, удаах нь, бусад улс орны улс төр, сонгуулийн ажиллагаанд хиймэл оюун ухаан, нийгмийн сүлжээ зэрэг технологийн боломжийг ашиглан мэдээлэл сэтгэлзүйн дайн өрнүүлэх замаар сонгуулийн үйл явцад хөндлөнгөөс нөлөөлөх боломжийг эрэлхийлэх. Ялангуяа ардчилсан бус орнуудад технологийн боломжийг эрх баригчид байр сууриа бэхжүүлэх, үзэл суртал, суртал ухуулгын чадварлаг хэрэгсэл болгох тал дээр гаршиж буйн зэрэгцээ бусад орны улс төрийн хэрэгт “хошуу дүрэх” үр дүнтэй арга барил болгон ашиглаж буй талаар судлаач, шинжээчид дүгнэлт зөвлөмж гаргаж, улс орнуудын засгийн газар бодлого шийдвэр гаргаж, технологийн корпорациуд гарц шийдэл санал болгож байна.

Дэлхий дахинд өрнөж буй хийгээд үлдсэн хугацаанд явагдах бүхий л сонгуулийг бүхэлд нь харвал орчин үеийн улс төрийн үйл явц мэдээлэл, харилцаа холбооны технологиос ангид байх ямар ч боломжгүй болж, нийгмийн сүлжээ, цахим технологиор дамжуулан иргэдийн оролцоог хангах, улс төрийн ил тод, нээлттэй, өрсөлдөөнт байдлыг хангах, сонгуулийн үйл явцыг цахимжуулах зэрэг ардчилсан үйл явц, үнэт зүйлийг бэхжүүлэхэд үр дүнтэй арга хэрэгсэл нэгэнт болжээ. Нөгөө талаас энэхүү хэрэгслээр дамжуулан иргэдийн улс төрийн эрхэнд халдах, улс орны тусгаар байдалд хөндлөнгөөсоролцох, улс төрийн тогтворгүй

байдал үүсгэх зэрэг ардчилалд эрсдэл аюул учруулах нөхцөлийг хязгаарлахтай холбоотой олон сорилтыг даван туулах, сөрөн тэсвэрлэх шаардлага тулгарч байна.

Ном зүй

1. K. Buchholz, “2024: The Super Election Year,” 19 01 2024. Available: <https://www.statista.com/chart/31604/countries-where-a-national-election-is-was-held-in-2024/>.
2. A. J. A. N. AGENCIES, “Aljazeera.com,” 31 03 2024. Available: <https://www.aljazeera.com/news/2024/3/31/turkeys-opposition-set-to-hold-power-in-major-cities-partial-results-show>.
3. УИХ, “Улс төрийн намын тухай \шинэчилсэн найруулга\,” Улаанбаатар, 2023.
4. УИХ, “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай,” УБ, 2023.
5. Янжиндулам, “ТОЙРОГ: 21 аймгийг дараах байдлаар 7 бүсэд хувааж, сонгуулийн тойргийг томруулна,” 18 12 2023. Available: <https://ubn.mn/p/54147>.
6. CEX, “SONGUULI,” 15 03 2024. Available: <https://m-election.mn/wp/mongol-ulsyn-ih-hurlyn-2024-ony-eelzhit-songuulijn-tojrog-tojrogt-nogdoh-mandatyn-too/>.
7. F. house, “FREEDOM IN THE WORLD 2023,” 2023.
8. H. Kitschelt, “LINKAGES BETWEEN CITIZENS AND POLITICIANS IN DEMOCRATIC POLITIES,” *COMPARATIVE POLITICAL STUDIES*, 6. 33, pp. 845-879, 2016.
9. Accessnow, “Weapons of control, shields of impunity: Internet shutdowns in 2022,” 28 02 2023. Available: <https://www.accessnow.org/internet-shutdowns-2022/>.
10. Sameer Patil, Shourya Gori, “Deep fake, disinformation, and deception,” 25 08 2023. Available: <https://www.orfonline.org/expert-speak/deep-fake-disinformation-and-deception>.
11. EU, “2nd EEAS Report on Foreign Information Manipulation and Interference Threats,” 2024.
12. М. мэдээ, ““Cambridge analytica” компани үйл ажиллагаагаа зогсоож, дампуурлаа зарлахаар боллоо,” 03 05 2018. Available: <https://www.mnb.mn/i/141197>.

13. A. Breland, “The Bizarre and Terrifying Case of the “Deepfake” Video that Helped Bring an African Nation to the Brink,” 15 03 2019. Available: <https://www.motherjones.com/politics/2019/03/deepfake-gabon-ali-bongo/>.
14. James Pearson, Natalia Zinets, “National post,” Reuters, 17 03 2022. Available: <https://nationalpost.com/news/deepfake-footage-purports-to-show-ukrainian-president-capitulating-2>.
15. IPU, “Dangers of deepfakes for parliamentarians,” 19 02 2024. Available: <https://www.ipu.org/news/news-in-brief/2024-02/dangers-deepfakes-parliamentarians>.
16. C. Montgomery, “Here’s What Policymakers Can Do About Deepfakes, Right Now,” 28 02 2024. Available: <https://newsroom.ibm.com/Blog-Heres-What-Policymakers-Can-Do-About-Deepfakes>.
17. S. Collins, “U.S. Senate Weighs Restricting AI Use in Elections,” 03 11 2023. Available: <https://www.govtech.com/policy/u-s-senate-weighs-restricting-ai-use-in-elections>.
18. C. Goujard, “ Europe wields new tech law to protect EU election Politico,” 26 03 2024. Available: <https://www.politico.eu/article/europe-wields-new-tech-law-protect-eu-election/>.
19. F. T. Hub, “It’s 2025, what is the Future of Elections?,” 2024. Available: <https://www.frontiertechhub.org/future-of/elections-1>.

УЛС ТӨРИЙН СОНГОЛТОД НӨЛӨӨЛӨХ НЭР ДЭВШИГЧТЭЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ

Профессор Ж.Төртогтох
МУИС-ийн УТСОУХНУС-ийн
Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч

Доктор Г.Туяагэрэл
МУИС-ийн УТСОУХНУС-ийн
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш

Хураангуй: Орчин үед улс төрийн үйл ажиллагаанд улс төрийн хошуучлагчийн үүрэг хариуцлага улам бүр нэмэгдэхийн хэрээр хошуучлагчид тавих шаардлага илүү өндөр болсоор байна. Ямар ч хошуучлах үйл явц нь бүлгийн үзэгдэл байдаг учраас тухайн үйл ажиллагаанд оролцогч, дэмжигч, нөгөө дагалдагч хэсэг гэж байдаг учир улс төрийн хошуучлалын талаарх судалгаа нь олон талтай, салбар дундын утгыг агуулдаг өргөн судлагдахуун юм. Хошуучлагчдын хувьд өөрийн дагалдагчдыг бий болгох, тэднээр хүлээн зөвшөөрөгдөх гэдэг бол анхаарах ёстой асуудлуудын нэг байдаг. Тэр утгаараа улс төрийн энэхүү харилцаанд ардчилсан нийгэм түүний гол хүчин зүйл болох сонгууль хамааралтай болж байна. Ард түмний хүсэл эрмэлзлийн дагуу төрийн шийдвэр гарч байх явдал бол ардчиллыг тодорхойлогч гол шинж ба хэн төлөөлөгч болох вэ? гэдгийг тодорхойлох ганц арга зам бол сонгууль гэж ойлгож болох юм. Ардчиллын тухай онолд төрийн эрх мэдэл ард түмний итгэл, зөвшөөрлөөс сурвалжтай бөгөөд ард түмний бүрэн эрхт байдал, олонхын удирдлагын үзэл санааг хэрэгжүүлэх гол хэрэгсэл бол сонгууль хэмээн үздэг. Тийм учраас Ардчилсан засаглал дахь улс төрийн сонгуулийг судлах нь “Улс төрийн хошуучлагч”, “Сонгогчдын үйл байдал”-ын талаар хамтад нь судлах зайлшгүй шаардлага байгааг харуулж байна. Энэ өгүүлэлд улс төрийн хошуучлагчтай холбоотой бие хүний болоод бусад хүчин зүйлс нь сонгогчдын сонголт, улс төрийн үйл байдалтай ямар хамааралтай байгааг 2023 оны 3-р сараас 5-р сарын хооронд Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд зохион байгуулсан судалгааны үр дүнгээр тайлбарлан авч үзсэн.

Түлхүүр үг: Улс төрийн хошуучлагч, сонгогчдын үйл байдал, улс төрийн сонголт, улс төрийн коммуникаци

Оршил

Нийгэм хөгжиж, улс төрийн үйл явц илүү нарийн болж өөрчлөгдөхийн хэрээр улс төрийн хошуучлагч, дагалдагч нарын хоорондын харилцаа төвөгтэй болж энэ нь судалгааны салбарт тодорхой хүндрэл, бэрхшээлийг үүсгэсээр байна. Улс төрийн хошуучлагчид тавих шаардлага илүү өндөр болохын хэрээр дагалдагчдын үйл байдал ямар байгааг мэдэх нь ихээхэн төвөгтэй асуудал болж хувираад байна. Тэр утгаараа нэр дэвшигчид нөлөөлөх хүчин зүйл буюу сонгогчид эцсийн сонголтоо хийхдээ ямар шалгуур үзүүлэлтээр нэр дэвшигчийг сонгох болсон талаар нэр дэвшигч, сонгогч хоёрыг хамтад нь системийн хүрээнд судлах зайлшгүй шаардлагатай байна. Нийгэм хөгжихийн хэрээр шинжлэх ухаан технологийн дэвшил улам өргөжиж түүнийг дагаад иргэдийн цахим оролцоо болон технологид суурилсан дэвшлүүдийг сонгуулийн кампанит ажилдаа ашиглах боломж бүрдсэнээр нэр дэвшигч, сонгогчдын үйл байдал, сонгуулийн коммуникаци гэсэн гурван ойлголтыг хавсарган судлах шаардлага үүсэж байна.

Сэдвийн судлагдсан байдал

Нийгмийн хөгжлийн үйл явцад “Улс төрийн хошуучлагч” нь улс төрийн үйл ажиллагааны гол субъект байдлаар тодорхойлогддог бөгөөд түүхэн тодорхой соёл иргэншил, нийгмийн хөгжил, улс төрийн соёл нь улс төрийн хошуучлагчийг төлөвшүүлэн хөгжүүлдэг билээ. Тийм ч учраас улс төрийн хошуучлагчийн судалгаа нь шинэлэг бас чухал ач холбогдолтой сэдэв болсоор байна. Сонголтод нөлөөлөх нэр дэвшигчтэй холбоотой зарим хүчин зүйлийн талаарх судалгаа улс төрийн шинжлэх ухааны хавсарга судалгааны хүрээнд нэр дэвшигчийн (Бие хүний шинж, улс төрийн замнал, улс төрийн хошуучлагчийн нэр хүнд, сонгуулийн коммуникаци буюу сонгогчидтой холбоо тогтоох, сонгуулийн кампанит ажлын зохион байгуулалт) ямар шинж байдал нь сонгогчдын эцсийн шийдвэрт нөлөөлж байгааг судалсан судалгаа байгаа тодорхой хүчин зүйлийн хүрээнд тусгайлан авч үзсэн судалгаа ховор байна. Онолын тайлбар болохын хувьд байгаа хэдий ч бодит орчин дахь судалгаа, шинжилгээ шаардлагатай байна. Судалгааны сэдэвтэй холбогдолтойгоор Монгол Улсын Их Сургуулийн Улс төр судлалын тэнхимээс хэвлэгдэн гардаг улс төрийн мэргэжлийн түвшинд хянагддаг Политологи эрдэм шинжилгээний бичгийг гол судлагдсан байдлын сурвалж болгон авсан болно.¹ Мөн Д.Ганхуяг “Хошуучлагчийн улс төрийн имиж, түүнийг бүрдүүлэхүй” номыг судалгааны ажлын онолын эх сурвалж мөн судлагдсан байдалд хамааруулсан болно.

1 Монгол Улсын Их Сургуулийн Улс төр судлалын тэнхимээс хэвлэгдэн гардаг улс төрийн мэргэжлийн түвшинд хянагддаг Политологи эрдэм шинжилгээний бичиг

ШУА-ын Философийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Философи, эрх зүйн судлал” сэтгүүлийн 37 дахь дугаар Доктор У.Батцэрэн “Улс төрийн лидерийн имиж бүрдүүлэлт ба технологи” бүтээлдээ улс төрийн лидерийн тойрон хүрээлэгчид, улс төрийн лидерийн баг, улс төрчийн би концепци, нэр дэвшигчээс улс төрийн лидер хүрэл, улс төрийн лидерийн манлайлал, улс төрийн лидер имижээ хайрцаглах гэсэн ойлголтуудыг тайлбарласан байна.²

Доктор Ц.Мөнхцэцэг “Улс төрийн манипуляци” бүтээлдээ Олон нийтийн үйл байдлыг өөрт ашигтайгаар өөрчлөхөд манипуляцийн гол зорилго оршиж байдаг гэсэн ба хүмүүсийн улс төрийн ухамсар, үйл байдалд далд аргаар нөлөөлөх нь улс төрийн манипуляци болно гэж үзсэн. Түүнчлэн манипуляци хийх сувгуудыг визуаль, вербаль гэж хуваан үзэж ОНМХ-тэй холбон тайлбарласан ба мөн олон түмний менталитетийн талаар тайлбарласан.

Доктор У.Батцэрэн “Улс төрийн имиж-Онол, үзэл баримтлал” бүтээлдээ улс төрийн имиж нь улс төрийн зүтгэлтнийг олон түмэнд тааламжтай эерэг харилцааг бий болгоход чиглэдэг хэмээн улс төрч, сонгогч хоёр талын ашиг сонирхлыг хангахын тулд үйлчилж, ашиг сонирхлуудыг нэгтгэхийг хичээдэг үйл явц гэж тодорхойлжээ.

Улс төрийн маркетинг-улс төрийн зах зээлийг судлах ба үүндээ сонгогчдыг судлах гэдгийг тодруулан удирдлагын онолчдын нэг Петер Друккер “Маркетингийн зорилго нь худалдаа, борлуулалтад их чармайлт гаргуулахгүйд оршино”. Бараа буюу үйлчилгээ нь худалдан авагчийн сэтгэлд таалагдаж борлогдоно гэдгийг сайн мэдэж ойлгосноор маркетинг зорилгоо биелүүлнэ” гэж хэлснийг бүтээлдээ дурдан уг санааг дэлгэрүүлэн тайлбарлажээ. Судлаач Д.Оюунчимэг “Сонгуулийн сурталчилгааны арга зүй” бүтээлдээ сонгуулийн кампанит ажил нь улс төрийн нам, нэр дэвшигчдэд ялалт байгуулахад нь, сонгогчид сонголтоо хийхэд нь ач холбогдолтой төдийгүй ард түмэн хэнийг сонгодог вэ? Сонгогч чухам юуны төлөө саналаа өгдөг вэ? Сонгогчийг санал өгөх сэдэл, шалтгаанаас нь хамааран “хувийн чиг баримжаатай сонгогч”, “улс төрийн чиг баримжаатай сонгогч” гэсэн хоёр бүлэгт хуваан авч үзвэл асуудлын хариултыг олоход дөхөм болно гэж үзээд ийм нөхцөлд сонгогчийн эхний бүлгийн хандлагыг “төгс нэр дэвшигчийн хандлага”-аар, харин хоёр дахь бүлгийг “нийгэм-эдийн засгийн хандлага”-аар тус тусад нь тодорхойлж болмоор харагдаж байна гэж үзжээ. Гэвч үнэн хэрэг дээр бүх зүйл арай өөр байдаг. Сонгогчийн санал өгдөг жинхэнэ шалтгааныг тэдэнд тавьдаг асуултаас олох хэцүү. Асуулгад оролцогсдын үнэн сэтгэлээсээ хариулсан хариултад үндэслэн таамаглалыг гаргаж ирж болох ч бодит байдал дээр тэдний сонголт хийхэд нь тун өөр механизм үйлчилсэн байдгийг судлаачид хүлээн зөвшөөрдөг гэдгийг дурдаж өгсөн байдаг.

2 Шинжлэх ухаан философийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Философи, эрх зүйн судлал” сэтгүүл, УБ, 2008 он

Улс төрийн хошуучлагчийн талаарх онолын үзэл баримтлал

Улс төрийн хошуучлагч нь улс төрийн зүй тогтол хөгжлийн хэрэгцээ, шаардлагаар буй болдог төдийгүй мөнхүү хөгжлийн үр дагавар, бүтээгдэхүүн болон төлөвшин тодорхойлогдож байдаг.³ Улс төрийн хошуучлалын талаарх үзэл санаа нь улс төрийн сэтгэлгээний эртний үеэс эхтэй юм.

Эртний үед бүр эрт үеэс дундад зууныг хүртэл хошуучлагч судлалын намтар зүй, “аугаа их хүний” үзэл санаа зонхилон хөгжиж байв. Энэ үеийн сэтгэлгээнд домог зүй, шашин, түүх, гүн ухааны хандлага чиглэлүүд хүчтэй илрэн хөгжиж байсан.

Дундад үед улс төрийн хошуучлагчийн тухай шинж төрх, үнэт зүйлс, бүтцийн онолуудаар тайлбарлаж иржээ. Хаад ноёдын удам угсаа, эрх ямба, байр суурь, шилдэг шинжүүдийг тайлбарлахад голлон анхаарч байсан. Улс төрийн хошуучлалын талаарх уламжлалт сэтгэлгээнд домог зүй, түүх, шашин гүн ухааны хандлагууд давамгайлж байсан. Улс төрийн хошуучлагчийн тухай онолуудыг XIX зууны сүүлч, XX зууны эхэн үед үзэл баримтлалын арга зүйн хувьд боловсруулан хөгжүүлж ирсэн нь бие даасан онол-практикийн судалгааны чиглэл болоход нөлөөлсөн байдаг.

Улс төрийн хошуучлалын талаарх орчин үеийн судалгаа, ном зохиолуудад улс төрийн хошуучлалыг өөрийн улс төрийн зорилго, эрх ашгаа гүйцэлдүүлэх зорилготой улс төрийн дүрийн нэг хэлбэр гэж үзэн үйл ажиллагааны гүйцэтгэл, зорилготой холбон авч үзсэн байдаг. Улс төрийн хошуучлалын талаарх орчин үеийн онолуудад хошуучлагчийн бие хүний шинж байдлын онол, үйл байдлын онол, нөхцөл байдлын онолууд тус тус багтаж байна.

Ямар нэгэн зорилгод хүрэхийн тулд нийгмийг дайчлах чадвартай нөлөө бүхий улс төрийн дүрийг улс төрийн хошуучлагч гэнэ. АНУ-ын улс төр судлаач Р.Такер “Улс төр-удирдлагын урлаг мөн” бүтээлдээ улс төрийн хошуучлагч гэдэг нь бодит хошуучлагчид, нөгөө талаас албан тушаалтнууд буюу удирдагчид байдаг гэжээ. Түүнийхээр улс төрийн хошуучлал нь эцсийн бүлэгт улс төрийн үйл ажиллагааг чиглүүлэгч механизм юм.⁴

Дундад үед улс төрийн хошуучлагчийн тухай шинж төрх, үнэт зүйлс, бүтцийн онолуудаар тайлбарлагдаж ирсэн ба хаад ноёдын удам угсаа, эрх ямба, байр суурь, шилдэг шинжүүдийг тайлбарлахад голлон анхаарч байв. Улс төрийн хошуучлагчийн тухай онолуудыг XIX зууны сүүлч, XX зууны эхэн үед үзэл баримтлал арга зүйн хувьд боловсруулан хөгжүүлж ирсэн байна. Ийнхүү биеэ даасан онол-практикийн судалгааны чиглэл буй болсон.

Дэлхий дахинд ардчилал илүүтэй хөгжиж, тэлэхийн сацуу улс төрийн

3 Г.Цэцэн “Монголын улс төрийн хошуучлагчдын хэв маягийн асуудал”, УБ, 2001 он, магистрын ажил

4 Улс төрийн шинжлэх ухаан, УБ, 2010 он, ху194

амьдралд олон түмэн өргөнөөр татагдан орох болсонтой холбоотой юм. Чухам энэхүү нөхцөл байдал нь улс төр дэх хошуучлагчийн болон олон түмний улс төрийн сонголтын хамаарлыг судлах шаардлагыг бий болгож байгаа юм.

Сонгогчдын үйл байдлын талаарх онолын үзэл баримтлал

Улс төрийн оролцооны нэлээд тархсан хэлбэр нь сонгогчдын үйл байдал юм. Хүмүүс сонгуульд саналаа хэрхэн өгдгийг судалдаг салбарыг **псефологи/ psephology/** хэмээн нэрлэдэг.⁵

Сонгогчдын сонголт хийх чадварын тухай, тэдний сонголтод нөлөөлөх хүчин зүйлсийн тухай асуудал нь псефологчдын анхаарлыг ямагт татаж ирсэн асуудлууд юм. Сонгогчид улс төрийг хэр зэрэг сонирхдог вэ, тэд ухамсарласан сонголт хийх чадвартай юу, тэдний улс төрийн мэдлэг, боловсролын төвшин ямар хамааралтай вэ? зэрэг асуудлуудад ардчиллын тухай онолын үзэл баримтлал бүр өөр өөрийн загварыг бий болгосон байдаг.

Улс төрийн ардчиллын сэтгэлгээний түүхэнд олон түмэн улс төрийн талаар мэдлэг, туршлагатай байх нөхцөлд л ардчилал оршин тогтнох чадвартай гэсэн үзэл давамгайлж ирсэн. Сонгодог ардчиллын онолчид үзэхдээ, сонгогчид ухаалаг шийдвэр гаргахын тулд өөрсдийгөө төлөөлж буй институт, хүмүүст нөлөөлж, тэдний үйл ажиллагааг хянаж чаддаг байхын тулд сонголтын утга учрыг бүрэн ойлгодог, улс төрийн тогтолцооны талаар наад захын мэдлэгтэй байх ёстой гэж үздэг.

Ардчилсан улс орны иргэд улс төрийн мэдлэгтэй, идэвхтэй, чадвартай байх боломжтой боловч харьцангуй цөөн иргэд эл боломжийг ашигладаг нь 1940-1960-аад онд явуулсан судалгааны дүнгүүдээс харагдсан нь судлаачдыг гайхан эргэлзэхэд хүргэсэн юм. Бодит амьдрал дээр сонгогчдын улс төрийн мэдлэг, боловсролын түвшин сонгодог онолын загвараас хол зөрүүтэй болох нь тодорхой байлаа.

Сонгогчдын санаа бодол, үйл байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах ажлыг АНУ-д 1940 оны сонгуулийн үед орон нутгийн хэмжээнд хийж байсан. 1948 онд Мичиганы их сургуулийн хэсэг судлаачид нийт улс орныг хамарсан сонгуулийн судалгаа хийжээ. Энэ бол өнөө хүртэл тасралтгүй үргэлжилж буй цуврал судалгааны эхнийх нь байжээ³. Мөн Мичиганы их сургуулийн хэсэг эрдэмтэд социаль болон сэтгэлзүйн хийгээд бусад хүчин зүйлийн нөлөөллийг аль алиныг нь тусгасан, сонгогчдын санал өгөх үйл байдлын загварыг 1980-аад оны сүүлчээр боловсруулсан нь өнөөдөр ч судлаачдын анхаарлыг татсаар байгаа билээ¹. Тэд энэ загвараа “учир шалтгааны хоолой” гэж нэрлэсэн байна.⁶

5 Улс төрийн шинжлэх ухаан, УБ, 2010 он, ху409

6 Улс төрийн шинжлэх ухаан, УБ, 2010 он, ху411

Сонгогчдын сонголтын учир шалтгааныг ойлгоход түүнд нөлөөлж буй хүчин зүйл нэг бүрийн гүйцэтгэх үүрэг, хоорондын харилцаа холбоо, хамаарлыг зөв тогтоох явдал нэн чухал. Сонгогчдын санал өгөх үйл байдлыг судлах салбарт нийгэм, сэтгэлзүйн хандлага нэвтэрч орж ирсэн нь чухал ололт юм.

Сонгогчдын сонголтод нөлөөлж буй үндсэн хүчин зүйлсийг:

- ❖ Богино хугацааны хүчин зүйлс (Улс төр, эдийн засгийн тухайн нөхцөл, улс төрийн лидерийн имидж, сонгуулийн кампани г.м)
- ❖ Урт хугацааны хүчин зүйлс (Социаль бүлгийн ялгаа, үзэл бодол, намын харьяалал, үнэт зүйлсийн баримжаа г.м) гэж ангилж үздэг.⁷

Сонгогчдын сонголтод нөлөөлдөг хүчин зүйлс дотроос улс төрийн намд өөрийгөө харъяалуулах буюу түүнтэй өөрийгөө адилтгах гэсэн ойлголтод Америкийн псефологичид 1860-аад оноос хойш ихээхэн ач холбогдол өгч иржээ. Хэвийн нөхцөлд иргэд тухайн нэг намыг онцгойлон үзэж, түүнд өөрийгөө харъяалуулдаг гэсэн ойлголт нь сонгогчийн үйл байдлыг тайлбарлахад тулгуур ойлголт болдог байна. Аль нэг улс төрийн намын талыг баримталдаггүй сонгогчдыг “хөвдөг сонгогчид” гэж нэрлэж сонгуулийн кампанийн үед тэдэнд илүү анхаарал тавьж ажилладаг.

Нэр дэвшигчийн имиж нь сонгогчдын үйл байдалд нөлөөлдөг хүчин зүйлсийн дотор өнөөгийн байдлаар хоёрдугаар зэрэгт орж байгаа, үндсэн суурь хүчин зүйл юм. Нэр дэвшигчийн имиж-намын имиж, намын имиж-нэр дэвшигчийн имиж харилцан үйлчлэлд оршиж нөхцөлдүүлж байдаг. Олон түмэн улс төрийн лидерийг имижээр нь таньж, үнэлж дүгнэж, сонголтоо хийдэг. Сонгогчдын үнэт зүйлсийн баримжаалал буюу тэдний юут үнэт зүйл үзэж буй итгэл үнэмшил нь хялбархан өөрчлөгдчихгүй. Тиймээс ч энэ нь сонгогчдын үйл байдалд нөлөөлдөг “урт хугацааны” (харьцангуй тогтвортой, суурь) хүчин зүйл юм.

Судалгааны үр дүн

Энэ өгүүлийн хүрээнд сонгогчдын улс төрийн сонголтод нэр дэвшигчтэй холбоотой ямар хүчин зүйл нөлөөлдөг болохыг судлахаар 2023 оны 3-р сараас 5-р сарын хооронд цахим болон цаасан хэлбэрээр олон нийтийн санаа бодлын судалгааг зохион байгуулсан. Судалгааны асуулгыг боловсруулахдаа сонгогчдын улс төрийн сонголтод нэр дэвшигчийн хэрхэн хүлээж авч байгаа нь нөлөөлнө гэж үзээд тухайн нэр дэвшигчтэй холбоотой хүчин зүйлсийг дараах 5 бүлэгт хуваан авч үзсэн. Үүнд:


1. Нэр дэвшигчийн хувь хүний шинж чанар
2. Улс төрийн замнал

7 Улс төрийн шинжлэх ухаан, УБ, 2010 он, ху411

3. Нэр дэвшигчийн сонгогчдын дундах нэр хүнд
4. Сонгуулийн кампанит ажлын үеэрх сонгогчидтой холбоо тогтоож байгаа байдал
5. Сонгуулийн кампанит ажлын онцлог
Сонгогчдын улс төрийн сонголтод нөлөөлөх нэр дэвшигчтэй холбоотой зарим хүчин зүйлийг шинжлэх зорилгын хүрээнд дараах таамаглалыг дэвшүүлэн.
 1. Сонгогчдын улс төрийн сонголтод нэр дэвшигчтэй холбоотой бие хүний шинж байдал нөлөөлнө.
 2. Сонгогчдын улс төрийн сонголтод нэр дэвшигчийн улс төрийн замнал нөлөөлнө.
 3. Сонгогчдын улс төрийн сонголтод нэр дэвшигчийн нэр хүнд нөлөөлнө.
 4. Сонгогчдын сонголтод нэр дэвшигчийн сонгуулийн коммуникаци буюу сонгогчидтой холбоо тогтоох байдал нөлөөлнө.
 5. Сонгогчдын сонголтод нэр дэвшигчийн сонгуулийн кампанит ажлын зохион байгуулалт нөлөөлнө гэсэн 5 таамаглалыг дэвшүүлэн ажилласан.

Судалгаанд оролцсон Улаанбаатар хотын 9 дүүргийн 650 оролцогчдын 51.5 хувь нь эмэгтэй, 48.5 хувь нь эрэгтэй; насны байдлыг 12 бүлэгт хуваан үзэхэд 7.9 хувь нь 18-19, 32.7 хувь нь 20-24, 21.8 хувь нь 25-29, 7.9 хувь нь 30-34, 9.9 хувь нь 35-39, 4 хувь нь 40-44, 6.9 хувь нь 45-49, 2 хувь нь 50-54, 3 хувь нь 55-59, 3 хувь нь 65-69 насныхан; ажил эрхлэлтийн байдал нь 7.9 хувь нь ажил хийдэггүй, 26.7 хувь нь оюутан, 4 хувь нь тэтгэвэрт, 39.6 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 21.8 хувь нь төрийн байгууллагад ажилладаг; гэрлэлтийн байдлын хувьд 32.7 хувь нь гэрлэсэн, 63.3 хувь нь гэрлээгүй; боловсролын түвшин нь 3 хувь нь бүрэн бус дунд, 29.7 хувь нь бүрэн дунд, 5.9 хувь нь техник болон мэргэжлийн, 61.4 хувь нь дээд боловсролтой; амьдардаг орон сууцны төрөл 12.9 хувь нь өөрийн эзэмшлийн хашаа байшин, гэр, 52.4 хувь нь өөрийн эзэмшлийн орон сууц, 2 хувь нь түрээсийн хашаа байшин, гэр, 18.8 хувь нь түрээсийн орон сууц, 10.9 хувь нь хамаатан ах дүүсийнхээ гэр, орон сууц, 3 хувь нь хувийн эзэмшлийн хаус; амьдардаг дүүргийн хувьд 5 хувь нь Багануур, 2 хувь нь багахангай, 10.9 хувь нь Баянгол, 28.7 хувь нь Баянзүрх, 3 хувь нь Налайх, 8.9 хувь нь Сонгинохайрхан, 15.8 хувь нь Сүхбаатар, 18.8 хувь нь Хан-уул, 6.9 хувь нь Чингэлтэй дүүргийн оролцогчид байсан.


График 1. Нэр дэвшигчийн хувь хүнтэй холбоотой шинж чанар



Судалгаанд оролцогчдын 38.6 хувь нь нэр дэвшигчийн хувь хүнийхээ хувьд ямар хүн болох нь нэн чухал шаардлага гэж үзсэн байхад тухайн нэр дэвшигчийн харагдах байдал 33.3 хувьд нь огт нөлөөгүй; 32.6 хувь нь хүмүүстэй харилцан ярилцаж, ярилцлагыг удирдан чиглүүлж байгаа байдал нэн чухал шаардлагатай; 38.6 хувь нь бусдад нөлөөлөх өөрийн үзэл бодлоо тайлбарлан ойлгуулах байдал нэн чухал шаардлагатай; 43.5 хувь нь бусдыг сонсож чаддаг байх нь нэн чухал шаардлагатай гэж үзсэн байна.

Бүх шатны сонгуульд дэвшин өрсөлдөж буй нэр дэвшигчийг хувь хүн талаас нь ямар чадваруудыг чухалчлан үзэж саналаа өгөх ёстой гэж та бодож байна вэ? гэсэн задгай асуулт асуухад 5.9 хувь нь харилцаа холбоо(хүнийг ойлгож чаддаг байх); 25.7 хувь нь мэдлэг, боловсрол, туршлага; 26.7 хувь нь хариуцлагатай байдал (шударга байдал); 7.9 хувь нь эх оронч үзэл; 8.9 хувь нь хувь хүний удирдан зохион байгуулах чадвар (илтгэх); 1.9 хувь нь ёс зүй; 6.9 хувь нь дээрх бүх чадвартай байх хэрэгтэй гэж үзсэн байна.


График 2. Нэр дэвшигчийн улс төрийн замнал, туршлага



Судалгаанд оролцогчдын 27.7 хувь нь нэр дэвшигчийн улс төрийн замнал дунд зэрэг нөлөөтэй; 35.6 хувь нь тухайн нэр дэвшигчийн улс төрийн замналын талаарх олон нийтийн ерөнхий хандлага дунд зэрэг нөлөөтэй; 23 хувь нь нэр дэвшигчийн харьяалагддаг улс төрийн намын талаарх олон нийтийн ерөнхий хандлага дунд зэрэг нөлөөтэй; 33 хувь нь тухайн нэр дэвшигч харьяалагддаг улс төрийн намын нэр хүнд дунд зэрэг нөлөөтэй; 25.7 хувь нь тухайн нэр дэвшигч улс төрийн хувьд хэр нэр хүндтэй байх нь маш их нөлөөтэй гэж тус тус хариулсан байна.

Улс төрийн сонгуульд дэвшин өрсөлдөж буй нэр дэвшигчийн хувьд улс төрийн ямар туршлага, чадваруудыг эзэмшсэн байх ёстой гэж та бодож байна вэ? гэсэн асуултад 9.9 хувь нь мэдлэг боловсрол; 7.9 хувь нь шударга байх; 9.9 хувь нь үзэл бодолдоо үнэнч байх; 10.8 хувь нь туршлагатай байх; 1.9 хувь нь оновчтой шийдэл(шинийг санаачлагч); 5.9 хувь нь харилцааны чадвар сайн байх; 5.9 хувь нь ажлын бүтээмж өндөр байх; 3.9 хувь нь хуульч байх; 1.9 хувь нь эх оронч байх; 11.8 хувь нь дээрх бүх төрлийн чадвартай байх гэж хариулсан байна.


График 3. Нэр дэвшигчийн итгэл даах байдал



Судалгаанд оролцогчдын 40.5 хувь нь нэр дэвшигчийн амлалтандаа хэр итгэлтэй, үнэнч байх нь маш их нөлөөтэй; 52.4 хувь нь нэр дэвшигчийн сонгогчдод танилцуулж байгаа мөрийн хөтөлбөр, амлалт хэмжигдэхүйц бодитой байх нь маш их нөлөөтэй; 35.6 хувь нь нэр дэвшигч дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн амлалтаа биелүүлж чадах талаарх сонгогчдын итгэл үнэмшил маш их нөлөөтэй; 29.7 хувь нь нэр дэвшигчийн хувийн нэр хүнд маш их нөлөөтэй гэж үзсэн байна.

Сонгогчид нэр дэвшигчийн итгэл дааж чадах эсэхийг хэрхэн мэдэж болох вэ? гэсэн задгай асуултад 11.8 хувь нь амлалт шийдвэрийг харах; 6.9 хувь нь туршлага; 8.9 хувь нь хувь хүн талаасаа (итгэл үнэмшил, биеэ авч яваа байдал); 0.9 хувь нь нас тогтсон хүн; 1.9 хувь нь намд эзлэх байр суурь; 12.8 хувь нь намтар (улс төрийн замнал); 1.9 хувь нь боловсрол, харилцаа хандлага; 0.9 хувь нь санхүүгийн хувьд бие даасан байх; 2.9 хувь нь шударга байдлаас; 4.9 хувь нь бүгдийн судалж мэдэх гэж үзсэн байна.

График 4. Нэр дэвшигчийн сонгогчидтой холбоо тогтоох байдал



Судалгаанд оролцогчдын 8.9 хувь нь сонгогчдын дунд тухайн нэр дэвшигчийн талаарх бий болсон ойлголт хандлага огт нөлөөгүй, 13.8 хувь нь нөлөөгүй, 28.7 хувь нь дунд зэрэг, 31.6 хувь нь нөлөөтэй, 12.8 хувь нь маш их нөлөөтэй; ТВ, радио, сонин сэтгүүл гэх мэт уламжлалт мэдээллийн хэрэгслүүдээр мөрийн хөтөлбөрөө танилцуулж байгаа нь 12.8 хувь нь огт нөлөөгүй, 13.8 хувь нь нөлөөгүй, 27.7 хувь нь дунд зэрэг, 28.7 хувь нь нөлөөтэй, 13.8 хувь нь маш их нөлөөтэй; нэр дэвшигч зорилтод(нэр дэвшиж буй тойргийнхоо) сонгогчдооол маш сайн чиглэх хэрэгтэй 9.9 хувь нь огт нөлөөгүй, 11.8 хувь нь нөлөөтэй, 27.7 хувь нь дунд зэрэг, 28.7 хувь нь нөлөөтэй, 17.8 хувь нь маш их нөлөөтэй; зөвхөн сонгуулийн үеэр биш сонгогчид олон түмэнтэйгээ тасралтгүй холбоотой байх нь 6.9 хувь нь огт нөлөөгүй, 5.9 хувь нь нөлөөгүй, 18.8 хувь нь дунд зэрэг, 22.7 хувь нь нөлөөтэй, 41.5 хувь нь маш их нөлөөтэй; цахим хэрэгслүүдээр мөрийн хөтөлбөрөө танилцуулж байгаа нь 9.9 хувь нь огт нөлөөгүй, 6.9 хувь нь нөлөөгүй, 31.6 хувь нь дунд зэрэг, 23.7 хувь нь нөлөөтэй, 23.7 хувь нь маш их нөлөөтэй; уламжлалт болон цахим мэдээллийн хэрэгслүүдийг хослуулан мөрийн хөтөлбөрөө танилцуулж, сонгуулийн ажлаа зохион байгуулах нь 6.8 хувь нь огт нөлөөгүй, 8.9 хувь нь нөлөөгүй, 26.7 хувь нь дунд зэрэг, 23.7 хувь нь нөлөөтэй, 29.7 хувь нь маш их нөлөөтэй гэж үзсэн байна.

Та нэр дэвшигчдийг сонгуулийн ажлаа хэрхэн зохион байгуулдаг байгаасай гэж боддог вэ? гэсэн задгай асуултад 14.8 хувь нь шударга байх(үнэн), 6.9 хувь нь хэлсэндээ хүрдэг байх, 2.9 хувь нь ил тод, нээлттэй байх, 5.9 хувь нь төсөв багатай

байх, 10.8 хувь нь хүртээмжтэй байдал (уламжлалт, цахим), 7.9 хувь нь энгийн байх, 3.9 хувь нь олон нийттэй ойр байх гэж үзсэн байна.

Хэрвээ танд өөрт тань улс төрийн ямар нэгэн сонгуульд нэр дэвших боломж гарвал та сонгуульд ялалт байгуулахын тулд сонгуулийн ажлаа хэрхэн зохион байгуулах вэ? гэсэн асуултад 21.7 хувь нь хүртээмжтэй байдлыг хангана, 3.9 хувь нь мөрийн хөтөлбөртөө анхаарна, 5.9 хувь нь итгэлтэй хүн, багт хариуцуулна, 9.9 хувь нь шударгаар өрсөлдөнө (хуулийн хүрээнд), 1.9 хувь нь өөрийгөө таниулах үйл ажиллагаа (намтар, улс төрийн замнал), 1.9 хувь нь ил тод, нээлттэй байх, 7.9 хувь нь мэдээлэл хүргэх бүх сувгийг ашиглах гэж хариулсан байна.

Өнгөрсөн хугацаанд болсон УИХ, Ерөнхийлөгч, орон нутгийн сонгуулиудад дэвшиж байсан нэр дэвшигчдийн сонгуулийн ажилд нь хамгийн их сөргөөр нөлөөлсөн зүйл юу байсан бэ? гэсэн задгай асуултад 5.9 хувь нь мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт муу, 3.9 хувь нь их мөнгө зарсан, 15.8 хувь нь хахууль (мөнгө тараах, бараа тараах...г.м.), 8.9 хувь нь хувь хүн талаасаа (намтар, нэр хүнд, ёс зүй), 13.8 хувь нь чанаргүй сурталчилгаа (харлуулалт, цаас, самбар...г.м.), 4.9 хувь нь итгэл итгэл суларсан гэж хариулсан байна.

Та өөрийгөө улс төрийн хувьд хэр идэвхтэй оролцоотой гэж боддог вэ? гэсэн асуултад 8.3 хувь нь огт идэвхгүй, 20.8 хувь нь ерөнхийдөө идэвхгүй талдаа, 33.3 хувь нь дунд зэрэг идэвхтэй, 25 хувь нь ер нь идэвхтэй, 12.5 хувь нь маш их идэвхтэй гэж үзсэн байна.

Судалгаанд оролцогчдын 41.5 хувь нэр дэвшигч хувь хүнийхээ хувьд ямар хүн болох нь хамгийн чухал; 31.6 хувь өмнө нь улс төрийн салбарт ажиллаж байсан туршлагатай байх нь ерөнхийдөө чухал; 49.5 хувь нь өмнө сонгогдож байх хугацаандаа мөрийн хөтөлбөрөө бүрэн хэрэгжүүлж байсан байх нь хамгийн чухал; 24.7 хувь нь нэр дэвшигч аль намаас нэр дэвшиж байгаа нь тийм ч их чухал биш; 22.7 хувь сонгуулийн кампанит ажил нь тийм ч их чухал биш; 26.7 хувь нь нэр дэвшигч танай тойрогт танигдсан нутгийн хүн байх тийм ч их чухал биш; 48.5-51.4 хувь нь хувь нь нэр дэвшигчийн хүйс ямар байх огт чухал биш гэж үзсэн байхад судалгаанд оролцогчдын 25 хувь нь нэр дэвшигч заавал эрэгтэй хүн байх нь чухал, нэр дэвшигч эмэгтэй хүн байх нь хамгийн чухал гэж 11.8 хувь нь хамгийн чухал; нэр дэвшигч олон нийтэд танигдсан байх нь хамгийн чухал гэж судалгаанд оролцогчдын 8.9 хувь нь, нэр дэвшигч ямар нэгэн салбараар илүү мэргэшсэн судлаач эрдэмтэн байх нь чухал гэж судалгаанд оролцогчдын 41.5 хувь нь үзсэн байна.

Хүснэгт 1. Хүчин зүйлийн хамаарал

	Хүчин зүйл	Улс төрийн сонголтод нөлөөлөх байдал
Сонгуулийн кампанит ажлын менежмент	X5	0.002
Бие хүний шинж чанар	X1	0.005
Улс төрийн замнал	X2	0.096
Сонгогчидтойгоо холбоотой байх байдал	X4	0.734
Нэр хүнд	X3	0.965

Сонгогчдын улс төрийн сонголтод хамгийн хүчтэй нөлөөлж байгаа хүчин зүйл нь X3 буюу нэр дэвшигчийн нэр хүнд, X4 буюу нэр дэвшигчийн сонгогчидтой холбоо тогтоох байдал бол дундаж нөлөөтэй нь X2 буюу нэр дэвшигчийн улс төрийн замнал, нөлөөлөл хамгийн багатай нь X1 буюу нэр дэвшигчийн бие хүний шинж чанар, X5 буюу нэр дэвшигчийн сонгуулийн кампанит ажлын менежмент байна. Үүнээс сонгогчдын улс төрийн сонголтод хамгийн хүчтэй нөлөөтэй хүчин зүйл нь X3 буюу нэр дэвшигчийн нэр хүндийн байдал нь 0.965 нэгжээр нөлөөлж байна. Харин сонгогчдын улс төрийн сонголтод хамгийн бага нөлөөтэй нь X5 буюу нэр дэвшигчийн сонгуулийн кампанит ажлын менежмент 0.002 нэгжээр сонгогчдын улс төрийн сонголтод нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 2. Нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ

Үзүүлэлт	Дундаж утга	Хувьсагч	Үзүүлэх нөлөөлөл
Нэр дэвшигчийг дэмжиж байгаа олон нийтийн дэмжлэг	2.3	Сонгогчидтойгоо холбоотой байх байдал	Хамгийн бага нөлөөтэй хүчин зүйл
Бусдыг сонсож чаддаг байх нь	3.4	Бие хүний шинж чанар	Дунджаар нөлөөлж байгаа хүчин зүйл
Хүйс	3.9		

Нэр дэвшигчийн амлалтдаа хэр итгэлтэй үнэнч байх нь	4.0	Нэр хүнд	Дунджаас дээгүүр нөлөөлж байгаа хүчин зүйл
Нэр дэвшигч аль намаас нэр дэвшиж байгаа нь	4.1	Улс төрийн замнал	Хамгийн их нөлөөлж байгаа хүчин зүйл
Нэр дэвшигч олон нийтэд танигдсан байх	4.1	Сонгогчидтойгоо холбоотой байх байдал	
Нэр дэвшигч ямар нэгэн салбараар илүү мэргэшсэн судлаач, эрдэмтэн байх	4.2	Бие хүний шинж чанар	

Сонгогчдын улс төрийн сонголтод хамгийн их нөлөөлтэй байгаа хүчин зүйл нь нэр дэвшигчийн бие хүний шинж чанар, нэр дэвшигчийн сонгогчидтойгоо холбоо тогтоох байдал, нэр дэвшигчийн улс төрийн замнал байна. Нэр дэвшигч ямар нэгэн салбараар илүү мэргэшсэн судлаач, эрдэмтэн байх гэсэн нэр дэвшигчийн бие хүний шинж чанарыг судалгаанд оролцогчид илүү чухалчилдаг байна. Нэр дэвшигч олон нийтэд танигдсан байх гэсэн нэр дэвшигчийн сонгогчидтойгоо холбоо тогтоох байдлыг судалгаанд оролцогчид илүү чухалчилдаг байна. Нэр дэвшигч аль намаас нэр дэвшиж байгааг нь гэсэн нэр дэвшигчийн улс төрийн замналыг чухалчилдаг байна. Сонгогчдын улс төрийн сонголтод дунджаас дээгүүр нөлөөтэй байгаа хүчин зүйл нь нэр дэвшигчийн нэр хүнд байна. Нэр дэвшигчийн амлалтдаа хэр итгэлтэй үнэнч байх гэсэн нэр дэвшигчийн нэр хүндийг судалгаанд оролцогчид чухалчилдаг байна. Сонгогчдын улс төрийн сонголтод дундаж нөлөөлтэй байгаа хүчин зүйл нь нэр дэвшигчийн бие хүний шинж чанар байна. Нэр дэвшигч бусдыг сонсож чаддаг байх болон нэр дэвшигчийн хүйс гэсэн нэр дэвшигчийн бие хүний шинж чанарыг судалгаанд оролцогчид чухалчилдаг байна. Сонгогчдын улс төрийн сонголтод хамгийн бага нөлөөтэй байгаа хүчин зүйл нь нэр дэвшигчийн сонгогчидтойгоо холбоотой байх байдал байна. Нэр дэвшигчийг дэмжиж байгаа олон нийтийн дэмжлэг гэсэн нэр дэвшигчийн сонгогчидтойгоо холбоотой байх байдлыг судалгаанд оролцогчид илүү чухалчилдаг байна.

Дүгнэлт

Нэр дэвшигч нь улс төрийн хошуучлагчийн хэлбэр болохынхоо хувьд өөрийн дагалдагчдыг бий болгох хэрэгцээ шаардлага үргэлжид байсаар байдаг. Тэр утгаараа “нэр дэвшигч”, “сонгогч”, хоёр бол хоорондын нягт хамааралтай ойлголт. Учир нь нэр дэвшигчийг улс төрийн дүр болгох эрх мэдэл сонгогчдын гарт байдаг.

Судалгааны ажлын хүрээнд тавьсан таамаглал болоод зорилго, зорилтуудаа шийдвэрлэж чадсан эсэхэд дараах дүгнэлтийг хийж байна.

Судалгааны үр дүнгээс харахад судалгаанд оролцогчдын хувьд улс төрийн сонголт хийхэд нь нэр дэвшигчийн нэр хүнд хамгийн хүчтэй нөлөөлж байна. Одоогийн Монголын нөхцөлд хэн илүү олон нийтэд танигдсан байна тэр хүн ялалт байгуулах магадлал өсөх хандлагатай нь үр дүнгээс шууд харагдаж байгаа билээ. Үүний шалтгааныг сонгогчид улс төрийн сонголтын мөн чанарыг ойлгоогүй бас нэр дэвшигчийг таньж мэдэх боломж хомс байгаа учир илүүтэй олонд танигдсан тухайн сонгогчийн далд ухамсарт илүү суусан хүнийг сонгох магадлалтай байна гэж үзэж байна.

Судалгаанд оролцогчдын үр дүнгээс харахад нэр дэвшигчийн сонгогчид тойгоо холбоотой байх байдлыг хамгийн хүчтэй нөлөө үзүүлж байна гэсэн бөгөөд үүнээс үзэхэд нэр дэвшигч сонгуулийн өмнө болон дараа нь сонгогчидтой уулзалт цуглаан хийх, сошиал хэрэглээгээр дамжуулан санаа бодлын сонсох гэх мэт аргыг илүүтэй ашигласнаар ялалт байгуулах магадлал нь нэмэгддэг гэж үзэж байна.

Нэр дэвшигчийг ялалт байгуулахад нь түүний улс төрийн замнал дундаж нөлөөлнө гэсэн судалгаанд оролцогчдын үр дүнгээс харахад өмнө нь өөрийн тойрог, орон нутгийн улс төрийн байгууллагад ажиллаж байсан, тухайн тойрог, орон нутагтаа илүү бүтээмж өндөртэй ажил хийж гүйцэтгэсэн хүнийг сонгох магадлалтай гэж үзэж байна.

Харин судалгаанд оролцогчдын үр дүнгээс харахад нэр дэвшигчийн бие хүний шинж чанар болон нэр дэвшигчийн сонгуулийн кампанит ажлын менежментийг илүү сулавтар нөлөөлнө гэсэн байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд нэр дэвшигч илүү иргэд, сонгогчид уруу чиглэсэн сонгуулийн кампанит ажлын менежменттэй мөн өрсөлдөгчөөсөө нэр хүндийн хувьд илүү байх нь ялах магадлалыг нэмэгдүүлэх боломжтой болох нь ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл нэр дэвшигчийг сонгогчид хувь хүн талаас нь харахаас илүүтэй өөрсөдтэй нь илүү ойр байгаа тэдний асуудлыг шийдвэрлэхэд сонгогчидтойгоо холбоотой байх байдал нь санаа бодлыг нь сонсож, шийдвэрлэхэд илүү хялбар болгоно хэмээн үзэх нь нэр дэвшигчийн ялах магадлалын нэмэгдүүлэхээр байна. Судалгааны үр дүнг нэгтгэн авч үзвэл:

1. Нэр дэвшигчийн нэр хүнд сонгогчдын сонголтод хамгийн хүчтэй нөлөө үзүүлнэ.

2. Нэр дэвшигчийн сонгогчидтойгоо холбоотой байх байдал нь сонгогчдын сонголтод хамгийн хүчтэй нөлөө үзүүлнэ.
3. Нэр дэвшигчийн улс төрийн замнал сонгогчдын сонголтод дунджаас дээгүүр нөлөө үзүүлнэ.
4. Нэр дэвшигчийн бие хүний шинж чанар нь сонгогчдын сонголтод дундаж нөлөө үзүүлнэ.
5. Нэр дэвшигчийн сонгуулийн кампанит ажлын менежмент нь сонгогчдын сонголтод бага нөлөө үзүүлнэ.

Ном зүй

1. Д.Ганхуяг, “Монгол дахь улсын их хурлын сонгууль-сонгогчдын оролцоо”, УБ, 2008
2. Д.Гантөмөр, “Монгол дахь их хурлын сонгууль, сонгогчидын оролцоо”, УБ, 2008, Магистрын ажил
3. Д.Түмэнжаргал, “Монголын сонгуулийн систем, эрэл шийдэл”, Улаанбаатар хот (2012)
4. Баасансүрэн нар..., “Монгол улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо”, Улаанбаатар хот (2017), ху219
5. Основы теории коммуникации. Учебник./Под ред.М.А.Василики/М., 2007.с.139-150
6. Политические коммуникации:Учебное пособие/Под.ред А.И.Соловьева/М., 2004
7. Соловьев.А И.Политическая коммуникация: к проблеме теоретической идентификации// Полис.2002 №3
8. Ц.Мөнхцэцэг. Политайнмент буюу цэнгээнт улс төр.УБ.,2010 Ольшанский Д.В. Социальная психология «винтиков». // Вопросы философии. — 1989.№8.—С.91—103.
9. PR буюу олон нийтийн мэдээлэл харилцаа. УБ., 2000
10. Ц.Ганболд. Улс төрийн сэтгэл судлал ба хүчирхийллийн сэтгэл зүй. УБ., 2005

СОНГУУЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, УДИРДЛАГА

Доктор, дэд профессор Г.Баасанжав
МУИС-ийн УТСОУХНУС-ийн
Нийтийн удирдлагын тэнхимийн эрхлэгч

Сонгуулийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах төрийн байгууллагын чиг үүрэг, ангилал, сонгуулийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, тэдгээрийн хэрэгжүүлэлтийг энэ бүлгээр илэрхийлэх зорилготой. Сонгуулийн үйл ажиллагааг улс орны улс төр, нийгмийн нөхцөл байдлаас хамааран ялгаатай байгууллага, институци удирдан зохион байгуулдаг. Ардчилал хөгжсөн улс орнуудын сонгуулийн төв байгууллага нь хараат бусаар үйл ажиллагаагаа явуулна.

Улс орнуудын сонгуулийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах төв байгууллагын чиг үүрэг, эрх зүйн байдлыг холбогдох хуулиар баталгаажуулсан бие даасан, намын харьяалалгүй, хараат бус байхаар хуульчилна. Сонгуулийн үйл ажиллагааг үндсэн хууль, сонгуулийн тухай хууль, болон холбогдох хуулиудаар зохицуулна. Зарим улс орнууд сонгуулийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохицуулсан байдаг бол бусад нь муж улсын түвшинд ялгаатай хууль, журмаар зохицуулж ирсэн байна. Гэхдээ эдгээрийн аль ч хувилбар нь ардчилсан зарчимд тулгуурлах ба сонгуулийн бүхий л үйл ажиллагааг цогцоор нь хамруулна. Сонгуулийн хууль эрх зүйн зохицуулалт нарийн тодорхой, энгийн ойлгомжтой байна. Зарим тохиолдолд сонгуулийн үйл ажиллагааны зохицуулалт, эрх зүйн шинэтгэл нь хуулийн зүйл заалтын тоог нэмэгдүүлэхэд бус сонгуулийн үйл ажиллагааны зохицуулалтыг оновчлон, улмаар зүйл заалтуудыг багасгахад чиглэгддэг.

Сонгуулийн хуульд дараах элементүүдийг тусгана. Үүнд: (i) сонгууль удирдан зохион байгуулах байгууллагын бие даасан байдал, харьяалал, (ii) сонгуулийн хорооны бүрэн эрх, мэдэл, төсөв хөрөнгө хэрхэн зохицуулагдах тухай, (iii) сонгуулийн тогтолцоо, сонгуулийн ардчиллыг хангах эсэх, (iv) эрх мэдлийн тэнцвэр, хуваарилалтын тогтолцоог баталгаажуулж буй эсэхийг багтаана.

Сонгуулийн үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах байгууллагын үндсэн гурван загвар байна. Үүнд :

1. Бие даасан: Сонгуулийн төв байгууллага үндсэн хуулийн болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулагдах,
2. Хараат бус: Сонгуулийн төв байгууллага хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд хараат бусаар байгуулагдах,
3. Холимог: Ихэнхдээ хоёр өөр институци (тухайлбал шүүх засаглалын харьяанд гэх мэт)-н харьяанд байх ба сонгуулийн удирдлага, зохион байгуулалтыг эдгээр байгууллагын төлөөлөл хангаж ажиллана.

Сонгуулийн үйл ажиллагааг удирдах зохион байгуулах байгууллагыг тодорхой шалгуурын дагуу ангилна. Сонгуулийн төв байгууллагын удирдлагыг хэрхэн сонгон шалгаруулах, томилж буйгаас хамааран:

- Гүйцэтгэх засаглалын хандлага – байгууллагын удирдлага нь энгийн төрийн албан хаагч байх,
- Шүүх засаглалын хандлага – шүүгч сонгуулийн байгууллагыг удирдахаар сонгогдох,
- Олон намын хандлага – намын төлөөлөгч сонгуулийн байгууллагын удирдлага байх,
- Экспертийн хандлага – нэр алдар бүхий хүмүүсийг улс төрийн намууд харилцан зөвшилцсөнөөр томилох онцлогтой.

Сонгуулийн төв байгууллагын эрх зүйн байдал, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг холбогдох хуулиар зохицуулна. Ихэнх улс орнуудын сонгуулийн хууль ардчилсан сонгууль явуулах тохиромжтой байдал болон нийтийн итгэлийг хангасан байна. Бүгд Найрамдах Турк Улс болон Азербайжан зэрэг улс орнуудад сонгуулийн өмнө болон дараа үе шатанд хүний эрх улс төрийн оролцоо зарим хэмжээгээр хязгаарлагдсан сонгуулийн ардчилал алдагддаг шинж чанартай.

Сонгуулийн үйл ажиллагааны төлөвлөлт, удирдлага

Сонгуулийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлаас тухайн сонгууль амжилттай явагдах эсэх нь ихэд шалтгаална. Энэ нь цаг хугацаа, хүний нөөц маш ихээр шаардагдах нүсэр ажил юм. Иймээс сонгуулийн үйл ажиллагааны бэлтгэлийг хангах, төлөвлөлтийг сайн гүйцэтгэх нь нэн чухал. Сонгуулийн байгууллагад ажиллагсдын мэдлэг, чадвар, төвийг сахисан байдал чухал. Сонгуульд нэр дэвшигчийн харьяаллаас үл хамааран бүх нэр дэвшигчдэд адил, тэгш нөхцөлийг олгох үүрэгтэй.

Сонгуулийн үйл ажиллагааг сайтар, нарийн төлөвлөх нь үүсэж болох хүндрэл бэрхшээлээс сэргийлнэ. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь үйл явцыг бүхэлд нь багтаасан, нээлттэй, ил тод байдлаар боловсруулан хэрэгжүүлнэ.

Сонгуулийн хороог байгуулах, сонгогчдын жагсаалт гаргах, санал авч дүнг нэгтгэн гаргах, сонгогдсон албан тушаалтнуудыг тангараг өргүүлэх бүхий л үйл ажиллагааг цогцоор хамруулна. Түүнчлэн сонгуулийн хороонд ажиллагсдыг сонгон шалгаруулах, сургах, сонгогдсон сонгуулийн боловсрол олгох, сонгогчдын нэрсийн жагсаалт гаргах, сонгуулийн дараах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг багтаана.

Сонгогчдын нэрсийн жагсаалт гаргах

Сонгогчдын жагсаалт гаргах хэд хэдэн аргууд байна. Нэгдүгээрт сонгуулийн үйл ажиллагаанд оролцон санал өгөх сонгогчдын жагсаалтыг захиргааны зориулалтаар ашигладаг хүн амын тооллогын мэдээлэл, тайланд үндэслэн сонгогчдын жагсаалтыг идэвхтэй бус хэлбэрээр гаргана. Гэхдээ гадаадад амьдарч, оршин сууж буй иргэд өөрсдийгөө сонгуульд бүртгүүлснээр, актив бүртгэл хийгдэнэ.

Бүгд Найрамдах Серби Улс болон Бүгд Найрамдах Австри Улс зэрэг улсууд сонгогчдын бүртгэлийг тогтмол шинэчлэн, тодорхойлсон бүртгэлийн системтэй. Үндэсний хэмжээний сонгуульд энэхүү бүртгэлийн системийн өгөгдөлд суурилан сонгогчдын жагсаалт гаргах бол зарим улс орнууд (тухайлбал Бүгд Найрамдах Чех Улс) нэгдсэн сан, дата байхгүй тул орон нутгийн хэмжээнд сонгогчдын жагсаалт гаргана.

Сонгогч иргэний хувийн мэдээллийг алдагдуулахгүй байх зорилгоор эдгээр жагсаалтад нэвтрэх эрхийг чанга хатуу байлгана. Өөрөөр хэлбэл сонгогч иргэн өөрийн мэдээллээ шалгах, хянах боломжтой. Нөгөө талаар сонгогчдын жагсаалтыг нийтэд ил тод мэдээлдэг улс орнууд байх ба ил тод байдал нь уг жагсаалтын үнэн зөв, нарийвчлалыг нэмэгдүүлнэ хэмээн үзнэ. Эдгээр мэдээллийг улс төрийн зорилготой сонгуульд нэр дэвшигч намууд ашиглахгүй байхад анхаарна. Эрх бүхий байгууллагад сонгуулийн насны иргэдийн мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Нам эвсэл, нэр дэвшигчийн бүртгэл, хяналт, тайлан

Хуульд заасан хугацааны дагуу сонгуульд оролцохоор ирүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчдийн хүсэлтийг хүлээн авч, сонгуульд оролцох эсэх тухай шийдвэр гаргана. Нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн лавлагаа гаргах, нэр дэвшигчийн үнэмлэх олгох, мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах, хандивын тайланг хүлээн авч дүгнэлт гаргах, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаа явуулсан тайланг хүлээн авч, хянах зэрэг үйл ажиллагааг сонгуулийн төв байгууллага, сонгуулийн хороод, холбогдох төрийн захиргааны байгууллагууд үйл ажиллагааны чиг үүргийн дагуу хэрэгжүүлдэг.

Сонгогчдыг мэдээллээр хангах

Сонгуулийн хороод нь сонгуулийн үйл явцын талаар мэдээллийг сонгогчдод хүргэнэ. Сонгуулийн талаар мэдээллийг иргэдэд олгохыг боловсролын системээр

дамжуулан олгох нь түгээмэл. Тухайн иргэний боловсролын хөтөлбөртэй уялдуулан, сонгуулийн холбогдолтой асуудлаар зааварчилгаа олгон, сонгуулийн боловсрол олгоно. Сонгогчдын боловсролын хөтөлбөрүүд нам бус, төвийг сахисан байх шаардлагатай. Хэвлэл мэдээллээр дамжуулан сонгуулийн бэлтгэл ажил, үйл явцын ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлнэ. Нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөртэй танилцан, сонголт хийхэд шаардагдах мэдээллийг сонгогчдод хүргэнэ.

Санал авах, үр дүнг нэгтгэх, ялагчийг тодруулах

Сонгуулийн үйл ажиллагааг хуулиар зохицуулах боловч, санал хураах, тоолох зэрэг үйл ажиллагааг зохицуулсан журмыг батлан гаргана. Санал хураах үйл явц нь сонгуулийн үйл ажиллагааны чухал хэсэг билээ. Энэхүү үйл явцыг урьдаас сайтар, нягт төлөвлөснөөр алдаагүй, маргаангүй явуулах боломжтой. Санал авах үе шатыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараах бэлтгэл ажлыг хангах шаардлагатай. Хэдэн сонгогч, хаана амьдарч байгаа мэдээллийг газар зүй, нутаг дэвсгэрийн онцлог, дэд бүтцийг харгалзан тодорхойлох; санал авах байруудын байрлалыг төвийг сахисан, сонгогч очиход дөхөм, нууцлал хадгалсан тодорхойлох; сонгуулийн хуудасны загварыг хэзээ гаргах, захиалах, сонгуулийн хэсгүүдэд хэдэн өдрийн өмнө хүргэгдсэн байх, сонгуулийн ажилтнуудыг хэзээ ажилд оруулах, сургалтад хамруулах хуваарийг гаргах; сонгуулийн ажилтнуудыг дайчилж, сургалтад хамруулах шаардлагатай. Улс төрөөс хараат бусаар сонгуульд ажиллагсдыг сонгон шалгаруулж, тэдний гүйцэтгэх ажил, чиг үүргийг нарийн тодорхойлж өгснөөр гадны нөлөөллөөс сэргийлнэ. Зарим улс орнуудад сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд намын тэнцвэрийг хангасан байхыг шаардана. Эдгээрийг гарын авлага байдлаар хэвлэн, сонгуулийн ажилтнуудын сургалтад хэрэглэнэ.

Сонгуулийн товын дагуу сонгогч өөрийн саналыг өгөх боломжийг сонгуулийн хороо хангана. Санал авах үе шатанд:

- Сонгогчдын ирц,
- Нэр дэвшигчдийн талаар мэдээлэлтэй,
- Санал өгөх үйл явц сонгогчдод хүндрэл, чирэгдэлгүй,
- Саналын нууцлал хангагдсан байх,
- Сонгуулийн үйл ажиллагаанд техник хэрэгслийг ашиглах,
- Ажиглагч, хянагч, хэвлэл мэдээллийнхэнд итгэмжлэл олгосон байх
- Санал авах байр, сонгуулийн үйл ажиллагаанд бүхэлд нь аюулгүй байдлыг хангах,
- Алдаа гаргахгүй байхад анхаарч ажиллана.

Сонгуулийн хороо хуулийг хэрэгжүүлэх үүднээс гаргасан журам нь

сонгуулийн ажилтнуудын үйл ажиллагааг зохицуулах ба журмыг хэрэгжүүлэх механизм ба хүлээлгэх хариуцлага, торгууль, шийтгэлийг тодорхой заасан байдаг. Санал авсны дараагаар нийт саналын хуудас, хүчинтэй саналын хуудас, дүнг нэгтгэсэн маягтыг сонгуулийн анхан шатны байгууллагаас дээд шатны байгууллагад ирүүлэх процессыг алдаа мадаггүй зохион байгуулах явдал юм.

Сонгуулийн хороо санал тоолох, үр дүнг нэгтгэх үйл ажиллагааг гадны нөлөөгүй, алдаагүй, гадны оролцооноос ангид байхаар зохион байгуулна. Сонгуулийн дүнг нэгтгэн тохиромжтой маягтуудыг бөглөн, дүнг нэгтгэн бүсийн болон үндэсний хэмжээнд нэгтгэн, тайлагнана. Сонгуулийн хороо анхан шатны нэгжтэй шууд холбогдох боломжийг бүрдүүлж, харилцаа холбоо, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангана. Сонгуулийн албан ёсны дүнг зарлан, ялагчийг тогтоох нь сонгуулийн зохион байгуулалтын чухал үе шат юм. Тооллогын албан ёсны үр дүнг болон ялагчийг тодруулах процессыг хурдан шуурхай зохион байгуулснаар аливаа, алдаа эрсдэлээс сэргийлж, сонгогчдын итгэлийг нэмэгдүүлнэ.

Сонгуулийн үйл ажиллагаанд цахим технологи ашиглах

Сонгуулийн үйл ажиллагааг төлөвлөлт сайтай, зохион байгуулалттай явуулах зорилгоор технологийн дэвшил, цахим технологийг улс орнууд ашиглана. Энэтхэг, Бразил, Бельги зэрэг улс орнууд сонгуулийн үйл ажиллагааны зохион байгуулалтад техник хэрэгсэл (тоологч машин) ашиглах болсон.

Сонгуулийн үйл ажиллагаанд ашиглагдах цахим технологи:

- Сонгогчдын бүртгэлийн систем:
- Сонгогчдыг таних систем:
- Нам, нэр дэвшигчдийг дэмжих систем:
- Ажиглагчдыг бүртгэх, баталгаажуулах систем:
- Тойргийн хил хязгаарыг тодорхойлох систем:
- Цахимаар санал өгөх, саналыг тоолох систем:

Сонгуулийн үйл ажиллагаанд цахим технологийг ашиглахад мэдээллийн аюулгүй болон найдвартай байдлыг хангаж, техникийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хангаж, техник хэрэгслийг ашиглах явцад гарах аливаа алдаа, зөрчлөөс сэргийлэх үйл ажиллагааг хууль, эрх зүйн хүрээнд зохицуулна.

Сонгуулийн үйл ажиллагааны зарчим

Сонгуулийн үйл ажиллагааны зарчмыг судлаачид тогтоон илэрхийлсэн. Тухайлбал судлаач Farrel сонгуулийн үйл ажиллагааны ил тод, үр ашигтай, үнэн

зөв, нээлттэй байх зарчмыг онцолсон бол Европын холбооны гишүүн улсууд сонгуулийг төвийг сахисан, шударга, ил тод зарчимд суурилан зохион байгуулахыг чухалчилсан. Сонгуулийн үйл ажиллагааг хууль дээдлэх, ил тод байдлыг хангах, шударга ёсыг сахих зарчимд суурилан хэрэгжүүлнэ.

Сонгуулийн байгууллагын үйл ажиллагаанд тавигдах үндсэн таван зарчимтай. Эдгээр нь :

- Бие даасан байх: сонгуулийн байгууллагын шийдвэр гаргах эрх, эрх зүйн байдлыг хангах,
- Шударга байх: үйл ажиллагааг гадны нөлөөллөөс ангид, шударгаар явуулах,
- Ил тод байх: мэдээллийг холбогдох талуудад нээлттэй олгох,
- Мэргэшсэн байх: сонгуулийг үр дүнтэй, үр ашигтай удирдах,
- Тогтвортой байх: цаг хугацааны явцад сонгуулийн байгууллагын чиг үүрэг, ажиллагсад тогтвортой байх,

Бие даасан байх: Сонгуулийн байгууллага нь институцийн бие даасан байдлыг хангаж, Засгийн газар, улс төрийн нам, сонирхлын бүлэг, сонгуульд нэр дэвшигчдийн хөндлөнгийн оролцооноос ангид үйл ажиллагаа явуулна.

Шударга байх: Сонгуулийн үйл ажиллагааг хуульд нийцсэн, шударгаар явуулна. Улс төрийн нам, нэр дэвшигчдийн намын харьяалал, статусаас үл хамааран оролцогчдод адил, тэгш нөхцөлийг олгоно. Ялангуяа засгийн эрхийг барьж буй намын гишүүдэд ямар нэгэн давуу эрх олгохгүй.

Ил тод байх: Сонгуулийн төв байгууллагын ил тод байдлыг дараах элементүүдэд суурилан хангана. Үүнд :

- Сонгуулийн үйл ажиллагааны бүхий л үе шат, шийдвэр гаргалтыг нийтэд мэдээлэх,
- Улс төрийн намуудын жигд оролцоог дэмжих,
- Хэвлэл мэдээллийн оролцоо, иргэн, иргэний нийгмийн оролцоог системтэй хангах,
- Сонгогчдын боловсролыг нэмэгдүүлэх, сонгогчдод мэдээллээр хангах,
- Сонгуулийн үйл ажиллагааны шударга байдалд итгэх талуудын итгэлийг нэмэгдүүлэх идэвхтэй хандлагыг ашиглах.

Сонгогчдын саналын шударга байдлыг хүндэтгэх ба тэдний саналын үр дүнг түргэн шуурхай, давтамжтай байдлаар нарийвчлан үр дүнг нь илэрхийлнэ.

Мэргэшсэн байх: Сонгуулийн үйл ажиллагааны үр дүнтэй, үр ашигтай байдлаар илэрхийлэгдэнэ. Сонгууль нь улс орны иргэдийн энх тайван байдлыг илэрхийлэхэд чухал байдаг энэхүү цогц үйл ажиллагааг удирдан явуулах байгууллагын ажиллагсад ур чадвар өндөртэй байхыг шаардана. Сонгуулийн байгууллагын ажиллагсдыг үе шаттай сургалтуудад хамрагдуулан мэргэшүүлнэ.

Тогтвортой байх: Сонгуулийн байгууллагын бие даасан байдал, үйл

ажиллагааны ил тод байдал, ажиллагсдын мэргэшсэн байдлыг хангахын сацуу тухайн байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах шаардлагатай. Сонгуулийн байгууллагын санхүүгийн болон техник, технологийн тогтвортой байдлыг хангана.

Сонгуулийн байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн болон техникийн тогтвортой байдлыг хангахад дараах үзүүлэлтүүдийг хангаж ажиллах шаардлагатай. Үүнд :

- Төлөвлөгөө, стратегийн зорилго сайн байх,
- Зохих ур чадвар бүхий хүний нөөц хангалттай,
- Дэд бүтэц тохиромжтой,
- Техник, технологийн сонголт бодитой,
- Санхүү, төсөв хүрэлцээтэй,
- Гадаад эх үүсвэр, нөөцөөс хамаарал бага байх шаардлагатай.

Сонгуулийн үр дүнг бүхий л оролцогч талууд хүлээн зөвшөөрөх байдлаар тогтвортой байдал хангагдана. Сонгуулийн үйл ажиллагааг шударгаар явуулах улс төрийн хүсэл, эрмэлзэлтэй, гол оролцогч талууд сонгуулийн үйл ажиллагаанд бодит итгэл хүлээлгэсэн, нийгмийн тэгш байдал, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангасан, зөрчилдөөн, улс төрийн оролцоо бага үед сонгуулийн үйл ажиллагааны тогтвортой байдал хангагдана.

Ном зүй

1. Abubakar Sodeeq Suleiman: “The Role of Technology in Election management with example from five democracies”, 2021.
2. David Matthew Farrel: “Electoral systems and Election Management”, 2010.
3. European Commission for Democracy through Law: “Ensuring Neutrality, Impartiality and Transparency in Elections: The Role of Electoral Management Bodies”, 2015.
4. European Commission for Democracy through Law: “Report on Electoral law and electoral administration in Europe, 2020.
5. Oliver Joseph: “Independence in Electoral Management”, IDEA, 2021.
6. UNDP: “Electoral Management Bodies as Institutions of Governance”, 2000.
7. UNDP: “Principals for Independent and Sustainable Electoral Management”, 2012.
8. Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, 2019, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14869>
9. Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, 2006, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=459>
10. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль, 2011, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=458>

СОНГОГЧДЫН УЛС ТӨРИЙН СОЁЛЫН ХАНДЛАГА

Доктор О.Хатанболд
ШУА-ийн Философийн хүрээлэнгийн
Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч, ЭШТА

Д.Уртнасан
МУИС-ийн УТСОУХНУС-ийн
Улс төр судлалын тэнхимийн багш

Оршил

Улс төрийн соёл нь тухайн улс, үндэстний улс төрийн тогтолцооны мөн чанарын талаарх өргөн тархсан итгэл үнэмшил, мэдрэмж, үнэлэмжийг хамруулсан ойлголт бөгөөд иргэн, төрийн харилцааны хоорондын холбоос болж, улс төрийн тогтолцооны тогтвортой байдлыг хангахад чухал нөлөөтэй. Харин сонгогчдын улс төрийн соёлын судалгааны нь ардчиллын судалгаанд чухал байр суурь эзэлсээр ирсэн чиглэл бөгөөд ардчиллын судалгааны шинэ үзэл баримтлал, хандлагыг судлахад сонгуулийн үйл явц, түүнд холбогдох талуудын хоорондын уялдааг харгалзах үндсэн хүчин зүйлсийн нэг болдог. Иймд дэлхий нийтийн сонгогчдын ерөнхий шинж чанар, ялгаатай ба нийтлэг хандлага, эдгээрийг бүрдүүлдэг хүчин зүйлс, сонгуулийн үйл явцад оролцох оролцоо, ойлголтын өөрчлөлтийг харуулсан сүүлийн үеийн дүр төрхийг судлах нь чухал байна.

Түлхүүр үг: сонгогч, сонгууль, улс төрийн соёл, сонгогчдын улс төрийн соёл, ардчилал

Үндсэн хэсэг

Ардчиллыг хэмжих, тодорхойлох төлөөллийн ардчиллын судалгаа гол төлөв Роберт Далийн ардчиллын онолд тулгуурладаг. Нэг үгээр иргэд өөрсдийн мөнхүү давуу талуудыг ижил тэгш хуваарилах “институционал баталгаа”-г шаарддаг” (Dahl, 1971) хэмээн үзсэн байдаг. Эдгээр баталгаанд:

1	институци байгуулах
2	нэгдэх эрх чөлөө
3	үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө
4	сонгох эрх
5	төрийн албан тушаалд томилогдох
6	улс төрийн дэмжлэг авахын төлөө өрсөлдөх эрх
7	мэдээллийн өөр эх сурвалж
8	чөлөөт, шударга, хараат бус сонгууль

Иргэдийн төлөөллийн институтээ байгуулах гол арга нь сонгууль байдаг учраас сонгуулийн үйл явц нь төлөөллийн ардчиллын гол индикаторуудын нэг болдог. Харин сонгуулийн үйл явц нь нэг талаас бүтэц, зохион байгуулалттай холбогдох боловч түүний үндсэн нөхцөл нь сонгогчдын улс төрийн үйл байдал, соёлын түвшнээс шууд хамаардаг гэж болно. Угтаа сонгууль бол ардчиллын гол үнэт зүйлс бөгөөд хүн төрөлхтний түүхэнд төр улс үүссэн цаг үеэс уламжлан хэрэглэгдэж ирсэн төрийн байгууллагын бүтцийг бүрдүүлэх, түүний албан ёсны легитимт байдлыг хангах сонгодог арга зам болж байв. Эртний Грек, Ромын үед сонгуулийн талаар нарийн цэгцтэй мэдлэг төсөөлөл бага байсан ч түүнийг улс төрийн практикт ямар нэг байдлаар хэрэглэж байсан түүхэн баримт байдаг. Хүн төрөлхтнийг улс төрийн амьдралын үзэгдэл, үйл явц боловсронгуй болж, парламентат ёс, улс төрийн нам байгуулагдан, иргэдийн сонгуулийн эрх улам тэлэхийн хэрээр сонгуулийг орчин үеийн улс төрийн практикт ардчиллын тогтвортой үнэт зүйлсийн түвшинд хүлээн зөвшөөрч, өргөн хэрэглэх болсон.

Орчин үед сонгуулийг олон янзаар тайлбарладаг ч улс төрчид, судлаачид түүнийг нэгд, улс төрийн сонголтын арга хэлбэр; хоёрт, улс төрийн оролцооны хэлбэр; гуравт, улс төрийн өрсөлдөөнт үйл ажиллагаа; дөрөвт, төрийн байгууллагын бүтцийг бүрдүүлэх арга; тавд, төрийн засаглал, эрх мэдлийн легитимт байдлыг хангах арга хэмээн үздэг байна. Чингэхээр төр бодитой оршин үйлчлэхийн тулд өөрийн хууль ёсны легитимт байдлыг олж авах, түүнийг тогтвортой хадгалах шаардлагатай болдог. Үүнийг германы социологич М.Вебер төр, засгийн хууль ёсны байдлыг хүлээн зөвшөөрөх гурван төрлийн түүхэн хэлбэр байдгийг судлаж тогтоосон нь уламжлалт - харизматик - рациональ эрх зүйн буюу ардчилсан хэлбэр юм. Тэдгээрийн дотроос төрийн хууль ёсны дагуу хүлээн зөвшөөрүүлэх орчин үеийн ардчиллын хамгийн сонгодог арга зам нь сонгууль болохыг М.Вебер онцлон тэмдэглэжээ¹. Иймээс сонгууль гэдэг нь хүмүүсийн улс төрийн сонголт хийх үйл ажиллагаа юм. Улс төрийн сонголт хийнэ гэдэг нь хүмүүс, улс төрийн тодорхой субъектүүд улс төрд туйлын идэвхтэй оролцож байгаа хэрэг. Тиймээс судлаачид сонгуулийг хүмүүсийн улс төрийн оролцооны тодорхой хэлбэр, улс төрийн сонголтын хамгийн зохистой бөгөөд бодитой арга механизм хэмээн нийтээр хүлээн зөвшөөрөх болсон.

Харин Ж.Шумпетер өнөөгийн ардчиллын хүрсэн түвшнийг тодорхойлох нэг үндсэн шалгуур нь сонгууль гэж үзээд “сонгуульт ардчилал”-ын тухай үзэл санааг дэвшүүлсэн. Тэрээр сонгуулиас ардчилсан тогтолцооны бусад шинжүүд урган гардаг гэж үзэн ардчилал бол “өрсөлдөөний замаар ард түмний саналыг авсны үндсэн дээр бие хүн, байгууллага нь төр, засгийн шийдвэр гаргахад оролцох эрх мэдэлтэй болсноор улс төрийн шийдвэрт нөлөөлдөг”² тогтолцоо хэмээн онцолсон байдаг.

1 Макс Вебер. Улс төр бол мэргэшил мөн, шинжлэх ухаан бол мэргэшил мөн. Уб., 2000


2 Hans-Joachim Lieber. Politische Theorien von der Antike bis zur Gegenwart. Bundeszentrale fuer politische bildung, Band 299, S.709

Өнөө үед ардчилсан сонголтын үр дүнд төрийн ардчилсан институтын бүтэц бүрдэж бий болдог. Харин сонгуулиас гадуур бүрдэж бий болсон аливаа төр засаг хууль бус юм. Сонгууль нь ардчилсан төр, засгийн бүтцийг бүрдүүлэх хамгийн оновчтой ардчилсан арга хэрэгсэл болж, улс төрчид, нам, хүчнийг эрх мэдэлтэй холбогч гол механизм нь сонгууль болдогоос түүнийг тойрсон онол, практикийн олон асуудал үүсэн гардаг билээ. Нэг үгээр бол иргэдийн улс төрийн конвенциональ оролцооны онцгой хэлбэр нь тэдний сонгуулийн оролцоо бөгөөд тухайн иргэн сонгогч сонгуульд идэвхтэй оролцон саналаа өгч байгаа нь тэдний улс төрийн оролцоо, идэвхийн тодорхой илэрхийлэл болдог. Тэгэхээр иргэдийн сонгуулийн оролцоо, тэдний санал өгөх үзэгдлийг тусгайлан судалдаг мэдлэгийн салбарыг псефологи хэмээдэг. Псефологи нь сонгууль, сонгогчийн харилцан хамаарал, шалтгаан нөхцөл болон иргэдийн сонгуулийн оролцооны цогц асуудлыг үндсэн судлагдахуун болгодог сонгуулийн социологийн нэг төрөл салбар. Сонгуулийн социологи буюу псефологийн судалгаа нь анх өрнөдийн орнуудад хийгдэж эхэлсэн бөгөөд XX зууны эхний хагаст бие даасан салбар болон хөгжсөн. Судлаачид иргэдийн сонгуулийн оролцоог улс төрийн үйл байдалтай нь холбон хүн ам зүй, эдийн засаг, улс төрийн орчин нөхцөл, амьдралын хэв маяг, сэтгэлгээний онцлог зэрэг хүчин зүйлтэй харьцуулан судлахыг хичээж ирсэн байдаг. Үүнийг ч энэ удаагийн өгүүлэлд тодорхой асуудлуудад тулгуурлан авч үзэхийг хичээсэн болно.

Сонгууль болон сонгогчдын зан үйлийн судалгааны нэлээд төвөгтэй, хамгийн их анхаарал хандуулдаг сэдэв бол сонгогчдын ирц бага буй шууд холбогдоно. Сонгогчдын ирцийн мэдээллийг Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэн³ (International IDEA)-гийн мэдээллийн санд үндэслэн тодруулахыг зорив. Тус мэдээллийн сан нь 1945 оноос хойших дэлхийн улс орнуудад явагддаг ерөнхийлөгчийн болон парламентын сонгууль дахь сонгогчдын ирцийн статистикийг өргөн хүрээнд хамруулан багтаасан байдаг. Тодруулбал, сүүлийн үеийн хүн амын тооллогын тоо баримтад үндэслэсэн сонгуулийн насны хүн ам (VAP), мөн бүртгэлтэй сонгогчдын тоо (REG) зэргийг улс төрийн оролцооны үзүүлэлт болгон ашигладаг.

3 Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэн (International IDEA) нь дэлхий даяар ардчиллыг дэмжин ажилладаг засгийн газар хоорондын байгууллага. Тус байгууллага нь ардчилсан шинэчлэлд тус дөхөм үзүүлж, харьцуулсан мэдлэгийг хөгжүүлэх, туршлагаа хуваалцах, харилцан ашиглах боломжийг олгох замаар дараах 6 чиглэлд буюу (i) сонгуулийн үйл явц; (ii) үндсэн хууль бүтээх; (iii) ардчиллын үнэлгээ; (iv) улс төрийн оролцоо ба төлөөлөл; (v) уур амьсгалын өөрчлөлт ба ардчилал; (vi) дижиталчлал ба ардчилал зэрэг хүрээнд олон улсын судалгаа явуулдаг.

Зураг 1. Сонгуулийн ирцийн мэдээлэл, 2022 он



Эх сурвалж: <https://www.idea.int/news/more-effort-needed-open-election-data-globally>

Судалгааны үр дүнгээс харахад, 2022 онд болсон сонгуулиудын сонгогчдын ирц нийт 9 улсад өмнөх онтой харьцуулахад нэмэгдэж, 27 улсад буурсан байна. Мөн 2022 оны дэлхий нийтэд болсон сонгуулийн ирцийн дундаж үзүүлэлт 64.5 хувьтай байсныг энд дурдах нь зүйтэй хэмээн үзэв.

Сонгуулийн ирцийн мэдээлэл хангалтгүй байгаа тохиолдлуудад Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэн (International IDEA)-ийн шинжээчид дараах байдлаар дүгнэлт хийсэн байна. Үүнийг тодруулбал,



Сонгуулийн ирцийн болон бусад мэдээллийг нээлттэй болгосноо сонгуулийн үр дүнд итгэх итгэл нэмэгдэх улмаар сонгогчийн бүртгэлтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжийг бүрдүүлнэ. Нөгөө талаар улс төрийн намууд, тэдгээрийн нэр дэвшигчдэд сурталчилгаагаа оновчтой болоход туслах, сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн зардлыг тооцох, мөн оролцогч талуудын итгэлцэл, ил тод байдлын орчныг бүрдүүлэх, ардчилсан институци болон сонгогчдын соёлыг төлөвшүүлэхэд нөлөөлдөг.

Сонгогчдын улс төрийн соёлд нөлөөлөх хүчин зүйлс болоод түүний хүрээнд хийгдэж буй судалгааны хандлагыг дараах гурван чиглэлд авч үзэж дүн шинжилгээг хийв.

Зураг 2. Сонгогчдын улс төрийн соёлд нөлөөлөх хүчин зүйлс ба судалгааны хандлага



Улс төрийн тогтолцооны хүрээнд сонгогчдын улс төрийн соёлд нөлөөлж буй хүчин зүйлсийг судалгаанд хамгийн ихээр дурдсан илэрхийлэмжийг тодруулбал, улс төрийн хөгжил, улс төрийн дэглэм, хууль эрх зүйн тогтолцооны асуудлуудтай шууд холбогдож байв. Тухайлбал, Липсетийн модернизаiczлалын онол (Lipset, 1959) нь технологийн шинэчлэл, бүтээмж, мэргэжлээрээ мэргэшсэн байдал, хотжилт, соёлын үнэт зүйлс зэрэг хүчин зүйлсийг нийгмийн хөгжилд нөлөөлдөг талаас нь түлхүү авч үзсэн байх жишээтэй. Мөн нийгэмд хөдөө аж ахуйгаас аж үйлдвэржсэн капиталист нийгэм рүү шилжих шилжилтийг хамарсан модернизацийн үйл явц явагдаж байгаа тул дарангуйллаас ардчилал руу шилжих шилжилт эдгээр өөрчлөлтийг дагалдан явагддаг болохыг ч мөн агуулсан байна. Учир нь үйлдвэржилт олон нийтийн хөдөлгөөнийг хөгжүүлэхийн тулд эвлэлдэн нэгддэг ажилчин ангийг бий болгодог хэмээн үзвэл, эдийн засгийн өсөлтийн түвшин, бичиг үсэг тайлагдалт түүний мэдлэг, технологи нь сонгогчдын үйл байдалд шууд нөлөөлдөг нь тодорхой зүйл. Харин хөгжлийн түвшний хувьд сонгогчдын соёлд хүчтэй нөлөөлдөг зүйл бол тэдний сонгуулийн зан төлөв бөгөөд эл соёл нь нийгмийн хөгжлийг урагшлуулах хөгжлийн бодлогыг тодорхойлох эрх мэдэлтнийг сонгох суурь нөхцөл болдгоороо онцлог.

Дээрхийг тодруулбал, улс төрийн дэглэмийн ерөнхий бүтэц нь улс төрийн тогтолцооны үйл ажиллагааны ерөнхий динамик байдалд гүнзгий нөлөө үзүүлэх магадлалтай. Тиймээс тухайн улс орон цаашлаад бүс нутгийн улс төрийн дэглэм, түүхийн өргөн хүрээний шинж чанарууд нь сонгогчдын туршлагыг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй (James & Garnett, 2023) болох нь илэрхий. Дэлхий даяар явагддаг V-Dem, Democracy Index, Freedom Index зэрэг ардчиллыг судалдаг судалгаануудын сүүлийн 5 жилийн дүнгээс харахад улс орнууд ардчилсан дэглэмээс илүү ардчилсан бус дэглэм рүү шилжих хандлага түгээмэл ажиглагдаж байна. Энэ үйл явцад улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал ихээхэн нөлөөтэй байна. Улс төрийн институцийн үйл ажиллагааны нөлөөллөөс гадна үүнийг эсэргүүцэхээс илүүтэй хүлээн зөвшөөрөх, үйл явцыг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг дэмжих хандлагатай иргэд, сонгогчдын үйл байдал ихээхэн нөлөөтэй болох нь ажиглагдсан. Автократ дэглэмүүд болон тус дэглэмд шилжиж буй улс орнуудын хувьд тэдгээрийн эрх баригчид нь өөрсдийн засаглалаа хадгалах олон нөөц хэлбэрүүдийг багтаасан байдаг. Тухайлбал албадлагын нөөцөөс илүүтэйгээр эдийн засгийн нөөц, соёл – мэдээллийн нөөц, социал нөөцүүдийг давуу ашиглах байдлаар сонгогчдыг татах, цаашлаад өөрсдийн дэмжигчдийн бааз суурийг илүү баталгаатай бүрдүүлэх, нөөц боломжийг бүрдүүлснийг энд дурдаж болно.

Өнөөгийн эрх баригчдын хувьд, сонгуулийн өмнө өөрсдийн ашиг тусын төлөө сонгуулийн хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар сонгуулийн орчинд нөлөөлөх стратегийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг. Тухайлбал,

сонгогчдын нэрсийн жагсаалтаас нэрийг хасах, санал өгөхөд хүндрэл учруулах зэрэг сонгогчдыг дарангуйлах тактикаар тодорхой хувь хүн, бүлгүүдийг сонгуульд нэр дэвших, санал өгөхөөс урьдчилан сэргийлэх оролдлого (James & Garnett, 2023)-уудыг хийхийг урьтал болгодог. Үүний үр дүнд өрсөлдөөн, иргэний эрх чөлөөг хязгаарлах зэргээр одоогийн эрх баригчдын баримталж буй бодлого, дэглэмийг дэмжих шахалтад өртүүлэх замаар илүү олон сонгуулийн үр дүнд нөлөөлөх хуулийг бий болгож, улмаар сонгуулийн оролцогч талуудын үйл ажиллагааг зохион байгуулахад нөлөөлөл үзүүлдэг гэж хэлж болно. Хуулийн хязгаарлалт нь түүнийг зөрчвөл ирэх шийтгэлийн арга хэмжээнээс айх нөхцөлийг бүрдүүлэх замаар сонгогчдыг байнгын дарамт түгшүүрт автуулах арга барилыг баримтална. Энэ бол сонгуулийн үр дүнд эргэлзэх эргэлзээнээс улбаалан сонгогчдын саналаас татгалзах, сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй байх улс төрийн хүнийслийн нөхцөлийг бий болгоход шууд болон шууд бус замаар нөлөөлөх хандлагыг бий болгодог байна.

Хууль, эрх зүйн тогтолцоон дахь улс төрийн зохист оролцооны хэлбэрийг сонгуулийн хууль тогтоомжид бүрдүүлэх замаар сонгуультай холбоотой сонгогчдын үйл байдлыг илүү тодорхойлсон бүтцийг бий болгох явдал ихээхэн чухал. “Сонгуулийн хуулиудад хэн санал өгөх боломжтой (болон чадахгүй), хязгаарыг хэрхэн тогтоох, саналыг хэрхэн суудал болгон хувиргах талаар (Rae, 1967) заасныг энд дурдахгүй өнгөрч үл болно. Учир нь СЕХ-ны хуульд заасан бие даасан байдал, чадавх, ажиллах хүчний уялдааг харгалзаж сонгуулийн зохион байгуулалтыг хийдэг нь сонгуулийн чанарт нөлөөлдөг гэдэг нь тодорхой асуудал.

Чингэхдээ улс төрийн институцийн хүрээнд сонгогчдын улс төрийн соёлд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар хамгийн ихээр илэрхийлэгдсэн байдлуудаас дурдвал, улс төрийн болон төрийн институци, сонгууль, сонгуулийн зохион байгуулалт зэрэг байлаа. Эдгээр асуудлууд нь ихэвчлэн дээрх институцид итгэх итгэл ардчилсан зарчмуудад нийцсэн эсэх, шударга байдал, үнэн зөв, иргэдийн эрх ашиг зөрчигдөөгүй эсэх талаарх үнэлгээнд тулгуурласан байна. Тухайлбал, Ардчиллын олон янз байдал (V-dem⁴) байгууллага нь дэлхийн 159 улсын 520 сонгуульд хийсэн дүн шинжилгээгээр иргэдийн сонгуулийн оролцоо, түүнд хандсан байдлыг дараах 9 шалгуураар хэмжиж үнэлсэн байна. Тодруулбал:

4 Varieties of Democracy (V-Dem) нь ардчиллын үзэл баримтлал, хэмжилтийн шинэ хандлага юм. 170 улс орны 3000 экспертүүдээс авсан үнэлгээнд тулгуурладаг нийгмийн шинжлэх ухааны судалгаанд суурилсан мэдээлэл цуглуулах хамгийн том хөтөлбөрүүдийн нэг юм. Ардчиллын үндсэн хэмжигдэхүүнүүд, тэдгээрийг төлөөлж болох шинж чанаруудыг ялгах сорилт, ардчиллын эмпирик аргуудаар сонгуулийн ардчиллын үнэлдэг. Сонгуулийн Ардчиллын Индекс (EDI)-ын нэг хэсэг болох 24 индикаторыг судалдаг.

1	Саналыг шударгаар тоолдог	2	Сэтгүүлчид сонгуулийг шударгаар мэдээлдэг	3	Сонгуулийн албаныхан шударга байна
---	---------------------------	---	---	---	------------------------------------

4	Сонгогчдод сонгуулиар жинхэнэ сонголт хийхийг санал болгож байна	5	Сөрөг хүчний нэр дэвшигчид өрсөлдөх боломжгүй болсон	6	Телевизийн мэдээ эрх баригч намыг илүүд үздэг
---	--	---	--	---	---

7	Сонгогчид саналаа худалддаг	8	Баян хүмүүс сонгуулийг худалдаж авдаг	9	Санал хураалт дээр сонгогчдыг хүчирхийлнэ гэж заналхийлдэг
---	-----------------------------	---	---------------------------------------	---	--

Судалгааны дүнд саналыг шударгаар тоолдог, сэтгүүлчид сонгуулийг шударгаар мэдээлдэг, сонгуулийн албаныхан шударга байна гэсэн 3 үзүүлэлт эерэг хандлагатай байгаа бол, сонгогчдод сонгуулиар жинхэнэ сонголт хийхийг санал болгодог хэмээн үзсэн байна. Харин сөрөг хүчний нэр дэвшигчид өрсөлдөх боломжгүй болсон, телевизийн мэдээ эрх баригч намыг илүүд үздэг, сонгогчид саналаа худалдаг, баян хүмүүс сонгуулийг худалдаж авдаг, санал хураалт дээр сонгогчдыг хүчирхийлнэ гэж заналхийлдэг гэсэн индикаторууд сөрөг хандлагатай байна. Эл сөрөг үнэлгээнд хамгийн ихээр нөлөөлөгч хүчин зүйл нь нэр дэвшигч, улс төрийн намуудын үйл ажиллагаатай шууд холбогдоно. Тодруулбал, санал хураалтыг зохион байгуулалттайгаар будлиантуулах, сонгогчдыг айдаст автуулах, сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй байх, маргааныг шийдвэрлэхийн оронд хүчирхийлэлд шилжих зэрэг аргачлалуудыг түгээмэл ашиглах нь ийнхүү сонгогчдыг сонгуулийн дүнд эргэлзэх хандлагыг бий болгож байна. Энэ нь тухайн үеийн сонгуулийн үр дүнд нөлөөлөхөөс гадна сонгогчдын сонгуулийн ардчилалд итгэх итгэлийг сулруулах, цаашлаад тэдний санал хураалтад оролцох хүсэлд сөрөг нөлөө үзүүлэх гол үндэс болсоор буй.


Сонгогчдын зан төлөвийн хүрээнд тэдний улс төрийн соёлд нөлөөлж буй хүчин зүйлсийг дурдан буй сэдвийн хүрээнд түгээмэл дурдагдсан болно. Жишээлбэл, сонгогчдын улс төрийн мэдлэг, ойлголт, сэтгэл хөдлөл, улс төрийн итгэл, сонгуулийн үр дүнгийн хүлээлттэй холбоотой асуудлуудыг энд тэмдэглэх нь зүйтэй. Улс төрийн мэдлэгийг явцуу утгаар улс төрийн талаарх үнэн бодит, зөв мэдээлэлтэй байх, харин өргөн утгаараа улс төрийн талаарх үнэн бодит, зөв мэдээлэлд үндэслэн улс төрийг танин мэдэж, улс төрийн үйл ажиллагаанд оролцож, шийдвэр гаргах чадвартай байхыг чухалчлан тодорхойлсон болно. Тиймээс улс төрийн мэдлэгийг сонгуульд санал өгөх, улс төрийн зан төлвийг

урьдчилан таамаглах, үйл явцын нөлөөг судлах, улс төрийн коммуникаци болон улс төрийн зан төлвийн харилцан хамаарал зэргийг чухал шалгуур болгон судлах нь сонгогчдын улс төрийн соёлыг тодруулах судалгааны гол чиглэл гэж үзнэ.

Сонгуулийн кампанид ажлын туршид тухайн нэр дэвшигч, намуудын талаар мэдээлэл авах, санал өгөхөөр бүртгүүлэх, хэрхэн санал өгөх, сонгуулийн шударга байдлын талаарх мэдээ, мэдээлэл зэрэг үйл явцын талаарх мэдээлэл нь сонгуулийн үнэлгээ болдог. Өөрөөр хэлбэл эдгээр нь сонгогчид сонгуулийн үйл явцыг мэдрэх орчин болоод зогсохгүй сонгуулийн хөндлөнгийн ажиглагчид, иргэдийн ажиглалтын бүлгүүд, сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагууд, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн сувгууд, нийгмийн сүлжээ зэрэг нь түүнийг хүлээн авах сувгууд болдгоороо онцлогтой.

Сонгогчдын соёлд нийгэм-хүн ам зүй ялгаатай байдал ихээр нөлөөлөх нь тэдний сонголт нь нас, хүйс, боловсрол, орлого, үндэс угсаанаас шалтгаалан ялгаатай байдал нэлээд бий болсон. Энэ нөхцөл нь сонгуульд сонгогчдыг жигд татан оролцуулахад ихээхэн хүндрэл учруулдаг. Сидней Вербагийн үзсэнээр боловсрол, орлого зэрэг нөөц бололцоотой иргэдийг улс төрд дайчлахад чухал ач холбогдолтой (Verba, Lehman, & Brady, 1995) боловч эдгээр нь хүн амын дунд жигд бус тархсан, мөн тус нөөц нэмэгдэхийн хэрээр улс төрд оролцох сонирхол бага байдаг нь бэрхшээлтэй холбоотой. Орлогын түвшин болон амьдралын чанар илүү сайн байх тусам сонгууль илүү үнэ цэнтэй, шударга өрсөлдөөнтэй явагдна. Хэдийгээр сонгогчдын насны ангилал сонгуулийн оролцоонд нөлөөлдөг ч сонгогчдосон төлөөлөгчид, намын удирдагчид нь ахмад настнууд байх хандлагатай байдаг нь дэмжлэгээ бүрдүүлэх, социал нөөцөө хадгалахын тулд тэдэнд чиглэсэн амлалт, мөрийн хөтөлбөр гаргах нь маргаангүй зүйл. Сонгуулийн кампанит ажлын үр дүнд залуучууд сонгуульд оролцохгүй байх нэг нөхцөл болж байна. Залуу сонгогчид болон орлого багатай хүмүүс сонгуулийн үйл явц, үр дүнд итгэхгүйн зэрэгцээ сонгогчдыг саналаа худалдсан гэдэгт итгэх магадлал өндөр байдаг.

Зураг 3. Сонгогчдын туршлагын мөчлөг: хүний рефлексийн хандлага



Эх сурвалж: (James & Garnett, 2023)

Сонгогчдын улс төрийн орчинд өөрийн мэдлэг, чадвар, хариу үйлдлийн үр дүнд өөрийн туршлагыг хуримтлуулж байдаг нь сонгогчдын улс төрийн соёлыг бий болгоно хэмээн үзэж болно. Нийгмийн хөгжил, улс төрийн дэглэм, нийгмийн хэм хэмжээнд тохирсон улс төрийн үйл ажиллагаа тухайлбал сонгуулийн орчинд нөлөөлөх стратегийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага бий. Энэ нь сонгогчдын туршлагын мөчлөгийн хоёр дахь үе шатанд бүтэц, агентуудын хоорондын нийгмийн харилцаа явагдаж, улмаар гол оролцогчид нь одоогийн эрх мэдэлтнүүд, нэр дэвшигчид, улс төрийн намууд, сонгуулийн албан тушаалтнууд, иргэний нийгмийн субъектүүд байна. Тэдний улс төрийн үйл ажиллагааны стратегийн үр дүнд сонгогчдод санал өгөх эсэхээ шийддэг. Сонгогч сонгуулийн үйл ажиллагааны талаарх цуглуулсан мэдээлэлдээ үндэслэн сонгуулийн үр дүнд, өргөн утгаараа сонгуулийн системд үнэлэлт өгөх явдал юм. Харин үнэлгээний дараа сонгуулийн системд асуудал үүсвэл шинэчлэх, улс төрийн системийг шинэчлэх, өөрчлөх хэрэгцээг, шаардлага бий болгодог.

Эцэст нь сонгогчдын зан төлөвт нөлөөлдөг сонгуулийн үйл явцын талаар тоймлон дүгнэвэл, санал өгөхөөс өмнө ба өгөх үеийн болон дараагийн шат гэсэн гурван хэсэгт хуваагдаж байна. Тодруулбал, санал өгөхөөс өмнөх үед сонгогчдын сонгуулийн талаарх мэдлэг, мэдээлэлтэй илүү холбогдох бөгөөд бүртгүүлэх журам, эцсийн хугацааг ойлгох, хэзээ, хаана санал өгөхөө мэдэх, саналын хуудасны хэлбэр, санал өгөх журмыг ойлгох, боломжит хувилбаруудаас шийдвэр гаргах зэрэг багтдаг. Хоёр болон гурав дахь хэсэг нь улс төрийн ухамсрын төлөвтэй холбогдож сонгуулийн үйл ажиллагаанд оролцоход зарцуулж буй цагийг тооцоолох бөгөөд үүнийг хүлээн зөвшөөрч, зохион байгуулах нь сонгогчдын санал өгөх сэдэлтэй шууд холбогддог. Ийнхүү цаг зарцуулалт нь санал хураалт руу явах хугацаа, дараалал, хүлээлгийн хугацаа, бүртгэлийн бичиг баримт бөглөх зэрэг захиргааны асуудлаас гадна сонгуулийн хэсгийн хороонд очих ажлаасаа чөлөө авах, үнэмлэхийн зөв хэлбэр олж авах, тээврийн зардал, хүүхэд асрах зардал гэх мэт материаллаг зардалтай байж болно. Тиймээс сонгогчдын улс төрийн соёлын төлөвшилд иргэний улс төрийн ухамсар, үүрэг, сэтгэл ханамж зэрэг субъектив хүчин зүйлсээс гадна сонгуулийн зохион байгуулалт шударга, хуулийн дагуу, сонгогчдод бэрхшээлгүйгээр өргөн оролцоог хангасан байх зэрэг объектив хүчин зүйл нь сонгогчдын улс төрийн соёлыг зөв дадал, зуршлаар төлөвшүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байна.

Дүгнэлт

Иргэдийн улс төрийн эрх ашгийг институционал хэлбэрт оруулах нэг чухал үйл явц нь улс төрийн сонгууль юм. Ардчиллын түвшнийг тодруулах судалгаанд сонгуулийн цэвэр, шударга байдал, сонгогчдын эрх, эрх чөлөөний үзүүлэлтүүд гол индикаторууд болдог. Уг судалгаануудын сүүлийн 5 жилийн дүнгээр дэлхий улс орнууд ардчиллаас ухран автократ дэглэмийн шинжүүд рүү шилжих төлөвтэй байна. Мөн сонгуулийн ирц, оролцоо буурах хандлагатай байгаа нь дэлхий нийтийн улс төрийн үйл явц дахь гол шийдвэрлэх ёстой асуудлын нэг болоод зогсохгүй хүн ам зүй, нийгэм эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөлөл, ялгаатай байдал үүсгэх нөхцөл зэргийг судалж байна.

Сонгогчдын ирц, оролцоо болон улс төрийн соёлын төлөвшилд улс төрийн орчин үнэн бодитоор мэдрэх, улс төрийг ухамсарлахад төр, засаглалын талаарх нээлттэй, ил тод мэдээлэл чухал бөгөөд энэ нь тухайн улс төрийн системээ хүлээн зөвшөөрөх, дэмжих хандлагыг бий болгож буй. Ялангуяа сонгуулийн бүхий л үйл явцын мэдээлэл тогтмол, нээлттэй, үнэн бодит, түргэн шуурхай сонгогчдод хүрэх нь сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөх үндсэн нөхцөл юм.

Сонгогчдын улс төрийн соёлд нөлөөлөх хүчин зүйлсийг улс төрийн

системийн хүрээнд нийгмийн хөгжил, улс төрийн дэглэм, нийгмийн хэм хэмжээ болох хууль эрх зүй зэрэг хэсгүүдээр тухайлан авч үзэх шаардлага нэгэнт бий болсон. Өнөөгийн улс төрийн институцийн хүрээнд сонгогчдын улс төрийн соёлд нөлөөлж буй хүчин зүйлсийг улс төрийн институци, төрийн институци, сонгууль, сонгуулийн зохион байгуулалтын асуудлууд, сонгогчдын үйл байдлын хүрээнд сонгогчдын улс төрийн мэдлэг, ойлголт, сэтгэл хөдлөл, улс төрийн итгэл, сонгуулийн үр дүнгийн хүлээлт зэрэгтэй холбогдох асуудлууд сонгогчдын улс төрийн соёлын судалгаанд түгээмэл судлагдаж байна.

Энэ утгаараа сонгогчдын улс төрийн соёл төлөвшихөд улс төрийн орчин, түүний бүтэц дэх элементүүдийн уялдаа холбоо, сонгогчдод нөлөөлөх сувгуудын нөлөө их бөгөөд энэ нь эргэх холбоотой сонгогчдын санал өгөх, саналын үр дүнг үнэлэх, дэмжих үйл явц болсоор байна.

Ном зүй

1. Dahl, R. A. (1971). *Polyarchy: Participation and Opposition*. New Haven: Yale University Press.
2. International IDEA. (2022). *Annual Review 2022*. Stockholm: International IDEA.
3. James, T. J., & Garnett, H. A. (2023). The Voter Experience Around the World: A Human Reflexivity Approach. *Journal of Representative Democracy*. Retrieved from Taylor & Francies.
4. Lipset, S. (1959). Some social requisites of democracy: Economic development and political legitimacy. *American Political Science Review*, 53(1), 69–105.
5. Rae, W. D. (1967). *The political consequences of electoral laws*. New Haven: Yale University Press.
6. V-Dem Institute. (2017-2024). *Democracy Reports*. Gothenburg: V-Dem Institute.
7. Verba, S., Lehman, S. K., & Brady, H. E. (1995). *Voice and equality: Civic voluntarism in American politics*. Cambridge: Harvard University Press.

МОНГОЛ ДАХЬ СОНГУУЛИЙН КАМПАНИЙН ТЕХНОЛОГИ БА ИМИЖ БҮРДҮҮЛЭЛТ

Доктор, дэд профессор У.Батцэрэн
Удирдлагын академийн Төрийн албаны
сургуулийн сургалтын менежер

Монгол дахь сонгуулийн кампанийн технологийн шинж онцлог, хэрэгжилт, илрэх арга хэлбэрийн тухай асуудал нь Монголын сонгууль шинжлэлийн салбарын томоохон судлагдахуун юм. Өнөөдөр манай судлаачид 1990 оноос хойш Монголд болж өнгөрсөн УИХ, Ерөнхийлөгчийн болон Орон нутгийн сонгуулийн ерөнхий үйл явцын талаар багагүй зүйлийг судлаж, бичиж байдаг хэдий ч сонгуулийн бүхэл үйл явц тэр дундаа улс төрийн лидерийн имиж бүрдүүлэлтийн талаар тусгайлсан судалгааг бараг хийж амжаагүй байна.

Манай улсад улс төрийн лидерийн имиж бүрдүүлэлтийн үйл явц нь төлөвших шатандаа явж буй юм. Тухайлбал, улс төрд шинэ хүмүүс, шинэ хөдөлгөөн, намууд орж ирсээр байна. Улс төрд орж ирж буй хүнд шаардлагатай мэдлэгийг шинээр эзэмшиж, түүнд суралцах дадал, улс төрчийн болон түүний багийн хувьд улс төрийн соёлын түвшингээ дээшлүүлэх тал дээр явуулах байнгын нарийн няхуур ажиллагаа нь бидний амьдарч буй нийгэм, нийт улс орны хувьд төдийгүй бүх дэлхийд томоохон ач холбогдолтой юм.

Улс төрийн имиж нь олон нийтийн ухамсарт төлөвшсөн шинж чанартай сэтгэл хөдлөлөөр тодорхойлогддог улс төрийн лидерийн дүр төрх юм. Имижийн төлөвшилт нь гэнэт ухамсаргүй юмуу эсвэл ухамсартай явагддаг. Ухамсартайгаар гэвэл улс төрчийг хүмүүсээс хүлээн зөвшөөрөх онцлогийг нягтлан судалснаар түүний таатай дүр төрхийг бүрдүүлэх шинэ стратеги тактикийг боловсруулах явдал юм. Энэ удаагийн өгүүлэлдээ Монгол дахь сонгуулийн кампанийн технологи, үе шатын талаар товч бичихийг хичээв.

Монголын сонгуулийн кампанийн үе шатны асуудал нь зөвхөн 1990 оноос хойших үеэр хязгаарлагдахгүй. Энэ үе нь тус орон ардчиллын замаар замнасан 30 гаруй жилийн төрийн түүхийг хамарч байна. Сонгуулийн кампанийн ардчилсан хэв маягийн хөгжлийн бүхэл үйл явцыг үечлэн судлах нь сонирхолтой. Ардчиллын замаар замнасан 30 гаруй жилийн хугацаанд нийгмийг ардчилсан үндсэн дээр өөрчлөн, улс төрийн тогтолцооны бүтцийг шинэчлэж улмаар сонгогч олонд ардчиллын суурь үнэт зүйлсийн шинэ үнэлэмжийг идээшүүлэн бий болгож байгаа нь сонгуулийн кампанийн хөгжлийн үйл явцыг шинжлэн судлах суурь үндэс болж байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн лидерийн имиж бүрдүүлэлт болон сонгуулийн кампанийн технологиос нь хамааран сонгуулийн кампанийн

шилжилтийн үе, сонгуулийн кампанийн төлөвшилт, орчин үе хэмээн хувааж болох юм. Сонгуулийн кампанийн хөгжлийн үйл явцыг ингэж зааглан ялгаж үзэх нь Монголын ардчилал, сонгуулийн үйл явцын төлөвшлийн шинж онцлогтой шууд хамааралтай юм.

Сонгуулийн кампанийн технологийн шилжилтийн үе. Энэ хэв маягийн үйлчлэн оршиж ирсэн цаг хугацааг 1990-2000 оныг үзэж болохоор байдаг. Монгол орон олон арван жил нэг намын дарангуйлалын дэглэмд захирагдаж, улс төрийн нэг ягшмал үзэл суртлыг баримталж ирсэнтэй холбоотойгоор ардчилсан сонгуулийн кампанийн орчин үеийн удирдлага, зохион байгуулалт, арга хэлбэрийн үнэт зүйлсээс хол, түүний талаарх бэлэн мэдлэг туршлага байхгүй байсан. Энэ онцлог 1990 онд ардчилсан улс төрийн тогтолцоо, төрийн бүтцийн үндсийг бүрдүүлэх, анхны чөлөөт ардчилсан сонгуулийг зохион байгуулах явцад нэн тодорхой илэрсэн билээ.

Монголын сонгуулийн кампанийн шилжилтийн үеийн хугацаанд болж өнгөрсөн орон нутгийн сонгуулийн үйл явцыг хамран илэрч байсан гэж үзэж болно. Сонгуулийн тогтолцооны шилжилтийн хэв загварын гол онцлог нь хуучин нийгмийн өвөөс үүдсэн сонгуулийн арга технологийн уламжлалт шинж, ардчилсан сонгуулийн орчин үеийн шинжийн аль алиныг нь өөртөө агуулсан түүний заримдаг шинжээр тодорхойлогддог. Тиймээс ч энэ үеийн Монголын сонгуулийн кампанийн үйл явц нь сонгуулийн кампанийг зохион байгуулах уламжлалт болон орчин үеийн арга хэлбэрийн хосолмол шинжийг агуулж байлаа.

Сонгуулийн кампанийн төлөвшилт, орчин үе. Сонгуулийн кампанийн энэ хэв маяг нь УИХ-ын 2000 оноос өнөөг хүртэл энэ хугацаанд болж өнгөрсөн сонгуулийн албан ёсны кампанийн бодит үйл явцыг шинжлэн үзэхэд монголын өнөөгийн сонгуулийн кампанийг шилжилтийн буюу холимог маягаас орчин үеийн модерн загвар түүний бэхжилт төлөвшлийн үйл явц руу нэгэнтээ орж эхлэх үе гэж үзэж болохоор байна. Тэгэхдээ гээд Монголын сонгуулийн кампанийг цэвэр модерн хэв маягийн кампани гэж үзэхгүй байна. Энд уламжлалт хүчин зүйлийн нөлөө урьдын адил хадгалагдсаар байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Харин сонгуулийн кампанийн энэхүү уламжлалт хүчин зүйл харьцангуй богино хугацаанд модерн хэв маягт зайгаа тавьж өгч байгаа нь сонгуулийн кампанийн энэ үеийн гол онцлог болж байна.

Өнөөгийн сонгуулийн кампанийн технологийн гол шинж болсон шинэчлэгдсэн (модерн) шинж улам тодрон илрэх болсон нь сонгуулийн кампанийн удирдлага, зохион байгуулалтад намын төв байгууллага, голлох хошуучлагчдын оролцоо нөлөөлөл нэмэгдэх болсон сонгуулийн кампанид гадны болон дотоодын улс төрийн имижмейкер, зөвлөх мэргэжилтнүүдийн зөвлөмж, туслалцааг чухалд үзэх болсон ардчилал хөгжсөн гадны улс орнуудын сонгуулийн

компанийн туршлага, сургамжийг аль болохоор анхааран судлах нь нэмэгдсэн "сонгуулийн үеийн мэдээлэл цуглуулах арга ажиллагаа нарийсаж, сонгогч олон түмнийг хамарсан шинжлэх ухааны үндэстэй судалгаа шинжилгээ, санал асуулга, мониторинг шинжилгээний үр дүнг сонгуулийн кампанид өргөн ашиглах болсон" сонгуулийн сурталчилгаанд хэвлэл мэдээллийн хэрэгсэл тэр дундаа телевизийн үүрэг онцгой нэмэгдэж, сурталчилгааны шинэ содон арга хэлбэрийг ашиглаж эхэлсэн сонгуулийн коммуникацийн суваг, арга хэлбэр нь өргөсөн, орчин үеийн шинжийг аажмаар агуулах болсон" хэвлэл сурталчилгааны тусгай дагнасан мэргэжилтэн, намуудын сонгуулийн сурталчилгаа, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцах үйл ажиллагааг зохицуулах байдал бий болж эхэлсэн сонгуулийн компанийн зардлыг аль болохоор багасгаж, түүний үр дүн, зонхилон зарцуулах сурталчилгааны салбар чиглэлийг онцлон анхаарах байдал ажиглагдаж эхэлсэн зэргээр илэрч байна.

Энэ бүхэн нь эцсийн дүндээ сонгуулийн компанийг зохион байгуулах технологид орчин үеийн арга хандлага эрчимтэй нэвтрэх болсонтой холбоотой байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд сонгуулийн кампанид олон нийтийн санал асуулгын судалгаа, нөхцөл байдлын шинжилгээ, зөвлөх мэргэжилтнүүдийн оролцоо болон интернет, чаат, гар утас, мессеж, PR-сурталчилгаа зэрэг сонгуулийн реклам сурталчилгааны шинэ хэлбэрүүд ямар нэг хэмжээгээр хэрэглэгдэх болсон. Энэхүү нөхцөл байдалтай холбоотойгоор сонгуулийн компанийн технологийн хэрэгжилтийн үйл явцыг хэв маягийн хувьд модерн шинжийг эрчимтэй олж төлөвшиж буй төлөвшилтийн үе хэмээн тодорхойлж болохоор байгаа юм.

Өрнөдийн модерн болон пост-модерн сонгуулийн компанийн ялгарах онцлог нь улс төрийн намуудын сонгуулийн компанийн бүхий л үйл ажиллагааг зөвлөх мэргэжилтэн, сонгуулийн удирдлага, зохион байгуулалтаар тусгайлан бэлтгэгдсэн мэргэжлийн хүмүүсээр удирдуулдаг оршдог. Тэдний заавар зөвлөгөө, чиглэл, тусгайлан боловсруулсан сценари, хөтөлбөрийн дагуу нэр дэвшигчид имижээ бүрдүүлж, олон нийт болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцаж байдаг. Манай улсад МАН, АН болон бусад намуудын хувьд судлаач мэргэжилтнүүдийн заавар зөвлөгөө, чиглэлийг тодорхой хэмжээнд авдаг боловч ихэнхдээ тэдний сонгуулийн кампанид орон нутгийн намын байгууллага, улс төрийн лидерийн нэр хүнд, нэр дэвшигчид, танил тал, найз нөхөд, нутаг усныхны дэмжлэг чухал үүрэгтэй байсан нь тэдний нийтлэг шинж гэлтэй.

Сонгуулийн бэлтгэлийн хангах үйл явц нь П.Норрисын үзэж байснаар сонгуулийн компанийн технологийн шинж байдлыг тодорхойлох чухал хүчин зүйл болж байдаг. Өрнөдийн улс орнуудын сонгуулийн компанийн бэлтгэл ажил нь эртнээс нарийн тооцсон шинжлэх ухааны үндэстэй хийгддэгээрээ онцлогтой. Үүнээс гадна сонгуульд оролцож буй намуудад сонгуульд бэлтгэх гарааны ижил нөхцөлийг бүрдүүлж өгөхийг чухалчилдагаас гадна тэдэнд үйлчлэх хууль, эрх зүйн орчин, механизмын боломж тэгш байдаг. Энэ тохиолдолд

намууд, нэр дэвшигчид сонгуулийн кампанийг зохион байгуулах мэргэжлийн тусгай байгууллагаа байгуулах, тэнд ажиллах сонгуулийн мэргэжилтнүүдийн багаа сонгож бүрдүүлэх, тойрогт ажиллах идэвхтэн дэмжигчдийнхээ үүргийг хуваарилах, сонгуулийн кампанийн стратегиа боловсруулах, сонгогчдын нийгэм сэтгэл зүйн болон улс төрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх, сонгуулийн үйл ажиллагааны тактикийн бодлогоо тооцон боловсруулах, нэр дэвшигчид болон өрсөлдөгч талынхаа давуу ба сул талыг судлах, өөрийн нэр дэвшигчийн имижийг бүрдүүлэх, сонгуульд зарцуулах хөрөнгө мөнгөө хуулийн хүрээнд босгох зэрэг сонгуулийн бэлтгэл ажилтай холбогдсон олон зүйлийг амжуулан гүйцэтгэхийг хичээдэг.

Манай улсад сонгуулийн бэлтгэл ажлыг хангахад чиглэгдсэн дээрх онцолсон ажлуудыг хэрэгжүүлэхээсээ илүүтэй парламентад суудалтай намууд өөрт байгаа эрх мэдлийн давуу байдал, мөнгө санхүүгийн нөөц боломжоо ашиглан сонгуулийн албан ёсны сурталчилгаа эхлэхээс өмнө сурталчилгааны ажлаа тойруу замаар албан бусаар эхлүүлэхийг оролддог билээ. Энэ байдал ч өнөөдөр ажиглагдаж байна. Тухайлбал, УИХ-ын 2024 оны сонгуулийн тойргийн хуваарь, УИХ-ын гишүүд сонгууль дөхөхөөр тойрогтоо ажиллах нэрийдлээр ирэх сонгуулийн бэлтгэлээ эртнээс базааж эхэлдэг. Ингэхдээ тойргийн сонгогчдоо элдэв амлалт өгөх, буяны болон өглөгийн арга хэмжээ зохиох, бэлэг сэлт тараах, өөрийгөө сурталчлан дөвийлгөх зэрэгт анхаардаг нь ажиглагдаж байна.

Харин парламентын гадна байгаа намуудын хувьд сонгуулийн бэлтгэл ажлаа ханган базаахад хөрөнгө санхүү, эрх мэдэл, хүний нөөцийн зэрэг олон зовлон бэрхшээл тохиолддог нь манайд сонгуулийн бэлтгэл ажлыг хангахад намуудад гарааны ижил тэнцүү нөхцөл бүрдээгүйгээр барахгүй хуулийн үйлчлэл нь ч тэгш биш байна гэсэн дүгнэлтийг хийхэд хүргэж байна.

Манай улсын сонгуулийн кампанийн үйл явцаас үзвэл сонгогчтой хийх коммуникацийн хэлбэр олон төрлийн сувгаар дамжин хэрэгждэг нь харагддаг. Тухайлбал, сонгогч олон түмэнтэй харилцахдаа хамгийн түгээмэл хэрэглэдэг суваг нь тойргийн сонгогчтой нэр дэвшигчийн хийх нүүр тулсан уулзалт, томоохон газруудаар зочлон очиж, сурталчилгаа явуулах хэлбэр юм.

Сонгуулийн кампанийн үеийн коммуникацийн хамгийн түгээмэл, хүртээмжтэй хэрэгсэл нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл тэр дундаа өнөөдөр цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэл болж байна.

Сонгуулийн сурталчилгааны кампанийн явц, үр дүн түүний стратеги, тактикийн асуудлыг нарийвчлан авч үзэхийн тулд дараах хэд хэдэн чухал үзүүлэлтийг ашиглаж байна. Энэ нь Америкийн судлаач Гибсон, Раммелс нарын санал болгосон сонгуулийн кампанийн технологийн стратегийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд юм.

Сонгуулийн кампанийн технологийн модернизацийн чухал үзүүлэлт нь зорилтот бүлгүүдэд хандсан сурталчилгааны арга технологи юм. Үүнийг урьд өмнө

төдийлөн ойшоодоггүй, нийт сонгогчидод ялгаваргүй хандсан сурталчилгааны арга тактикийг хэрэглэж байсан. Харин 2012 оноос хойш улс төрийн амууд өөрийн нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх өндөр магадлалтай сонгогчид, эргэлзсэн болон хэнд ч санал өгч мэдэх хөвдөг сонгогчдыг татахын тулд сонгогчдыг зорилтот бүлгүүдэд ялган тэдгээрт хандсан тусгайлсан сурталчилгааг өргөн хэрэглэсэн нь үр дүнгээ өгсөн байдаг.

Сонгуулийн кампанийн технологийн стратеги, тактикийн шинж байдлыг тодорхойлоход сонгуулийн кампанийн үеийн шинэ арга технологийг ашиглаж буй байдал, цаг үеийн тулгамдсан анхаарал татсан асуудлыг намдаа ашигтай байдлаар зохицуулан мэдээлэх чадвар, өрсөлдөгчийн алдааг сонгуулийн сөрөг сурталчилгаандаа ашиглах байдлын чадвар зэрэг үзүүлэлтүүд чухалд тооцогддог. Энэ чухал үзүүлэлтүүдийн түвшин өнөөгийн улс төрийн намуудын хувьд харилцан адилгүй байдлаар илэрч байна. Намуудын хувьд сонгуулийн шинэ технологийг хэрэглэх байдлын түвшинг нэгд, сонгуулийн сурталчилгааны шинэ содон аргуудыг сонгож хэрэглэсэн байдал" хоёрт, сурталчилгааны шинжлэх ухааны үндэс буюу гадны болон дотоодын туршлага, зөвлөх мэргэжилтнүүдийн зөвлөгөө, зааврыг авч хэрэгжүүлж байгаа байдлын түвшин" гуравт, сурталчилгааг гардан зохион байгуулж буй үйл ажиллагааны шинж байдал зэргээр тодорхойлж болох юм. Тухайлбал, сонгуулийн үед намууд политтаймент буюу цэнгээнт улс төрийн арга технологийг хэрэглэх явдал нийтлэг ажиглагдах болсон.

Өнөө үед сонгуулийн кампанийн шинэлэг технологийн тодорхой илрэл нь сонгуулийн кампанийн үйл ажиллагаанд гадны болон дотоодын зөвлөх мэргэжилтны зөвлөлгөө зааврыг бодитой авах, гадны орны сонгуулийн үйл ажиллагааны туршлагыг судлах, орчин үеийн нийгмийн судалгааны шинэлэг аргуудыг сонгуулийн үед өргөн ашиглаж судалгаа шинжилгээг хийх, улс төрийн нөхцөл байдал болон нэр дэвшигчдийн талаарх өргөн мэдээллийг цуглуулах түүнд дүн шинжилгээ хийх зэрэг сонгуулийн кампанийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулахад чиглэж байгаа нь сайшаалтай юм.

ЗАЛУУ, ШИНЭ НЭР ДЭВШИГЧДЭД ТУЛГАМДАХ АСУУДЛУУД

Т.Туяачимэг

МУБИС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн багш

Сонгогчид сонгуульд санал өгөхдөө өөртэй нь адил, өөрийнх нь асуудлыг мэддэг, төлөөлдөг нэр дэвшигчийг эрэн хайж байдаг. Сонгуульд оролцож, улс төрд хөл тавих залуу нэр дэвшигчээс сонгогчид юу юу хүлээх вэ? Залуу, шинэ нэр дэвшигчийн тухай судлах бүрд энэ судлагдахуун сонгогчийн залуу хүнээс хүлээх хүлээлт, нөгөө талаар залуу нэр дэвшигч өөрөө ямар сэдэв асуудлыг төлөөлбөл зохистой талаар давхар утгатай байгааг олж харсан.

Зохиогч миний хамтарсан бүтээл “*Z сонгогч гэж хэн бэ?*” ном тун удахгүй хэвлэгдэх бөгөөд тус бүтээлд залуустай холбоотой сонгуулийн зан үйлийн талаарх олон асуултын хариуг эрэлхийлсэн бөгөөд энэхүү нийтлэлд зориулан зарим асуултад хариульга.

Залуу сонгогч сонгуулийн үед нэр дэвшигчийн юунд илүү анхаардаг вэ?

Монголын залуус нэр дэвшигчдээс таны сонголтод хамгийн ихээр нөлөөлөх хүчин зүйл юу вэ? гэсэн асуултад тэдний 26 хувь нь хийж бүтээсэн зүйл, ололт амжилт¹ гэж хариулсан нь өнөөх улс төрийн суб'ектэд найддаг, гол баатар хүлээдэг улс төрийн ухамсар гэлтэй. Бусад хариултаудаас өндөр хувьтай гарсан энэ хувилбар нөгөө талдаа хийж бүтээсэн зүйлгүй өөр шиг нь залуу нэр дэвшигч сонгуульд залуусынхаа саналыг авах магадлал багатай гэдэгтэй ижил хариулт мэт сонсогдоно. Судалгааны хариултын дараагийн үр дүн залуусын 18 хувь нь сонгуулийн мөрийн хөтөлбөр амлалтыг харгалздаг² гэжээ. Сонгуулийн мөрийн хөтөлбөр дангаараа биш амлалт гэсэн байгааг анхаараарай. Амлалт бол мөрийн хөтөлбөртэй дүйхгүй. Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн үгэн илэрхийлэл юм. Нөгөө талаар мөрийн хөтөлбөрийн хураангуйлсан үг юм. 2021 онд сонгуулийн дараа хийгдсэн судалгаанаас харахад аль ч (17-26) насны залуучуудын хувьд сонгуулийн мөрийн хөтөлбөртэй сайн танилцах эсвэл тойм байдлаар танилцан сонголтдоо хийх хандлага давамгайлж байсан. Харамсалтай нь сонгуулийн дараа Монголын “Z” залууст мөрийн хөтөлбөрийн аль бодлого, зарчим, нэр дэвшигчийн ямар асуудлаарх байр суурь санал өгөхөд нөлөөлсөн талаарх мөшгөх судалгаа хийх санхүүгийн болон институцийн дэмжлэг хангалтгүй байна.

1 IRIM. БНУУХ. (2020). Залуусын санал бодлын судалгаа. Судалгааны тайлан
2 Мөн тэнд

2023 оны судалгаагаар Америкийн “Z” үеийн залуу сонгогчдын хувьд тэдний 28 хувь нь нэр дэвшигчдийн байр суурийн талаар, 26 хувь нь нэр дэвшигчийн талаар илүү их мэдээлэл авахыг хүссэн байна. Дээр дурдсанчлан сонгуульд санал өгсөн залуусаас боловсролын салбарын асуудлуудаас аль бодлого, байр суурь сонгуульд санал өгөхөд түлхэц өгсөн талаар судалж үзэхэд тэдний 50 хувь нь сургуулийн аюулгүй байдлыг сайжруулах, багшид олгодог нэмэлт санхүүгийн дэмжлэгийг төрөөс санхүүжүүлэх асуудал, залуусын сэтгэцийн болон сэтгэл зүйн эрүүл мэндэд анхаарсан төрийн дэмжлэгийн асуудлууд санал өгөхөд хөтөлсөн³ гэж хариулжээ. Мөн энгийнээр сонгогч өөрт хамгийн ойр санагдсан хүндээ санал өгдөг гэсэн сонгогчийн зан үйлийн орон зайн онолын үндэслэлийг умартаж болохгүй. Нэр дэвшигч нэг л өдөр сонгуулийн сурталчилгааны постер, постдоо залуу стильтэй хувцасласан, залууст ойр гэдгээ харуулж ядахын оронд залуусын амьдралд тулгамдаж буй асуудлаар судалдаг, өөрөөр хэлбэл, залуусыг мэдэрдэг, тэдний асуудлыг яаж шийдвэрлэхээ өөрсдийнх нь оролцоотой хэлэлцдэг хүн байх ёстой. Залуулаг хүн байх ёстой гэснээс ерөөсөө намууд яагаад залуусыг нэр дэвшүүлж, өөрсдийн аргаар ажиллах боломж олгож болохгүй хэрэг вэ? Ийм арга замыг зөвшөөрөхгүй байгаад л залуус улс төрийн намуудыг өөрсдийг нь төлөөлөх чадваргүй гэж үзэхэд хүргэж байгаа юм. Энэ талаар нотолгоотой судалгааны үндэслэлийг дараагийн асуулгаас олж харах болно.

Залуу нэр дэвшигч та хэр бэлтгэгдсэн бэ?

Монголд нийгмийн сүлжээгээр нэр дэвших эсэх талаараа бяцхан санал асуулга явуулаад нэг мянган хүн дэмжиж лайк дарсныг өөрийгөө нэр дэвших боломжтой хүн мэтээр ойлгох горилогчдыг харахад тэд улс төрийн талаар ямар ч мэдлэггүйн дээр улс төрийн намууд залуу нэр дэвшигчээ бэлтгээгүйг илтгэнэ.

Залуусын улс төрийн оролцоо, төлөөлөл бага байгааг тайлбарласан судалгааны бүтээлүүдээс харахад судлаач Ш.Хилл (2020) сонгуульд залуус нэр дэвшихэд өндөр өртөгтэй төдийгүй залуу нэр дэвшигч бэлтгэгдээгүй, бодит байдалд дээр залуу нэр дэвшигчийн хомсдолд орсонтой холбоотой⁴ гэж дүгнэжээ. Үнэхээр залуу нэр дэвшигч сонгуульд нэр дэвшсэн л бол ялдаг уу? гэсэн асуултын хариулт янз бүр. Үүнд нөлөөлдөг олон хүчин зүйл бий. Юутай ч залуу нэр дэвшигчээс өөрөөс нь үл хамаарах шалтгааныг цогцоор нь судлахад улс төрийн системийн, улс төрийн намын талын хүчин зүйлийг авч үзье. Шинэ болоод залуу нэр дэвшигчийн хувийн нэр хүнд, хүч чадлаас тусдаа энэхүү хүчин зүйлийг бүтцийн сул тал гэнэ. Өөрөөр хэлбэл, залуу нэр дэвшигчийг улс төрийн намаас нэр дэвшүүлэхээс цааш суурь шинжтэй нөлөөлөх хүчин зүйлүүд бий. Европын залуучуудын форумаас гаргасан зөвлөмжид хэрхэн залууст ээлтэй улс төрийн нам болох талаарх дараах

арга замуудыг⁵ санал болгосон. Залуу, шинэ нэр дэвшигчид дараах асуултад шууд ба шууд бусаар хариулж дүгнэлт хийгээрэй.

А. Намууд залуусын талаар нэгдсэн бодлого, стратеги төлөвлөгөөтэй байх	Тийм	Үгүй
Нам дахь залуусын эрх ашгийг хэрэгжүүлэх нэгдсэн стратеги төлөвлөгөөтэй эсэх		
Намын шийдвэр гаргах төлөөллийн байгууллагад залуусын оролцоог хангадаг эсэх		
Намын албан ёсны бодлогын болон эрх зүйн баримт бичигт залуусыг дэмжих заалт бий эсэх		
Б. Намын дэргэдэх залуучуудын байгууллагаа хүчирхэгжүүлэх		
Намын дэргэдэх залуучуудын байгууллага нь бүрэн эрхт, бие даасан байдлын хувьд: Намын дэргэдэх залуусын байгууллагыг санхүүжүүлдэг тогтмол хөрөнгөтэй эсэх, боломжит нөөцийг зарцуулдаг эсэх		
Эдгээр санхүүжилт, нөөцийг хэн нэгний зөвшөөрөлгүйгээр шууд ашиглах, зарцуулах боломжтой эсэх		
Намын дэргэдэх залуучуудын байгууллагын төлөөлөл лидерүүд намын гол үйл ажиллагаа, хурал, форумд тогтмол оролцоотой эсэх		
Намын гол байгууллага, хурал, форумд залуус санал өгөх эрхтэй эсэх, саналын квоттой эсэх		
Намын дэргэдэх залуучуудын байгууллага нь өөрийн эрх ашгаа хамгаалах чиглэлээр мэргэшсэн ур чадвар бүхий: Намын дэргэдэх залуусын байгууллагын санаачилгаар намын гол хурал, бүрэлдэхүүнийг хуралдуулдаг эсэх		
Намаас залуусыг жолоодохгүйгээр залуусын өөрсдийнх нь утга учиртай үнэт зүйлтэй оролцоог дэмждэг эсэх		
Намын гол бодлогод залуусын асуудлыг, эрх ашгийг тусгадаг эсэх		
Намаас залуучуудыг сонгуульд албан тушаалд томилох болон сонгуульд нэр дэвшүүлдэг эсэх		

<p>Намынхаа үзэл баримтлал, үнэт зүйлтэй нийцэж байгаагаас үл хамааран залуус үзэл бодлоо илэрхийлэх, үүнийгээ нийтэд сурталчилдаг эсэх</p>		
<p>В. Намын үндсэн аппарат болон намын дэргэдэх бусад байгууллагад залуусын төлөөлөлтэй байх</p>		
<p>Намын (гүйцэтгэх засаглалын) гол байгууллагууд, тэр дундаа бүх шатны нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалтын бүрэлдэхүүнд залуучуудын байгууллага, залуучуудын төлөөлөгчдөд зориулсан суудлын хэмжээг тогтоосон эсэх Эдгээр суудлын жин (саналын эрх) нь залуучуудыг бүрэн төлөөлөх тоог тусгасан байх ёстой бөгөөд залуучуудын төлөөлөгчдийн эрх бусад гишүүдийн эрхтэй тэнцүү байгаа эсэх</p>		
<p>Бүх шатны хууль тогтоох байгууллагын сонгуульд залуучуудын нэр дэвшигчийн квотыг нэвтрүүлнэ. Квот нь залуучуудын хүн амын тоотой тохирч байх ёстой бөгөөд залуу нэр дэвшигчдийг хүн амын бусад бүлгүүдийн нэгэн адил сонгогдох албан тушаалд (жагсаалтад орсон, сонгогдох боломжтой) байрлуулдаг эсэх</p>		
<p>Нэр дэвшигчид болон залуучуудын төлөөлөл нь нийгмийн залуучуудын олон янз байдлыг (хэрэгцээтэй) тусгаж, сурталчилдаг эсэх (эмэгтэйчүүд, шашин шүтлэг, хүйс, бусад цөөнхийн төлөөлөл)</p>		
<p>Г. Залуу гишүүд, нэр дэвшигчдэд зориулсан академик сургалтын хөтөлбөртэй байх</p>		
<p>Залуу нэр дэвшигчийн хувиар нэр дэвшихэд шаардлагатай ур чадвар, мэдлэгээр хангаж, байгууллагын улс төрд идэвхтэй оролцоход чиглэсэн байнгын болон богино хугацааны сургалтын олон төрлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг эсэх</p>		
<p>Д. Намын үндэсний хэмжээний мэтгэлцээн, сонгуулийн мөрийн хөтөлбөрт залуусын талаар тусгайлсан бодлоготой байх</p>		
<p>Залуу гишүүд, залуучуудын байгууллагуудтай хамтран үндсэн үнэт зүйл, эрхэм зорилгоо шинэчлэхэд оролцдог эсэх</p>		

Намаас дэвшүүлж буй бүх бодлогын залуучуудад үзүүлэх нөлөөллийг үнэлж, залуучуудын үзэл бодлыг намын гол бодлого болон салбар бүрд тусгадаг эсэх		
Намын хөтөлбөр, сонгуулийн мөрийн хөтөлбөрт залуучуудын сонирхсон, хамааралтай сэдвүүдийг залуучуудын байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн эрэмбэлсэн эсэх (жишээ нь залуучуудын тунхаг гэх мэт).		
Е. Нам найдвартай судалгаа, нотлох баримт, мэдээлэлд үндэслэн залуучуудад зориулсан бодлогоо тодорхойлох		
Бодлогын байр сууриа үндэслэж, залуу хүмүүст хандсан мессежээ баттай, хамааралтай нотлох баримт, мэдээллээр баяжуулсан эсэх		
Залуучуудын тулгамдсан асуудлын талаарх байнгын санаачилга, судалгаа, мониторингийг дэмжиж, олон нийтийн байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, иргэний нийгмийн бүлгүүдийг залуучуудын талаар мэдээлэл цуглуулахад дэмжлэг үзүүлдэг эсэх		
Ё. Судалгаанд үндэслэсэн ойлгомжтой мессеж боловсруулах		
Залуучуудын бодит амьдрал дээр тулгамдаж буй асуудлыг хөндөж, нотлох баримтад тулгуурласан бодлого, үндэслэлээр тайлбарласан уу?		
Үнэт зүйлдээ тууштай байж, үүнийгээ мессеж хэлбэрээр түгээдэг үү?		
Энэ мессеж нь эрс шийдэмгий, бодит асуудлыг байгаагаар нь илчлэн харуулсан уу?		

Залуу нэр дэвшигчийг ялалтад хүргэдэг намын үйл ажиллагаа ямар байх вэ?

Либерал үзэл ялан дийлсэн Америкт ардчилсан социалист үзлийг үлгэрлэн үзүүлсэн залуу улс төрч бол Александра Окасио Кортес юм. Тэрээр 1989 онд төрсөн 2019 онд АНУ-ын Конгресст сонгогдсон анхны латин америк залуу эмэгтэй. 2016 онд улс төрч Берни Сандерсийн сонгуулийн кампанид зохин байгуулагчаар ажиллахаасаа өмнө бааранд зөөгч, бармен хийж байсан. Хоёр жилийн дараа улс төрд хөл тавьж 2019 онд Конгресст сонгогдсон нь улс төр судлаачдын судалгааны

үр дүнг эргүүлсэн цочирдом амжилт үзүүлсэн байв. Цочирдом гэсэн нь судлаачдын таамаглаж байсан судалгааны дүнг орвонгоор нь өөрчилсний учир нь ардчилсан социалист үзэлтэй залуу эмэгтэй Ардчилсан намын бүлгийн даргаар 10 удаа сонгогдсон Жо Кроулиг ялсанд оршино. Улс төрийн тоймчид Америкийн Бүгд найрамдах нам ялагдаагүй, ялагддаггүй, харин хөгшин нэр дэвшигчид л ялагддаг гэж дүгнэх болов. Өнөөх л нэр дэвшигчийн насны тухай.

Жана Бельшнер (2024) “Сонгуульд ялахад хэт залуудаад байна уу?” судалгаагаар залуу болон бусад насны нэр дэвшигчийн талаар сонгогчид хэвшмэл ойлголтууд байдаг⁵ гэж дүгнэжээ. Залуу учраас ялагдах биш тэдний талаар олон нийт, сонгогчид ташаа төсөөлөл ойлголттой байдаг байх нь. Мөн энэ ташаа төсөөлөл зөвхөн залуу нэр дэвшигчтэй холбоогүй, ахимаг насныханд хамаатай ажээ. Залуу болон ахмад нэр дэвшигчдийн аль аль нь сонгуульд цөөн суудал авсан, цөөн гишүүнтэй, жилийн орлого багатай намуудтай холбоотой байдаг. Нэг талаас, залуу сонгогчид хэт зүүн эсвэл баруун талын намуудад санал өгөх магадлал өндөр байдаг (Walczak et al. 2012; Zagorski et al. 2021), мөн шинээр байгуулагдсан намуудыг дэмжих, элсэх магадлалтай (Franklin and Spanje 2012; Rekker 2022) гэсэн дүгнэжээ. Үүнээс үзэхэд нэр дэвшигч залуу учраас ялах гэхээсээ намын дэмжлэг чухал байртай болж ирлээ. Залуу нэр дэвшигчийг залуус илүүтэй дэмждэг гэж үзвэл залуу сонгогчийн саналыг татах дараах стратеги тактикуудыг хэрэгжүүлээрэй. Шинэ, залуу нэр дэвшигчид дэвших гэж буй улс төрийн намаасаа дараах дэмжлэгийг шаардаарай. Үүнд:

А. Залуучуудыг хамруулах улс төрийн кампанит ажлын стратегиа тэдний оролцоотой хамтран бүтээх

- ✓ Нам доторх залуучууд болон/эсвэл шаардлагатай бол намаас гадуурх залуучууд тэргүүтэй байгууллагуудтай хамтран залуучуудад чиглэсэн кампанит ажлыг зохион байгуулж, явуулах.
- ✓ Энэ кампанит ажлын менежмент нь дизайнаа гаргах үзэл баримтлалаа сонгохоос эхлээд төлөвлөхөөс хэрэгжүүлэх хүртэл үргэлжлэх ёстой.

Б. Намын үнэт зүйл, алсын харааг хүлээн зөвшөөрдөг залуусыг нэгтгэн бүртгэх

- ✓ Сурталчилгааны кампанит ажлаа байнгын дэмжигчдээр хийлгэх. Тэд кампанит ажлын мессежийг өөрсдийнхөө сүлжээнд тарааж, кампанит ажлыг сурталчлагч болгон хувирдаг
- ✓ Намын улс төрд нийцсэн, үнэт зүйл, үзэл санаагаа хуваалцсан анхан шатнаас гарах санал санаачилга, хөдөлгөөнд нээлттэй хандах. Сонгуулийн сурталчилгааны гол ажлуудыг ийм зохион байгуулалттай хэрэгжүүлэх

В. Залуучуудыг сонсох

- ✓ Улстөрчдөө залуучуудыг сонсож, тэдний санал, үзэл бодол, шаардлага, гомдлыг цуглуулах замаар залуустай хоёр талын яриа хэлэлцээ өрнүүлэх.

Г. Залуусын саналыг хүлээн авах, хэлэлцүүлэг хийх, залууст олон талаар нээлттэй нам байх

- ✓ Залуучуудад хамаатай асуудлаар олон намын оролцоо, мэтгэлцээнийг дэмжиж, оролцох
- ✓ Гол нэр хүндтэй мэтгэлцээнд залуучуудтай холбоотой асуудлаа танилцуулах, хэлэлцүүлэх,
- ✓ Залуучуудад тулгамдаж буй асуудал, намын байр суурийн талаар мэдээлэл өгөх, сурталчлахын тулд ийм орон зайг ашиглах

Д. Залуустай шууд болон шууд бусаар уулзах

- ✓ Залуус байгаа газруудад тэдэнд хандсан хөтөлбөр, уриалга, мессежээ байрлуулах

Е. “Саналаа өгөөрэй” кампанит ажил зохион байгуулах

- ✓ Залуу сонгогчидтой нүүр тулан уулзаж “Саналаа өгөөрэй” кампанит ажлаа таниулах, сурталчлах
- ✓ Залууст хандсан кампанит ажлын гол мессежүүдийг гар утас, интернет болон социал медиа ашиглан түгээх

Ё. Сургуулиудад ажиллах

- ✓ Сонгуулийн хугацаанд залууст хандсан ямар хөтөлбөр, бодлого төлөвлөсөн талаар сурталчлах, таниулах хөтөлбөрийг сургуулиудад зохион байгуулах
- ✓ Улс төрийн асуудлаар оюутнуудтай нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх
- ✓ Оюутан залуусын дуу хоолой, санал хүсэлтийг сонсож, сонгуулийн дараа уг асуудлаар ямар үр дүнд хүрснээ танилцуулах

Ж. Залуустай ажилладаг сайн жишгүүдийг таниулж, тэдний төлөөллийг намдаа элсүүлэх

- ✓ Залуучуудтай өдөр бүр ажилладаг хүмүүсийг дайчлах, намын сонгуулийн үйл ажиллагаанд татан оролцуулах
- ✓ Нийгмийн амьдралд идэвхтэй оролцдоггүй залууст хүрч очихын тулд үе тэнгийнхнээр нь дамжуулж харилцах
- ✓ Өөрийн намын үзэл баримтлалыг дэмждэг залууст биш, залуу хүн бүрд залууст хандсан хөтөлбөрөө, мессежээ хүргэх

З. Уламжлалт улс төрийн намын хэв маягаас гарч олон нийтийн хөдөлгөөнт хэлбэрт шилжих

- ✓ Шууд бус болон уламжлалт хэлбэрээр залуучуудыг олноор нь

дайчлах үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх

- ✓ Нутгийн залуучуудын хамгийн их ашигладаг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон бусад мэдээллийн технологийн платформуудыг ашиглах
- ✓ Залуучуудын шууд бөгөөд хамгийн их тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд “нэг асуудал”-тай кампанит ажил өрнүүлэх
- ✓ Ийм кампанит ажил төлөвлөхдөө залуучуудтай хамтран ажиллах

И. Залуустай хамтран боловсруулсан сошиал сүлжээний мэдээллийн стратеги төлөвлөх

- ✓ Залуучуудын байгууллага болон бусад залуу гишүүдтэй хамтран залуучуудад ээлтэй мэдээлэл солилцох, зөвлөлдөх, санал хүсэлт гаргахад олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглах, олон нийтийн харилцааны стратегийг боловсруулах
- ✓ Өсвөр үеийнхний сонирхдог гол сэдвээр санал асуулга авах, хэлэлцүүлгийн форум, зөвлөлдөх уулзалт хийх гэх мэт дотоод интерактив хэрэгслүүдийг ашиглах
- ✓ Онлайн зөвлөгөө, хэлэлцүүлгээр дамжуулан залуучуудын харилцааг нам хэрхэн бодлого болгох, хэрэгжүүлэх, ашиглах талаарх байр сууриа тодорхой, ил тод болгох

Й. Уламжлалт нам сошиал сүлжээн дэх залуу “нөлөөлөгч” (Influencer) шиг ажиллах

- ✓ Залуучуудын гол нөлөөлөгчдийн адил олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглах
- ✓ Поп соёлынхон, урлагийнхантай хамтран ажиллах, тэдний дэмжлэгийг авах, залуучууд сайн дураараа хуваалцах олон нийтийн мэдээллийг бүтээх
- ✓ Залуучуудын байгаа газарт тулгуурлан харилцах бичил зорилтот стратеги боловсруулах. Энэхүү стратегиар залуусын оролцоог дэмжих, урамшуулах, эерэг мессеж түгээх

Дүгнэлт

Залуусын сонгуулийн оролцоог сайжруулах нэг гарц, хөшүүрэг нь залуу нэр дэвшигчдийг сонгуульд нэр дэвшүүлэх явдал юм. Мөн Монголын парламентын сонгууль зохион байгуулж ирсэн сонгуулийн систем нь залуу, шинэ гэхээсээ танигдсан, туршлагатай улс төрчийг ялах боломж олгодог байсан. 2024 оны парламентын сонгуулийн тогтолцоо өөрчлөгдсөн нь улс төрийн намууд шинэ, залуу нэр дэвшигчийг олноор нэр дэвшүүлэх, намын нэрсийн жагсаалтад багтаана

гэсэн хүлээлт буй. Гэсэн хэдий ч залуу нэр дэвшигч зөвхөн нэр дэвших босго давах тухай биш цаашлаад улс төрийн сонгуульд амжилттай оролцоход нөлөөлдөг хүчин зүйлийн талаар энэхүү өгүүлэлд товч хөндөн судаллаа. Тухайлбал, зарим судалгаагаар залуу болон ахимаг насны нэр дэвшигчдийн талаар сонгогч олон нийт ташаа төсөөлөлтэй байдаг үр дүн гарсан бол Ш.Хилл (2020) сонгуульд залуус нэр дэвшихэд өндөр өртөгтэй төдийгүй залуу нэр дэвшигч бэлтгэгдээгүй, бодит байдалд дээр залуу нэр дэвшигчийн хомсдолд орсон байна зэргээр дүгнэжээ.

Улс төрийн намаас нэр дэвших эрхээ авсан залуу нэр дэвшигчид маань намаа эргэн харах, нам дотроо ихээхэн өөрчлөлт хийх шаардлагатай байгааг “залууст ээлтэй улс төрийн нам”-шалгуурыг харахад төвөггүй ойлгогдоно.

Ном зүй

1. IRIM. БНОУХ. (2020). Залуусын санал бодлын судалгаа. Судалгааны тайлан
2. Charlotte Hill. (2021) Young people face higher voting costs and are less informed about state voting laws. Michael Jankowski, Stefan Muller (Eds.), *The Incumbency Advantage in Second-Order PR Elections: Evidence from the Irish Context, 1942–2019*, vol. 71, *Electoral Studies* (2020), Article 102331
3. Jana Belschner. (2024). Too young to win? Exploring the sources of age-related electoral disadvantage. *Electoral studies*. Volume 88, April 2024, 102748
4. Rainsford, E. (2017). Exploring youth political activism in the united kingdom: what makes young people politically active in different organisations? *Br. J. Politics Int. Relations* 19, 790–806. doi: 10.1177/1369148117728666
5. Toma DeJelan. (2018) Youth and political parties. A Toolkit for Youth-friendly Politics in Europe.
6. Thompson, Dennis F. 2010. Representing future generations: political presentism and democratic trusteeship. *Critical Review of International and Political Philosophy* 13(1): 17-37
7. UN. (2022). Be seen, be heard: Understanding young people’s political participation report. https://www.iknowpolitics.org/sites/default/files/full_report.pdf
8. Walton Family Foundation. (2023). Understanding the Gen Z Vote Post-Election Research Project.

УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

О.Ариунбилэг

Тогтвортой хөгжлийн төлөөх сэтгүүлзүй ТББ-ын тэргүүн

Хураангуй: Монгол Улс 1990 оноос хойш сонгуулийн ардчилсан зарчмуудыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 1992 онд Улсын Их Хурлын анхны сонгуулийг зохион байгуулжээ. Өнөөдрийг хүртэлх нийт 8 удаа УИХ-ын ээлжит сонгууль болсноос:

-1996, 2000, 2004, 2016 онуудад 1 мандаттай 76 тойрог,

-1992, 2008, 2020 онуудад олон мандаттай томсгосон тойрог,

-2012 оны ээлжит сонгуулийг сонгуулийн хосолсон тогтолцоогоор буюу 48 мандаттай 28 тойрог, 28 мандаттай пропорциональ системээр явуулсан юм. УИХ-ын Сонгуулийн тухай хуулийг 2005, 2011, 2015, 2020 онд өөрчлөн баталжээ. Хамгийн сүүлд 2023 оны зургаадугаар сард хуулийг батлах болсон шаардлага нь 2023 оны тавдугаар сард Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлттэй холбоотой юм. Улмаар тухайн оныхоо арванхоёрдугаар сард УИХ-ын тогтоол гарч, сонгуулийн тойрог, нутаг дэвсгэрийг тогтоов. Ийнхүү тогтоосон тойрог нь олны хүлээлтээс огцом өөрөөр эргэсэн зүйл байлаа.

Түлхүүр үг: УИХ-ын сонгууль, сонгуулийн зардал, сонгуулийн тухай хууль

Улсын Их Хурлын ес дэх удаагийн сонгуулийг Үндсэн хуулийн өөрчлөлт, түүнийг дагасан Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн өөрчлөлтийн хүрээнд холимог тогтолцоогоор, 126 гишүүнийг сонгох сонгуулийг 2024 оны зургаадугаар сарын 28-ны баасан гарагт зохион байгуулах гэж байна. Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлд “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно” хэмээн заасан. ¹

Дээрх хуулиудын шинэчлэлтэд жендэрийн квотыг тусгахдаа хувь тэнцүүлэн төлөөлөх буюу нам, эвслүүд жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай нэрсийг гаргахаар, мөн нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувьд хүйсийн квот тогтоож өгсөн нь жендэрийн эрх тэгш байдлын хувьд өмнө байгаагүй ололт болж байна. Өмнөх хуульд зааснаар аль нэг хүйсийн квотын доод хэмжээ 20 хувь байв. Цаашдаа 2028 оны УИХ-ын сонгуулиас эхлэн квотын доод хэмжээ 40 хувь болж өснө.

Монгол Улсын Дээд Шүүхэд албан ёсоор бүртгүүлсэн 37 нам байгаагаас УИХ-

ын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор 27 нам, 2 эвсэл Үндэсний аудитын газарт мөрийн хөтөлбөрөө илгээсэн.

Мөрийн хөтөлбөргүй субъект сонгуульд оролцох боломжгүй. Дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих мөрийн хөтөлбөрийг ҮАГ-аас хянах шаардлагыг Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд дараах байдлаар заажээ:

“Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар төрийн аудитын байгууллагаар хянуулж дүгнэлт гаргуулсан байна.”

Гэвч анх удаа Үндэсний Аудитын газраас мөрийн хөтөлбөрөө илгээсэн нийт 27 намын мөрийн хөтөлбөрийг “Дахин засварлах шаардлагатай” хэмээн дүгнэж, буцаасан юм. Хуульд заасны дагуу сурталчилгааны хугацаа болоогүй тул мөрийн хөтөлбөрт ямар засвар орсон талаарх дүгнэлтийг ҮАГ-аас сэтгүүлчид, олон нийтэд мэдээлэхгүй байхыг үүрэгдэв. Харин “Эрх чөлөөний эвсэл” нам мөрийн хөтөлбөрт нь хийсэн дүгнэлтийг твиттер хуудастаа ил тод нийтэлсэн бөгөөд энд бичсэнээр тус нам мөрийн хөтөлбөрийнхөө 2 дугаар заалтад “Засгийн газрыг цомхотгож, яамдуудын тоог 9-өөс дээшгүй байхаар хязгаарлаж, дэд сайд болон бусад данхар бүтцийг цомхотгоно” хэмээн заасан заалтад ҮАГ-аас “Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал 3.3.2-т заасан Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх гэж заасантай нийцэхгүй” гэсэн дүгнэлтийг хийжээ.

Мөн 18 дугаар заалтад “Төрийн өмчит компаниудыг бүхэлд нь хувьчилна” гэж заасныг “Засгийн газрын бүрэн эрхийн асуудал тул нийцэхгүй. Үндэслэл, тайлбар, тодруулга авах” гэх мэтээр дүгнэжээ. Энэ мэтээр зөвхөн тус намын мөрийн хөтөлбөрт тусгагдсан нийт 63 заалтын 40 заалтад нь “Засвар оруулах шаардлагатай” хэмээн буцаасан байна.

Эндээс харвал намуудын мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын урт хугацааны бодлого буюу Алсын хараа-2050-д нийцсэн байх гэдэг үндсэн шалгуурыг хангах нь нэг талаараа бодлогын залгамж байдал, урт хугацааны бодлоготой байх гэсэн үндсэн шаардлагын хувьд зөв байж болох ч, Алсын хараа-2050 бодлогыг зүүн төвийн үзэл баримтлалтай МАН-ын дангаар ноёрхлын үед баталсан гэж үзвэл барууны үзэл баримтлал, бодлогын өрсөлдөөн нэвтрэх боломжийг хааж байгаа хэлбэр гэж шүүмжлэлт талаас нь харж болох юм. Намуудын төлөөлөл ч энэ талаар өөрсдийн шүүмжлэлт байр суурийг илэрхийлснээс үүнийг харж болно.

Үндэсний аудитын газраас нам, эвслийн мөрийн хөтөлбөр хууль эрхзүйн шаардлага хангаагүй бол дөрөвдүгээр сарын 12-17-ны өдрүүдэд зөвлөмж өгөн,

алдаа зөрчлийг засуулах хуулийн хугацаатай. Ингээд дөрөвдүгээр сарын 26-ны өдөр нам, эвслүүдийн мөрийн хөтөлбөрийг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ. Харин бие даан нэр дэвшигчдийн хувьд дөрөвдүгээр сарын 22-24-ний өдрүүдэд Үндэсний аудитын газарт мөрийн хөтөлбөрөө дахин өгнө. Дөрөвдүгээр сарын 29-н гэхэд эцсийн байдлаар нам эвслүүд, нэр дэвшигчид албан ёсоор тодрох юм.

Мөрийн хөтөлбөр эцэслэсний дараа УИХ-ын сонгуульд нэр дэвшигчид тодорхой болно. УИХ-ын 2020 оны сонгуульд 15 нам, 4 эвсэл болон бие даагчид нийт 606 хүн нэр дэвшиж, 76 суудлын төлөө өрсөлдөж байв. Тэгвэл энэ удаад 126 суудлын төлөө 25 нам, 2 эвсэл (ҮАГ-аас дээрх бүрэн тоогоор зөвшөөрвөл) болон бие даагчид өрсөлдөх гэж байна. (Өмнөх сонгуулиудад нэр дэвшигчдийн тоог графикаар үзүүлэв)

График 1. Сонгуулийн кампанит ажлын сурталчилгааны хугацаа ба нэр дэвшигчдийн тоо



Одоогоор сонгогчдын саналын хуудас ямар загвартай байх, тэдгээрийг сонгогчид өмнөх сонгуулиудын хугацаанд бөглөж амжих эсэх нь тодорхойгүй байна. Өнөөдрийг хүртэл (2024.4.22) саналын хуудасны загвар эцэслэгдээгүй. Нэг зүйл хуульд заасанчлан тодорхой байгаа бөгөөд энэ нь ямар дарааллаар байрлах вэ гэдгийг заажээ. Энэ дагуу:

- намуудын нэрсийг саналын хуудсанд жагсаахдаа Дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллаар,
- эвслийн нэрийг тухайн эвсэлд нэгдэн орсон намуудаас хамгийн түрүүнд Дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллаар
- нам эвслээс тойрогт нэр дэвшигчийг тухайн нам, эвслээс тойрогт ирүүлсэн дарааллаар
- бие даан нэр дэвшигчийг Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн дарааллыг баримтлан нам, эвслээс тойрогт нэр дэвшигчдийн нэрсийн дараа тус тус эрэмбэлнэ.

Энэ эрэмбээр 27 нам, 2 эвсэл нь дараах байдлаар саналын хуудаст дугаарлагдана. Үүнд:

№	Намын нэр	Бүртгүүлсэн он	Намын дарга
1	Монгол Ардын нам	1990.5.16	Л.Оюун-Эрдэнэ
2	Ардчилсан намт	2000.12.26	Л.Гантөмөр
3	Үндэсний эвсэл (Монголын Ногоон нам, МҮАН)	1990.05.26	Н.Номтойбаяр
4	Иргэний зориг ногоон нам	2000.03.23	Б.Батбаатар
5	Шинэ нэгдсэн эвсэл (МУНН, Шинэ нам)	1994.01.14	Б.Батболд
6	Монголын Либерал Ардчилсан нам	1998.05.21	Д.Пүрэвдаваа
7	Эх орон нам	1998.12.22	Б.Эрдэнэбат
8	Монголын Либерал нам	2000.01.28	Э.Оргил
9	Бүгд Найрамдах нам	2004.04.05	Б.Жаргалсайхан
10	Монголын Социал Демократ нам	2005.01.20	А.Ганбаатар
11	Ард түмний нам	2005.12.21	Л.Гүндалай
12	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	2007.02.09	Ш.Төмөрсүх
13	Иргэний хөдөлгөөний нам	2007.10.17	Ө.Баяраа
14	Хөгжлийн хөтөлбөр нам	2007.10.30	О.Заяа
15	ХҮН нам	2011.12.05	Т.Доржханд
16	Эх орончдын нэгдсэн нам	2012.03.12	Г.Ганбат
17	Монголын Консерватив нам	2012.10.23	Н.Дашдаваа
18	Үнэн ба Зөв нам	2017.06.07	А.Отгонбаатар
19	Эрх чөлөөний эвсэл Зон олны нам	2017.06.30	Б.Цацрал
20	Ард түмний олонхийн засаглал нам	2018.12.21	А.Батдорж
21	Их эв нам	2018.12.21	З.Бат-Отгон
22	Гэр хорооллын хөгжлийн нам	2019.01.07	Б.Батсүх
23	Монголын шинэчлэлт нам	2019.06.26	Н.Жамсран
24	Зүй ёс нам	2019.09.12	Б.Насанбилэг
25	Ардчилал шинэчлэлийн нам	2020.02.21	Э.Бямбацэрэн
26	Иргэдийн оролцооны нэгдэл нам	2022.05.20	Ц.Оюунгэрэл

27	Сайн иргэдийн нэгдсэн нам	2023.05.08	Б.Жагар
----	---------------------------	------------	---------

Харин нэр дэвшигчдийн нэрс одоогоор тодорхой болоогүй байна. Сонгуулийн санал авах өдөр зургаадугаар сарын 28-ны баасан гараг бөгөөд нэр дэвшигчид 10-ны бямба гарагт нэр дэвшигчийн үнэмлэхээ гардан авна. Ингээд сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхэлнэ.

Монгол Улсыг 13 тойрогт хуваасан бөгөөд дээр өгүүлсэнчлэн 78 суудлын төлөө нэр дэвшигчид, 48 суудлын төлөө нам, эвслүүд томгосон тойрогт өрсөлдөнө.

Тойрог ба сонгогчдын тоо

Тойрог ба мандатын тоо	Тойргийн нутаг дэвсгэр	Тойргийн сонгогчдын тоо	Нийт сонгогчийн тоо (2020)	Нийт сонгогчийн тоо (2024.4.1-ий байдлаар)	Нийт сонгогчийн тоо (2024)	Нэг мандатад ноогдох сонгогчийн тоо
Нэгдүгээр тойрог. 9 мандаттай	Архангай	61194	192135	61059	192842	21426
	Өвөрхангай	74367		75185		
	Баянхонгор	56574		56598		
Хоёрдугаар тойрог. 10 мандаттай	Говь-Алтай	37448	191204	37619	195218	19521
	Завхан	47388		46981		
	Увс	52121		53854		
	Ховд	54247		56764		
Гуравдугаар тойрог. 3 мандаттай	Баян-Өлгий	59386	59386	69289	69289	23096
Дөрөвдүгээр тойрог. 8 мандат	Булган	40877	193605	40882	201264	25158
	Хөвсгөл	85997		88741		
	Орхон	66731		71641		
Тавдугаар тойрог. 10 мандат	Дархан-Уул	65074	197095	70600	204788	20478
	Сэлэнгэ	70283		71472		
	Төв	61738		62716		
Зургаадугаар тойрог. 7 мандат	Дорнод	52159	142523	53192	146649	20949
	Сүхбаатар	40731		41819		
	Хэнтий	49633		51638		
Долоодугаар тойрог. 7 мандат	Говьсүмбэр, Дундговь	40824	130278	41626	135843	19406
	Дорноговь	44633		45850		
	Өмнөговь	44821		48367		

Нийслэлд мандат хуваарилалт						
Наймдугаар тойрог. 5 мандат	Баянзүрх	221758	221758	275517		55103
Есдүгээр тойрог. 3 мандат	Баянгол	134872	134872	165786		55262
Аравдугаар тойрог. 6 мандат	Сүхбаатар	86814	183453	103845		34524
	Чингэлтэй	96639		103304		
Арваннэгдүгээр тойрог. 5 мандат	Сонгино-хайрхан	195329	195329	221951		44390
Арванхоёрдугаар тойрог. 3 мандат	ХУД	114446	114446	174326		58108
Арвангуравдугаар тойрог. 2 мандат	Багануур, Багахангай, Налайх	44540	44540	49556		24778
Нийт сонгогчийн тоо			2000624		2240178	

Хүснэгт 1: Мэдээллийн эх сурвалж: СЕХ (2024 оны тоо нь дөрөвдүгээр сарын 1-ний байдлаарх тоо бөгөөд иргэдийн шилжилт хөдөлгөөнийг дөрөвдүгээр сарын 29-нөөс сонгуулийг дуустал түр зогсооно.)

Сонгуулийн сурталчилгаа 17 хоног. Өмнөх 2020 оны УИХ-ын сонгуулиар сурталчилгааны хугацаа 21 хоног байв. Гэвч энэ хугацаа сурталчилгаа явуулахад хүрэлцэхгүй байсан талаар нэр дэвшигчид ярьдаг. Тэгвэл энэ удаагийнх томсгосон тойрогт буюу 2-3 аймаг, нийслэлийн нэг бүтэн дүүргийн хэмжээнд нэр дэвшиж, 126 суудлын төлөө өрсөлдөх мянга гаруй хүнээс тодорч тойргийнхондоо танигдах, мөрийн хөтөлбөр, бодлогоо танилцуулахад дэндүү бага хугацаа юм.

УИХ-ын Сонгуулийн тухай хуулийг 2023 оны зургаадугаар сард баталсан бол тойрог томсгох УИХ-ын тогтоолыг 2024 оны арванхоёрдугаар сард баталсан. Тухайлбал,

46.6.Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт нэг цаг /60 минут/-аас илүүгүй байна.

46.7.Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хоногт гарах нийт хугацаа /60 минут/-ны хорин таваас илүүгүй хувь /15 минут/ нь нэг нам, эвсэлд, түүнчлэн бие даан нэр дэвшигчдэд ногдоно гэж заасан.

Дээрх заалтыг батлахдаа тойргийн газар нутгийг бүсийн хэмжээнд баталж, нэр дэвшигч нам, эвсэл нь гурван аймгийн газар нутгийг сурталчилгааны 17 хоногийн хугацаанд туулж чадахгүй бол телевизийн дэлгэцээр сонгогчидтойгоо уулзах боломжтой байна гэдэг боломжийг харгалзаж үзээгүй нь лавтай.

Сонгуулийн сурталчилгаанд самбар, телевиз, цахим сурталчилгаа, уулзалт, хурал гэх зэрэг хэд хэдэн төрөл бий. Гэвч эдгээрээс “мөлхөө сурталчилгаа” буюу иргэдтэй нүүр тулсан уулзалтуудыг хийх нь хамгийн үр дүнтэй талаар “УИХ-ын

сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн зардлыг бууруулах боломж, арга зам”¹ судалгааны ажилд дурьджээ. Сурталчилгааны хоногт тойргийнхоо бүх хороогоор орж уулзалт хийж амждаггүй гэдгийг дээрх судалгаанд оролцогчид ярьжээ².

Зөвхөн Баянзүрх дүүргээр жишээ татахад 43 хороотой бөгөөд энэ удаагийн сонгуульд нэр дэвшигч сурталчилгааны арга хэрэгслүүдээс зөвхөн иргэдтэй уулзах төрлийг сонгосон ч 17 хоног нь хүрэлцэхгүй. Өөрөөр хэлбэл, шинэ залуу болон эмэгтэй нэр дэвшигчдийн хувьд сурталчилгааны хугацаа-газар нутгийн хэмжээ нь тэднийг УИХ-д сонгогдох боломжгүй гэдгийг илэрхийлнэ.

Боломж тааруу байдал зөвхөн газар нутгийн хэмжээ, сурталчилгааны хугацаагаар зогсохгүй. Нэр дэвшигч, нам, эвслийн зарцуулах зардлын дээд хэмжээг Үндэсний аудитын газраас зарласан бөгөөд энэ зардлын дээд хэмжээг харвал 1 тэрбум төгрөгтэй байхыг албан ёсоор зарласан байна.

Тойрог ба мандатын тоо	Тойргийн нутаг дэвсгэр	Нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээ	Нам эвслийн зардлын дээд хэмжээ
Нэгдүгээр тойрог. 9 мандаттай	Архангай	1,378,983,796	574,308,107
	Өвөрхангай		
	Баянхонгор		
Хоёрдугаар тойрог. 10 мандаттай	Говь-Алтай	1,526,054,380	659,785,964
	Завхан		
	Увс		
	Ховд		
Гуравдугаар тойрог. 3 мандаттай	Баян-Өлгий	1,058,746,682	261,992,747
Дөрөвдүгээр тойрог. 8 мандат	Булган	1,230,485,598	487,060,273
	Хөвсгөл		
	Орхон		
Тавдугаар тойрог. 10 мандат	Дархан-Уул	1,064,320,563	498,096,846
	Сэлэнгэ		
	Төв		

1 О.Ариунбилэг 2023. (МУИС, Улс төр судлалын тэнхимийн магистр)“УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн зардлыг бууруулах боломж, арга зам” магистрын ажил

2 Мөн судалгаанд

Зургаадугаар тойрог. 7 мандат	Дорнод	1,164,854,766	474,369,193
	Сүхбаатар		
	Хэнтий		
Долоодугаар тойрог. 7 мандат	Говьсүмбэр , Дундговь	1,098,521,799	469,951,439
	Дорноговь		
	Өмнөговь		
Наймдугаар тойрог. 5 мандат	Баянзүрх	1,164,541,061	640,984,301
Есдүгээр тойрог. 3 мандат	Баянгол	1,099,697,551	488,776,433
Аравдугаар тойрог. 6 мандат	Сүхбаатар	894,773,229	569,801,654
	Чингэлтэй		
Арваннэгдүгээр тойрог. 5 мандат	Сонгинохайрхан	968,576,569	590,595,221
Арванхоёрдугаар тойрог. 3 мандат	ХУД	1,121,664,599	435,352,153
Арвангуравдугаар тойрог. 2 мандат	Багануур, Багахангай, Налайх	994,256,563	283,456,891

Дээрх зардлын дээд хэмжээг хэрхэн тогтоосноо мөн УАГ-аас дэлгэрэнгүй танилцуулсангүй. Үүнийг 2020 оны сонгуулийн дүнтэй харьцуулан харвал, тухайлбал Баян-Өлгий аймагт нэр дэвшигчийн зардал хоёр дахин нэмэгджээ. Гэвч газар нутгийн хэмжээнд өөрчлөлтгүй. Мөн нэгдүгээр тойрог болох Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгуудын хувьд өнгөрөгч сонгуулийн зардлын дээд хэмжээг нэгтгэн үзвэл 1,1 тэрбум байх бөгөөд энэ удаад 1,5 тэрбум болж нэмэгджээ. Газар нутгийн хувьд том байх нь зардал илүү гарахад нөлөөлөх тул ийнхүү нэмэгдсэн байж болзошгүй хэмээн таамаглаж байна. Учир нь, 2020 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд дүн шинжилгээ хийсэн “УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн зардлыг бууруулах боломж, арга зам” судалгаанд дурьдсанаар, Улаанбаатар хотын хувьд жижиг нутаг дэвсгэртэй Чингэлтэй, Сүхбаатар, Баянгол дүүрэгт нэр дэвшигчдийн зардал Сонгинохайрхан, Баянзүрх зэрэг том нутаг дэвсгэртэй тойрогт зарцуулснаас харьцангуй бага байжээ. Гэх мэтээр сонгуульд нэр дэвшигчийн зардал огцом нэмэгдсэн нь нэр дэвшихээр төлөвлөж байсан залуучууд, эмэгтэйчүүдэд хүнд цохилт боллоо. Тиймээс нэр дэвших шийдвэрээсээ буцаж буйгаа илэрхийлэх нь ч байна.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагын нэг нь нэр дэвшигчдийн зардлыг бууруулах хэмээн төслийг санаачлагчид ярьж байв. Тухайлбал, УИХ-ын Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах төслийн Ажлын хэсгийн ахлагч Д.Тогтохсүрэн “Хуульд өөрчлөлт оруулснаар зардал 45 хувиар буурна” хэмээн чуулганы танхимд 2023 оны зургаадугаар сарын 8-ны өдөр хэлсэн.

Нэр дэвшигчийн А самбарыг болиулж нэгдсэн самбар байршуулан зардлыг орон нутгийн засаг захиргаанаас гаргах, ухуулагчийн тоог цөөрүүлж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас хэтрэхгүйгээр урамшууллыг олгох, тээврийн хэрэгслийн тоог хоёр дахин бууруулах, хэвлэмэл материалын тоог цөөрүүлэх өөрчлөлтийг баталсан. Мөн тв-ийн хувьд сонгуулийн сурталчилгаа эфирийн нийт цагийн 60 минутаас хэтрэхгүй байх, мэдээнд нэг нэр дэвшигч, нам эвслийн мэдээ 5 минутаас хэтрэхгүй байх, цахим орчны сурталчилгааг нийт сурталчилгааны зардлын 15 хувиас хэтрэхгүй байхаар хуульчилсан юм.

Энэ хуулийн өөрчлөлт нь 2023 оны арванхоёрдугаар сарын 21-ний өдрийн УИХ-ын чуулганы хуралдаанаар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, УИХ-ын сонгуулийн тойргийг хөдөө орон нутагт 7, Улаанбаатар хотод 6 нийт 13 байхаар тогтоохоос даруй зургаан сарын өмнө гэдгийг дээр дурьдсан.

Гэтэл зардлыг хэмнэх зорилгоор өөрчилсөн Сонгуулийн тухай хуулийн өөрчлөлтийн үр дүнг УИХ-ын тогтоол нь үгүйсгэж, харин ч зардлыг хоёр дахин нэмэх болгоод зогсохгүй, зардлыг бууруулахаар сурталчилгааны хэлбэрүүдийн тоо хэмжээг бууруулсан заалтууд хэвээр байгаа нь том тойрогт нэр дэвшигчдийн сурталчилгааг 17 хоногт явуулах ямар ч боломжгүй болгож, гацаанд оруулсан хэлбэр болов.

Дүгнэлт

“Сонгуулийн зардлыг бууруулна” гэж баталсан хуультай, бодит амьдрал дээрээ зардлыг нэмэгдүүлсэн УИХ-ын тогтоолтой сонгууль болох нь. Том тойрогт, богино хугацаанд, “хэмнэсэн” сурталчилгаатай энэ сонгуульд зөвхөн олны танилууд, улс төрд олон жил болсон “архагууд”, одоо ажиллаж буй УИХ-ын гишүүд л дахин сонгогдох магадлал нь илүү. Учир нь хуулийн 41.9-д Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй хэмээн заасан нь УИХ-ын гишүүдэд давуу тал болж байгаа юм.

Мөн тогтоолоор тойргийн газар нутгийг тогтоох нь хуулиас давах эрсдлийг дагуулж болзошгүйг энэхүү нийтлэлээр өгүүллээ.

Төгсгөлд нь сонирхуулахад, манай улс 2012 оны сонгуулиас эхлэн “Сонгуулийн автоматжуулсан систем”-ээр сонгуулийг зохион байгуулж ирсэн бөгөөд энэ хүрээнд санал тоолох төхөөрөмжийн иж бүрдэл, сонгогчийн бүртгэлийн иж бүрдэл багтдаг. Энэ удаад ч энэхүү автоматжуулсан системээр явагдана. Харин хяналтын тооллого өмнөх сонгуульд 50 хувь гараар хийгдэж байсан бол энэ удаагийн сонгуулиас 100 хувь гараар тоолохоор болсон.

Ардчилсан Намын дарга Л.Гантөмөртэй хийсэн ярилцлага

Сэтгүүлч Ц.Эгиймаа

“АЛС ХЭТДЭЭ АРДЫН НАМ, АРДЧИЛСАН НАМ ГЭСЭН ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ХОЁР ТОМ НАМЫН ХООРОНД ҮЗЭЛ САНААНЫ ӨРСӨЛДӨӨН ЯВАГДАХ БОЛОМЖТОЙ ГЭЖ ХАРЖ БАЙНА”



Сонгуулийн шинэ тогтолцоог та юу харж байна вэ? Одоо болох парламентын сонгуульд танай намын хувьд хэрхэн нөлөөлөх бол?

Нэн тэргүүнд бид парламентын засаглалыг бэхжүүлэхийн тулд шинэ тогтолцоог сонгосон. Ингэснээр парламентын гишүүдийн гүйцэтгэх засаглалд үзүүлж буй нөлөөллийг бууруулах, цаашлаад парламентын гишүүдийн хувийн ашиг сонирхлыг бууруулах ач холбогдолтой. Гишүүдийн тоо нэмэгдсэнээр парламент нь хууль тогтоох байгууллага гэдэг үндсэн үүргээ чанартай биелүүлэх боломжтой. Түүнчлэн холимог тогтолцоог сонгосноор санал гээгдэхгүй. Өөрөөр хэлбэл, ард түмний сонгосон төлөөлөл парламентад суудалтай болж, олон намын тогтолцоо бий болно. Саналын 40 орчим хувийг авчихаад парламентын суудалд 80, 90 хувийг эзэлдэг үзэгдэл үндсэндээ байхгүй болж байгаа юм. Мөн эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлснээр Монгол улсад жендэрийн бодлогыг хүчтэй болгох суурь нь тавигдаж байна гэж харж байна.

Нөгөөтээгүүр, парламентын гишүүдийн тоо нэмэгдсэнээр популист улс төрчдийн тоо нэмэгдэх үр дагавар мөн бий. Тухайлбал, хувь тэнцүүлсэн зарчмаар өндөр санал авахын тулд популист улс төрчдийг дэвшүүлэх хандлага байдаг. Тиймээс дэгийн хуулийг хэлэлцэх хэрэгтэй. Дэгийн хуулийг хэлэлцэж байж олон гишүүн санал бодлоо нэг дор олноор хэлдэг хүндрэлээс сэргийлж чадна. Энэ нь ХБНГУ-ын Бундестаг, Японы доод танхимын жишгийн дагуу байж болно. Ингэснээр парламентад суудалтай намын бүлгүүдийн үүрэг тодорхой болох юм. Бүлгүүдийн үүрэг тодорхой болсноор парламент нь үзэл санааны талбар болж, хөгжих учиртай.

Сонгуулийн шинэ тогтолцооны өөр нэг онцлох хэсэг бол томсгосон тойрог. Тойрог томссоноор хөгжлийн бодлого ялгарах болов уу гэсэн хүлээлттэй байгаа. Учир нь 76 гишүүн тал тал тийшээ Монголын “жижигхэн” төсвийг тарааснаас болоод хөгжлийн хөрөнгө оруулалт их дутагдаж байна. Хөгжлийн хөрөнгө оруулалт дутагдсанаас болоод үнэтэй зээл рүү шилждэг, үнэтэй зээл нь өр болдог. Хөгжлийн бодлогыг гаргаж ирснээр дээрх эдийн засгийн эрсдэлтэй үйл явцаасаа сална гэж найдаж байгаа юм. Хоёрдугаарт, төсөв мөнгө ярьвал Монгол улсад “мөнгөний сонгууль” хавтгайрсан. Тийм учраас тойрог томссоноор мөнгө тарааж санал авдаг хүний тоо багасна. Цаашлаад алс хэтдээ Ардын нам, Ардчилсан нам гэсэн үндэсний хэмжээний хоёр том намын хооронд үзэл санааны өрсөлдөөн явагдах боломжтой гэж харж байна. Ардчилсан намын хувьд өнгөрсөн гурван жилийн хугацаанд сонгуулийн бэлтгэлээ базааж чадаагүй гэдэг дутагдал бий. Гэхдээ бид маш богино хугацаанд зохион байгуулалт хийж чадсан учраас намын даргын хувьд намынхаа зохион байгуулалтаар ялагдахааргүй болсон гэж харж байгаа. Бид мөрийн хөтөлбөрийн уралдаан руу чиглэхийг хүсэж байна. Хэрэв мөрийн хөтөлбөрийн хийгээд үзэл санааны жинхэнэ уралдаан бий болгож чадвал манай намын хувьд томсгосон тойрог дээр сул тал харагдахгүй байна.

Томсгосон тойргийн сул талыг та юу гэж харж байна вэ? Сонгуулийг том тойргоор зохион байгуулснаар гарах сонгуулийн дараах үр дагаварыг та хэрхэн төсөөлж байна вэ?

Үр дагаварын тухайд, хэт олонх төрөхөөргүй болж байгаа. Томсгосон тойрог бол мажоритар тогтолцооноос холдож байгаа хэрэг. Тиймээс харьцангуй тэнцвэртэй парламент бүрдэнэ. Тэнцвэртэй парламент гэдэг нь нэг нам нөгөө намаа ялгаварлан гадуурхдаггүй, үзэл санаанаасаа урваж байж сайхан амьдардаг гэдэг үзлээс хол байхыг хэлж байгаа юм. Ардчилсан намын тухайд танигдаагүй гэдэг асуудал яригдаад буй. Эсрэгээрээ, хэчнээн танигдчихаад найман жил ажил хийгээгүй хүмүүсийг иргэд дахиад сонгохгүй гэдгийг судалгаанууд хэдийнэ харуулаад эхэлчихсэн. Тэгэхээр шинэ, залуу хүмүүсийн хувьд, өөрийгөө таниулж,

өөрийнхөө дэвшүүлж байгаа бодлогыг ойлгуулж чадах юм бол амжилтад хүрэх нь эргэлзээгүй юм. Ард түмэн бол шударга, залуу, элдэв асуудалд холбогдоогүй, боловсролтой, бодлого боловсруулж чадах хүмүүсийг л хүсэж байгаа. Харин бид тэд залуусыг олж дэвшүүлэх нь л чухал юм.

Танай нам нэрийн жагсаалтаа ямар шалгуур, шаардлагыг хангасан нэр дэвшигчдээс бүрдүүлж байна вэ?

Намын гишүүдээс хамгийн өндөр санал, дэмжлэг авсан хүмүүсээ нэн тэргүүнд дэвшүүлнэ. Харин түүний дараа ардчиллын үзэл санаандаа тууштай байгаа хэсгээ дэмжинэ. Ардчилсан нийгмийг хамгаалахын төлөөх үзэл санаандаа үнэнч, популизмд автагдаж, үзэл санаанаасаа ухраагүй хүмүүсээ аль болох дэмжинэ л гэсэн үг. Гуравдугаарт, нийгмийн олон талт байдлыг харгалзан үзэхийг зорьж байгаа. Жишээлбэл, нийгэмд дуу хоолой нь бүрэн хүрч чадахгүй, орхигдсон салбаруудаас төлөөллийг нь оруулахын тулд богино хугацааны сонгон шалгаруулалт зарлана. Үүнд эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээний салбаруудыг дурдаж болно. Эдгээр салбараас төлөөлөл болж чадах, нэр дэвших хүсэлтэй хүмүүсийг дэмжих нь сонгуулийн шинэ тогтолцооны хүрээн дэх бас нэг давуу тал болж байгаа.

Ардчилсан намын үзэл баримтлалыг та хэрхэн тодорхойлох вэ? Ардчилсан нам уг үзэл баримтлалынхаа хүрээнд ажиллаж чадаж байгаа гэж та харж байна уу?

Ардчилсан нам бол Монголчуудад улс төрийн эрх чөлөөг нь авчирсан нам. 1990 оны 4-р сарын 7-нд Ардчилсан нам бүртгэгдсэнээр Монголын ард түмэн улс төрийн сонголтоо өөрсдөө хийдэг болсон юм. Монголчуудад улс төрийн эрх чөлөөг нь ингэж авчирсан нам цаашид эдийн засгийн эрх чөлөөг нь авчрахын төлөө тэмцэх учиртай юм байна. Өнөөдөр бүтэн ардчиллын талаар их ярих болсон. Учир нь гажуудсан ардчиллыг засах нь бидний үүрэг болж байгаа юм. Харин социализмыг бүтээх гэж явсан нам ийм үүрэг хүлээхгүй. Нам хаанаас үүсэх вэ гэдэг хүн хаанаас төрөхтэй адил. Ямар ч залуу хүн эцэг эхийнхээ үйл хэргийг үргэлжлүүлдгийн адилаар энэ нам үүсэхдээ Монгол Улсад улс төрийн тусгаар тогтнол авчирсан. Тиймээс бид цаашид улс төрийн тусгаар тогтнолоо хадгалж, ардчилсан нийгмийг бэхжүүлэх үйлсээ бүтээх хариуцлага хүлээж байгаа юм. Үүний тулд эдийн засгаа хөгжүүлж, босгох нь чухал. Хүндээ зориулсан эдийн засгийн орчныг бүрдүүлж, “Мөнгөтэй Монгол хүн”-ий төлөө бодлого баримтлах учиртай.

Ардчилсан нам бол парламентын сөрөг хүчин. Үүгээрээ бусад намуудаас бодлогын хувьд яаж ялгарч байна вэ?

Ардчилсан нам Монгол Улсыг өрнөөс гаргая гэдэг том стратегиа зарласан. Монгол Улс гадаад бодлого болон эдийн засгийн бодлогын хувьд өрний барьцаанд орчихсон. Тиймээс бид өрнөөс гарч байж л эдийн засгийн тусгаар тогтнолыг ярих юм. Түүнчлэн эрчим хүчний хараат байдлаас гарах хэрэгтэй. Бензин, цахилгаан тогны асуудлууд бүгд энэ эрчим хүчний хараат байдал гэдэгт орж байгаа. Харин эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт ихээр татаж чадсанаар эрчим хүчний хараат бус байдал бий болж, энэ нь эдийн засгийн тусгаар тогтнолд хүргэх юм. Дараагийн ялгарах онцлог бол бизнесийн сайн орчин. Төрийн бизнест оролцож байгаа оролцоог хумиснаар эдийн засгийн салбар аль нэг дарга, засгийн газарт биш “Монгол хүн, иргэн” дээрээ очих юм.

Таныг боловсролын сайдаар ажиллаж байх үеийн боловсролын салбарын нөхцөл байдлыг одоо үетэй харьцуулан үзвэл юу хийх зайлшгүй шаардлагатай харагдаж байна вэ?

Бид боловсролын салбарт өөрчлөлт авчрах гэж их оролдсон. Үүнд Кэмбрижийн хөтөлбөрийг дурдах нь зүйтэй. Кэмбрижийн хөтөлбөрөөс гадна ХБНГУ, Японы боловсролын хөтөлбөрүүдээс туршлага судалсан. Эдгээр хөтөлбөр нь 10 жил тутамд шинэчлэгдэж байдаг гэдгээрээ онцлогтой. Бид энэ хөтөлбөрүүдээс хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх шаардлагатай гэдгийг ойлгосон. Өөрөөр хэлбэл, хүн нэг бүр ялгаатай учир бүгдийг нь адилтгах гэж оролдох шаардлагагүй гэдэг ойлголтыг нэмэгдүүлэх гэж эрмэлзсэн. Улмаар хүүхэд нэг бүрийн чаддаг зүйлсийг хөгжүүлж, амьдрах чадвартай, суралцах чадвартай хүнийг төрүүлдэг хөтөлбөрийг бид боловсруулсан юм. Харамсалтай нь Засгийн газар солигдож, намайг ажлаа өгснөөс хойш олон сайд боловсролын сайдын албыг хашив. Гэвч бүгд ухарч, шинэ зүйл рүү явах итгэлгүй болсон. Тиймээс энэ хөтөлбөрийг дахин сэргээх ёстой. Амьдрах ухаантай, тэмцэх чадвартай, сурах чадвартай Монгол хүн төрүүлдэг сургалтын хөтөлбөрийг дахин сэргээх ёстой л гэж хэлээд байгаа юм. Дараагийн миний анхаарч ажилласан ажил бол инженерийн салбарт онцгой ач холбогдол өгсөн явдал. Инженерийн боловсролыг бага сургуулиас нь л сургалтын хөтөлбөрт системтэйгээр оруулахаар зорьсон. Физикийн хуулиудыг гараараа хийх буюу ямар нэг зүйл бүтээж, цахим орчинд ашиглаж, робот бүтээе зэрэг зорилтуудын хүрээнд 9-р ангиас нь дээд боловсрол олгохын тулд гурван коосэн байгуулсан. Японд 1000 инженер сургаж, ХБНГУ-аас технологийн дээд сургууль оруулж ирсэн нь одоо Налайх дүүрэгт үйл ажиллагаагаа явуулж байна. ХБНГУ-ын технологи, Японы инженерийн

сургалтыг нэвтрүүлснээр гараараа бодитой зүйл бүтээж чаддаг инженертэй болох боломжтой болсон юм. Гуравдугаарт, шинжлэх ухааны орон болох зорилт тавьж байсан. Энэ зорилтынхоо хүрээнд АНУ-ын шилдэг их сургуулиудад залуучуудаа сургах бодлого хэрэгжүүлж, 400 гаруй оюутан явж суралцсан. Мөн бид дэлхийн шилдэг технологийн их сургууль болох Массачусэтсийн технологийн институттай гэрээ хийсэн. Тодруулбал, Монголын шинжлэх ухааныг дэлхийн түвшинд гаргах хамтын ажиллагааны төлөвлөгөө гэж засгийн газрын хурлаар баталж байсан юм. Би өөрөө тус институт дээр очоод энэ гэрээг хийж, улмаар манай улс маш богинохон хугацаанд шинжлэх ухааны бүтээл гаргадаг, инновац хийдэг улс болох боломжтой байсан. Гэвч намайг сайдын ажлаа өгснөөс хойш энэ ажил урагшлаагүй, зогсчихсон. Тиймээс бид дахиад үүнийг ажил хэрэг болгох хэрэгтэй, угаас боловсролын салбарт шинэчлэл хэрэгтэй. Бид боловсрол хийгээд эрүүл мэндийн салбарыг социалист хэвээр нь аваад үлдчихсэн. Гэтэл зах зээлийн эдийн засаг, хүн төрөлхтний чөлөөт сэтгэлгээн дунд Монгол хүний амьдрах, тэмцэх чадвар унаад байна. Яагаад гэвэл төлөвлөгөөт эдийн засагтай тийм нийгэмд амьдраад, өсчихсөн хүмүүс чөлөөт нийгэмд хөл алддаг юм байна. Сэтгэл зүй нь ч бэлэн болоогүй, өрсөлдөх чадваргүй хүмүүсийг бид бэлтгэж байгаа. Иймийн тулд Монголын боловсролыг шинээр тодорхойлох зайлшгүй хэрэгтэй. Энэ салбарыг чөлөөлж, илүү чөлөөт өрсөлдөөн рүү, арга барил руу чиглүүлэх нь зөв юм. Бид заах гэхээс илүү сурах чилэлд боловсролыг төвлөрүүлэх гэж хичээсэн. Боловсрол судлалыг Монгол Улсад одоо ч хөгжүүлэх нэн шаардлагатай байна. Тухайлбал, тэргүүлэх эрдэмтдийг дэлхийн жишигт хүргэж, багш бэлдэх тогтолцоо, үнэлгээ, сургалтын хөтөлбөр, агуулгад цогц анхаарах цаг нь хэдийнэ болсон. Эцсийн зорилго нь өндөр бүтээмжтэй үйлдвэрлэл хийж чадах ард түмэнтэй болох юм. Түүнчлэн дан түүхий эд экспортлогч орон байх нь ирээдүйд бидэнд үр ашиггүй. Энэ мэтчилэн маш олон, чухал шалтгаануудын улмаас боловсролыг үндсээр нь өөрчлөх хэрэгтэй гэж харж байна.

Сүүлийн жилүүдэд Ардчилсан намын дотоод үйл явдлууд олны анхаарлын төвд байлаа. Сонгуулийн дараа намын дотоод ардчилал, санхүүжилтаа Үндсэн хуулийн өөрчлөлтөд хэрхэн нийцүүлэх вэ?

Улс төрийн нам хаалттай, харанхуй байгаа нь манай нийгмийн бас нэг том асуудал. Тухайлбал, олон нийтийн дунд улс төрийн нам авлигалд баригдсан, авлигачдыг төрүүлдэг гэх хардлага их бий. Энэ бол мэдээж зүй ёсны хардалт. Ингэж ч ажил хэргээ гүйцэлдүүлдэг хүмүүс байдаг нь ч үнэн. Улс төрийн нам төрийн албатай хэт хутгалддаг зэрэг асуудлуудаас ангид байхын тулд бид улс төрийн намын тухай шинэ хуулиа баталсан. Энэ хуулиар тодорхой болсон зүйл нь намуудын санхүүжилтийг парламент дахь суудлаар нь зохицуулах болсон

тухай юм. Өөрөөр хэлбэл, хэн нэгнээс мөнгө авч байж нам хөдөлдөг бус, төр нь өөрөө санхүүжилтээр улс төрийн намаа институт болж хөгжих боломжийг нээж өгч байна. Тиймээс бид энэ хуулийг чандлан мөрдөх суурь өөрчлөлтүүдээ хийж байна. Тодруулбал, улс төрийн намын үйл ажиллагаа мөнгөө зарцуулах гурван чиглэл бий. Нэгдүгээрт, судалгаанд мөнгө зарцуулах буюу нийгмийн чанараа байнга судалж байх хэрэгтэй. Хоёрдугаарт, сургалтын байгууллагатай болох ёстой. Өөрийн үнэт зүйлийг түгээж чадсанаар эсрэг талын суртал ухуулгад автахгүй байх боломжийг олон нийтэд бүрэлдүүлж байгаа юм. Тиймээс “бие даасан, өөрөөрөө” Монгол хүнийг олон байлгахын тулд сургалтууд явуулах нь зөв шийдэл болж буй. Энэ сургалтын байгууллага ч бид байгуулчилсан байгаа. Гуравдугаарт, намын хүний нөөцийг нэмэгдүүлэх. Бид дараагийн үеэ, дараагийн лидерүүдээ бэлдэх хөтөлбөрүүдээ олон улсын байгууллагуудтай хамтран бэлдэж эхэлж байна.

Манай намын хувьд дээрх чиглэлээр санхүүжилтээ шийдвэрлээд явна. Ер нь манай улсад нэг нам нь том байртай, түүнийгээ түрээслээд ч болтугай мөнгө олоод байдаг бол нөгөө нам нь байргүй байдаг ийм нөхцөл байдлыг цааш арилгах ёстой. Монголын төр парламентад суудалтай намууддаа байр гаргаж өгөх хэрэгтэй. Байр буюу өмч хөрөнгө гэдэг нь өрсөлдөөний гол суурь болчихоод байгаа юм. Жишээлбэл, өмчтэй айлын хүүхэд, өмчгүй айлын хүүхэд хоёр нэг бизнест өрсөлдөхөд хэн ялах вэ? Тийм учраас цаашид улс төрийн намуудыг улам сайжруулахын тулд санхүүжилтийг нь шилэн болгож, чөлөөт өрсөлдөөнийг бий болгох учиртай. Дараагийн нэг дурдах асуудал бол төрийн бус байгууллагууд улс төр хийх үү, үгүй юу гэдгийг шийдэх хэрэгтэй юм. Улс төрийн нам нь улс төрөө хийгээд, төрийн бус байгууллага нь иргэний нийгмийн ажлаа хийх хэрэгтэй. Гэтэл улс төрийн зорилготой төрийн бус байгууллага байгуулах явдал байгаад байна. Энэ бол байж болохгүй зүйл юм. Энэ мэтчилэн энэ жил хэд хэдэн томоохон асуудлыг шийдэх нөхцөл байдал бүрдэж байгаа. Тухайлбал, томоохон групп, компаниудаас санхүүжилт авдаггүй байх тогтолцоо руу шилжих, парламентын гишүүдийн гадаадад байгаа хөрөнгийг татах, бизнес дэх оролцоог нь татах гэх мэтээр дурдаж болно. Улс төрийн намыг мөнгөнөөс салгая гэвэл улс төрчдийг нь мөн төрөөс хамааралтай мөнгөнөөс салгах хэрэгтэй. Санхүүжилтээс гадна, институтыг бэхжүүлбэл гэвэл парламентын гишүүний халдашгүй байдал гэдэг асуудлыг бид анхааралдаа авах хэрэгтэй болчихоод байгаа юм. Шүүхээс ял авчихаад улсын их хурлын чуулганд суугаад явж байгаа үзэгдэл дэлхийд ганцхан Монголд л болж байна. Шүүхээс ял сонсчихоод парламентын гишүүний ажлаа хийгээд явдаг тохиолдол өөр улсад байхгүй. Тухайн гишүүн яллагдагчаар татагдахын бол бүрэн эрхийг нь түдгэлзүүлдэг болох ёстой юм. Тусгай эрх, ямба гэдэг зүйлийг халах шаардлагатай. Парламентын гишүүн бол улс төрийн намын том төлөөлөл. Парламентын гишүүн нь намаасаа давсан үйл ажиллагаа явуулахыг хориглох ёстой болж байгаа юм.

Манай улс бол “залуу” нийгэм. Залуучуудад чиглэсэн төлөвлөгөө, тэдний дэмжлэгийг авахад яаж ажиллах вэ?

Улаанбаатар хот бол залуусын хот. Энэ залуучуудыг хөдөө орон нутаг руу явуулна гэхээс илүү Улаанбаатартаа тохь тухтай, ирээдүйдээ итгэлтэй амьдрах тэр хөрсийг нь бид бүрэлдүүлэх юм. Тухайлбал, бид ипотекийн зээлд асар их ач холбогдол өгч байна. Ипотекийн зээлийн төлбөрийг гурав дахин бууруулна. Залуу хүнд хамгийн чухал зүйл бол амьдрах орчин шүү дээ. Энэ нь залуучууддаа зориулсан хот бий болгох цаашдын бодлогын эхлэл болно.

Нөгөөтээгүүр, Ардчилсан намыг залуучуудын нам гэж анх байгуулсан. Залуучууд 1990 онд ардчиллыг хүссэн шүү дээ. Харин ахмад настнууд эсэргүүцсэн. Тийм учраас Монгол Ардын намын хувьд хөгшчүүдийн нам байсан. Харин Ардчилсан нам залуучуудад хандсан, залуучуудыг татах ажил хийхгүй явсаар байгаад өөрийнхөө хүчийг алдаад байгаа юм. Улмаар миний хийх ажил залуучуудыг татах, тэднийг өөрсдийг нь дэвшүүлэхэд чиглэж байна. Залуучууд Ардчилсан намыг дэмжье гэвэл өөрсдөө л дэвших хэрэгтэй. Иймээс ч манай намаас нэр дэвшигчдийн ихэнх нь залуучууд байна гэдэгт эргэлзэхгүй байна. Залуучууд өөрсдөө л ирээдүйн боломжийг бүтээнэ, энэ боломжийг өгөх нь харин ардчилал юм. Товчхондоо, залуучуудад ийм зүйл бүтээж өгнө гэхээс илүү өөрсдийг нь ардчилсан намаас дэвших боломж олгож, улмаар өөрсдөө хүссэн нийгмээ бүтээх орчин нь бүрэлдэж байгаа гэж хэлж болно. Залуучуудад их нээлттэй болж байгаа гэдгээрээ онцлог гэдгийг дахин дурдья.

Ярилцсанд баярлалаа.

ХҮН намын дарга, УИХ-ын гишүүн Т.Доржхандтай хийсэн ярилцлага

Сэтгүүлч О.Ариунбилэг

“ЭНЭ УДААГИЙН СОНГУУЛЬ ХУВЬ ХҮМҮҮСИЙН ГЭХЭЭСЭЭ ИЛҮҮТЭЙ
БОДЛОГЫН ИНСТИТУЦ ХООРОНДЫН ӨРСӨЛДӨӨН БАЙХ БОЛНО”



Сонгуулийн шинэ тогтолцоог та хэрхэн харж байна вэ. Одоо болох парламентын сонгууль танай намын хувьд хэрхэн нөлөөлөх бол?

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг парламентад суудалтай намууд хэлэлцэж, шийдсэн. Гэхдээ бодит байдал дээр яг энэ асуудалд зорин ажиллаж, 21 аймаг, 330 сум, нийслэлийн бүх дүүргээр явсан УИХ-ын гишүүний хувьд яагаад энэ өөрчлөлтийг хийсэн бэ гэдгээ хэлэхгүй бол болохгүй. Монгол Улс ардчилсан нийгэмд шилжээд 30 гаруй жил болсон ч үнэндээ шилжилтээ гүйцэт, сайн хийж чадаагүй. 1992 оны анхны шинэ Үндсэн хуулиар парламентын ардчилсан улс гэж тунхагласан атлаа парламентын засаглалтай ч юм шиг, эс бөгөөс ерөнхийлөгчийн засаглалтай ч юм шиг холимог байдлаар явж иржээ. Сонгуулийн систем нь байнга өөрчлөгддөг, үр дүн нь хоёр намын тогтолцоо руу шахсан, сүүлдээ бүр нэг

намын тогтолцоонд орчихсон. Тэгэхээр “Монгол Улсын хөгжил, ирээдүйд аль нь хэрэгтэй вэ” гэдэг өнцгөөс харсны үндсэн дээр Үндсэн хуульд пропорциональ элемент оруулж болно гэх агуулга бүхий Үндсэн хуулийн цэцийн №01 дүгээр тогтоолыг хуульч Үүрцайхтай хамт анх хийж байлаа. Дараагийн №02 дугаар тогтоолыг “Давхар дээлийг албажуулаа, Үндсэн хуульд ийм ойрхон хугацаанд нэмэлт өөрчлөлт хийж болохгүй” гэж хүн бүхэн шүүмжилж байсан. Үндсэн хуулийн цэцэд 2022 онд энэ асуудлыг гаргаж тавиад, наймдугаар сард нь Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргаж, тэр дүгнэлт дээр үндэслэж процесс эхэлсэн. Энэ маш том ажил болсон юм. Түүнээс ордонд хэдэн хүн ярилцаад, эсвэл эрх баригч намын дарга нь ганцаар шийдчихсэн асуудал огт биш. Энэ өөрчлөлт бол улстөрд олон жил явж буй, улс төрийн инсититуцийг хөгжүүлэх хүсэлтэй хүмүүсийн мөрөөдөл байсан. Энэ тогтолцооны үр дүнд нэг нам, нэг хүн, нэг хэсэг бүлэг хүмүүс биш нийтээрээ хожиж, парламентаараа ардчиллаа бэхжүүлж, геополитикийн өнөөгийн орчинд тусгаар тогтнолоо хамгаалаад явах боломж нь бүрдсэн.

Гэхдээ энэ удаагийн сонгууль танай намд ямар үр дүнг авчирна гэж бодож байна?

Энэ өөрчлөлтийг бид өөрсдөдөө зориулж хийсэн зүйл биш юм. “Манай нам ялах уу, би ялах уу” гэдэг бол 30 дугаар асуудал. Хамгийн гол нь Монгол Улс, нийтээрээ хожих, ялах ёстой юм. Ийм л зорилгоор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн. Үүнийг дагаж батлагдсан УИХ-ын Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хуулийн санаачлагч нь би юм. ХҮН намын хувьд өнгөрсөн хоёр удаагийн сонгуулиар иргэдээс нийт 20 хувийн санал авсан. УИХ-ын 2020 оны сонгуулиар Ардчилсан нам 24%, МАН 45 орчим хувийн санал авсан. Гэтэл МАН парламентын 80 хувийг дангаараа бүрдүүлж, харин Ардчилсан нам 11 суудал, манай нам ганц суудалтай болсон. Энэ нь иргэдийн санал ихээр гээгддэг, парламентад төлөөлөл нь орох боломжгүй сонгуулийн тогтолцоотой холбоотой. Тэгвэл энэ удаагийн сонгуульд тойрог томсож байгаа учир мөнгөний хүчин зүйл багасаж, бодлогын нөлөө өндөрсөж, тойргуудад бодлогоо таниулснаар манай нам багадаа 20-30 хувийн санал авах юм байна гэж тооцоолж байна. Мэдээж бид бодлогоо сайн гаргаад явбал олонх болох боломжтой, зөв тактик стратеги барьвал бидний хувьд маш сайн үр дүнд хүрч, Засгийн эрхийг авна гэсэн хүлээлттэй ажиллаж байна.

Тойргийг томсгож, бүсчилсэн нь сурталчилгааны 17 хоногийн хугацаанд өөрсдийгөө таниулах, таны ярьж буйгаар бодлогоо танилцуулахад хэтэрхий богино хугацаа биш үү?

Одооны энэ тогтолцоог “Танигдсан хүмүүс, эсвэл том намынхан, мөнгөтэй хүмүүст давуу талтай. Залуу, шинэ хүмүүст боломж бага, зардал өндөр, сурталчилгааны хугацаа богино” гэдэг буруу пиар яваад байна. Сонгуулийн систем нь өөр юм аа. Энэ бол “cumulative block voting” гэдэг систем юм. Энэ системд санал засагддаг. Нэг намд нэлэнхүйд нь санал өгнө гэдэг ойлголт байхгүй. Энэ тогтолцоогоор шинэ улс төрийн хүчин, шинэ хүмүүс, эрүүл саруул үзэл бодол парламентад орж ирэх боломж гарч ирсэн. Жишээ нь, 10 мандат дээр сонгогч 10 санал өгнө. Тэгэхээр заавал таньдаг 10 хүндээ өгнө гэдэг ойлголт байхгүй. Манайхан судалгаагүйгээр, таамаглаж яриад байна. Судалгаануудыг эхэлж уншиж, бусад улс оронд энэ систем хэрхэн ажилладаг, ямар онцлогтой, үр дүнтэй систем бэ гэдгийг мэдсэний дараа дүгнэлтээ хийж ярих нь зөв болов уу. Эс тэгвэл буруу мессэжийг их түгээх нь залуу хүмүүсийг нэр дэвшихгүй гэх шийдвэрт хүргэх, мохооход хүргээд байна. ҮАГ-аас хоёр сарын өмнө тойрог томссон учир, нэг тойрогт зарцуулах зардлын дээд хэмжээг 1-1,5 тэрбум төгрөг байна гэж зарлангуут хүмүүс “Өө би яаж ийм их мөнгө зарцуулах вэ” гэж бодоод байгаа юм. Энэ чинь зарцуулж болох хамгийн дээд хэмжээ буюу ийм хэмжээний мөнгийг зарцуулахгүй ч байж болно. Танигдах олон боломж бий, халаасан дахь гар утсаа ч ашиглаж болно.

Тойргийг томсгож, бүсчилсэн шалтгаан нь “Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэхгүй бол хөдөөд хүнгүй болох нь, үр ашиггүй зардал өндөртэй буюу 100 хүүхэдтэй сумын төвд 600 хүүхдийн сургууль барьдаг энэ байдал арилахгүй нь” гэдгийг ХҮН намын хувьд анхнаасаа л хөндсөнтэй холбоотой. МАН-ын гишүүдийг аваад үзвэл 60-70 хувь нь аймгийн засаг дарга нар. Парламентын гишүүд дунд бас нийслэл, дүүрэг, аймгийн засаг дарга нар олон бий. Энэ хүмүүсийн парламентын гишүүн болсон шалтгаан нь дөрвөн жил улсын хөрөнгөөр үнэгүй сурталчилгаа хийгээд, орон нутгийн иргэдийг “өөрийн” болгоод байгаа хэрэг. Тэгвэл энэ удаагийн сонгуулийн тогтолцоогоор нөгөө дөрвөн жил орон нутагтаа ажилласан засаг дарга нарын хувьд бүсийн хэмжээнд танигдах шаардлага тулгарсан.

Нөгөө талдаа энэ сонгуулийн системийн онцлог нь хувь хүн гэхээсээ илүүтэй нам, институцуудын хооронд болох юм. ХҮН намаас олон доктор, профессор, судлаачид, тал талын мэргэжилтнүүд нэр дэвшинэ. ХҮН намд өнөөдрийн байдлаар 160 хүн нэр дэвших сонирхлоо илэрхийлсэн байна. Үүнээс 126-г нь нэр дэвшүүлнэ. Гэтэл эдгээр хүмүүс заавал нийгэмд танигдсан байх албагүй. Ажлаа хийж чадах, мэргэжлийн хүмүүс байгаач л гэж хүсэж байгаа. Танигдах ёстой гол субъект нь ХҮН нам нь. “Би гоё дуулдаг”, “Гоё барилддаг”, “Би гоё инфлүнсер” гээд явах чинь парламентын засаглал биш юм. Улс төрийн нам гэдэг бол үзэл санаа, үнэт зүйлс дээрээ нэгдсэн тов тодорхой мөрийн хөтөлбөртэй, бодлоготой, түүнийг нь авч явах чадвартай хүний нөөцтэй институц. Энэ институц

парламентад орж, ачаагаа үүрч явна шүү дээ. Тэгэхээр энэ удаагийн сонгууль бол институт хоорондын бодлогын өрсөлдөөн болно гэсэн үг.

УАГ-аас дөрөвдүгээр сарын 10-ны өдөр мөрийн хөтөлбөрөө илгээсэн 27 намын бүгдийнх нь хөтөлбөрийг “Засварлах шаардлагатай” гэж үзэн буцаалаа. Шаардлага нь, Монгол Улсын урт хугацааны бодлого Алсын хараа-2050 хөтөлбөрийн үзэл санаатай нийцсэн байх гэв. Ингээд харвал намуудын бодлогын өрсөлдөөн мөрийн хөтөлбөрт тусах боломжтой гэж та бодож байна уу?

Бүгдийг нь буцаасан байна. Тухайлбал, ХҮН намыг гурван заалтаа тодорхой болгооч гэсэн байна. МАН-ыг 60 асуудлаа засварлах ёстой гэх мэдээлэл ирлээ. Хуулиас давсан популист амлалтуудыг нэлээн тусгасан гэсэн үг. Мөрийн хөтөлбөр нээлттэй болох үед сайтар дүн шинжилгээ хийх хэрэгтэй юм. “Алсын хараа 2050” гэдэг бол УИХ-аар батлагдсан Монгол Улсын урт хугацааны хөтөлбөр бөгөөд УИХ-аар батлах үед нь би сонгогдоогүй байсан (Сурв: УИХ-ын 52 дугаар тогтоол 2020 оны тавдугаар сарын 13-нд батлагдсан). УИХ-ын гишүүн болсныхоо дараа энэ асуудалд би шүүмжлэлтэй хандаж байсан. Ардчилсан тогтолцоо, парламентын засаглал гэдэг дөрвөн жилд явуулах бодлогоороо өрсөлддөг, тэр бодлого нь улсынхаа урт хугацааны бодлого дээр үндэслэгдсэн байх ёстой. ХҮН нам 2016 онд “Монгол хүний товчоон 2050” бодлого боловсруулж, ном болгон хэвлүүлсэн. Дараа нь МАН-аас “Алсын хараа 2050” бодлого боловсруулсан. Ардчилсан нам дээр ямар бодлого байгааг сайн мэдэхгүй байна. Гэхдээ би “Монгол хүний товчоон 2050” гэдэг бодлогоо УИХ-аар батлуулчихаад “Үүнийг та бүхэн дага” гэвэл болохгүй биз дээ. Яг л тийм зүйл болоод байгаа бөгөөд энэ бол буруу юм. “Алсын хараа 2050” гэдэг МАН-ын дэвшүүлсэн бодлогот бид уягдах боломж байхгүй. Харин мөрийн хөтөлбөрт байх ёстой шалгуур бол төсвийн шалгуур байх ёстой. Өөрөөр хэлбэл, төсөв нь давж дийлэхгүй популист амлалтуудыг өгөх ёсгүй.

Нэг намын хөтөлбөрт бүгд нийцүүлнэ гэвэл юуных нь парламент, үзэл бодлын ялгаатай байдал байх билээ? ХҮН нам бол бизнесийг дэмждэг, баруун төвийн нам байтал эрх баригч нам зүүн байсан одоо зүүн төвийн социал демократ нам болсон. Энэ тохиолдолд нийгмийн хамгаалал, халамжийн салбаруудыг түлхүү санхүүжүүлнэ, төр том байна гэсэн үзэл санаа л баримталдаг. Төрөөр дамжуулж баялгийг тараана, төрөөр дамжуулж нийгмийн үйлчилгээг хүртээнэ гэдэг. Тэгэхээр ялгаатай үзэл санаануудыг нэг хайрцганд оруулна гэдэг агуулгаараа буруу. Үүнийг би УИХ-ын гишүүн болсон өдрөөсөө ярьсан. Зарчмын асуудал ярихаар хүмүүс ойлгодоггүй. Гэхдээ одоо ийм зүйл яригдаж, ийм асуулт асууж байгаа нь зөв.

Танай нам жагсаалтад орох гишүүддээ ямар шаардлагыг тавьж байгаа вэ?

Энэ асуудлаар Германы Бундестагийн төлөөлөлтэй уулзсан, мөн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг гардаж хийсэн туршлагатай хуульчид болон парламентын гишүүдтэй ч санал солилцлоо. Ингэхэд нэг л зүйл маш хүчтэй сэтгэгдэл төрүүлсэн. “Германы сонгуулийн системд пропорциональ нь 50 хувь гэж заасан нь манай улсын хөгжлийн гарц байсан” гэж ярьсан. ХҮН нам жагсаалтад нэг л шаардлага тавина. Тэр бол популизм ярьдаггүй, популизмын эсрэг зогсож чаддаг тийм л хүнийг сонгоно. Иргэд таалахгүй байсан ч эх орныхоо эрх ашгийн төлөө зогсож чаддаг, зарчмынхаа талд байдаг, гал барьдаг ийм л улс төрчдийг би оруулна. ХҮН намын жагсаалт бол иргэдийн маш их хүсэн хүлээсэн жагсаалт байх болно. Бид хоёр жилийн хугацаанд хөдөө орон нутгаар иргэдтэй уулзаж явлаа. Иргэдийн хамгийн их асуусан асуулт бол “Хөөгөөд гаргахаар тооноор ороод ирдэг ийм системийг та яагаад дэмжээд байгаа юм бэ”, эсвэл “Намын даргын эргэн тойронд байдаг эсвэл хамгийн их мөнгөтэй, нөлөөтэй хүмүүс л ордог юм биш үү” гэх нь ч байсан. Жагсаалтад орох хүмүүсээ би бүгдийг нь ил зарлана, худлаа хэлж хулгай хийсэн хүмүүс орохгүй, мэргэжлийн хүмүүс л орно.

Жагсаалтаар нэр дэвшиж байгаа хүмүүсээс танай нам дэнчин авах уу?

Дэвшихийн тулд дэнчин авна гэж зүйл манай намд байхгүй. Үүнийг хуулиар хориглосон. Энэ удаагийн хуулийн зохицуулалтын нэг онцлог нь жагсаалтаар нэр дэвшсэн ч тойргоос нэр дэвшигчтэй ижил хэмжээний санхүүгийн хариуцлага үүрнэ гэсэн заалт орсон. УИХ-ын 2012 оны сонгуулиар сонгогдсон 76 гишүүний 28 нь жагсаалтынх байсан. Үүнээс үүдэлтэй нэг зовлон үүссэн нь “Оймсныхон” гэх зэргээр нөгөө гишүүдээ ялгаварласан. Яагаад гэхээр, жагсаалтынхан мөнгө төлдөггүй, намын даргад ойрхон эсвэл асар их мөнгөтэй хүмүүс орчихсон. Гэтэл тойрогт өрсөлдөж сонгогдсон хүмүүс нь зардлаа гаргаад, иргэдтэй нүүр тулж уулзаад, эрсдэл үүрсэн байдаг. Тэгэхээр энэ ялгааг арилгахын тулд өмнө дурьдсан хуулийн зохицуулалт орсон. ХҮН намын хувьд хуулийн хүрээнд тойрогт өрсөлдөх хүмүүс ийм хэмжээний зардал гаргаж байгаа бол, та бас энэ хэмжээний зардлыг гаргаад оролцоод яв гэдэг шаардлагыг л тавих байх.

Энэ сэдвээр Монгол Ардын Намын даргаас ярилцлага авах хүсэлт тавьсан ч харамсалтай нь тодорхой хариу аваагүй болно.

